




---

# МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

---

2013  
X сар  
№2



---

**МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫН ТАЙЛАН**

---

Дугаар №2

Улаанбаатар хот  
2013 оны 10 дугаар сар



*Энэхүү тайланг боловсруулахад хариуцсан чиглэлээр материал ирүүлэн,  
хамтран ажилласан Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны  
холбогдох газрууд болон тайланг хянан тохиолдуулж, санал шүүмж өгсөн  
Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх, Ерөнхий эдийн засагч С.Болдод  
талархал илэрхийлье.*

**НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН  
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	8
ТОЙМ	10
<b>1. МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН</b>	<b>13</b>
<b>1.1 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тойм</b>	<b>13</b>
• Дэлхийн эдийн засаг	13
• Дэлхийн санхүүгийн зах зээл	16
<b>1.2 Монгол Улсын макро эдийн засгийн тойм</b>	<b>20</b>
• Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал	20
• Гадаад сектор	24
• Бодит сектор	29
• Мөнгө санхүүгийн сектор	30
• Улсын төсөв	34
<b>2. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА</b>	<b>41</b>
<b>2.1 Санхүүгийн салбарын төлөв байдал</b>	<b>41</b>
• Банкны салбар	41
• Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо	44
• Хөрөнгийн зах зээл	49
• Даатгалын байгууллага	53
• Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	61
• Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа	62
<b>2.2 Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт</b>	<b>63</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД</b>	<b>66</b>
<b>3.1 Гадаад секторын эрсдэлүүд</b>	<b>66</b>
<b>3.2 Санхүүгийн салбарын эмзэг байдал</b>	<b>70</b>
• Банкны салбарын эмзэг байдал	70
• Бусад санхүүгийн байгууллагын эмзэг байдал	72
<b>3.3 Салбаруудын зээл, түүний эрсдэл</b>	<b>73</b>
<b>4. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ</b>	<b>79</b>
<b>4.1 Хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт</b>	<b>79</b>
<b>4.2 Төлбөр тооцоо, хөрөнгийн бүртгэлийн систем</b>	<b>85</b>
<b>4.3 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа</b>	<b>89</b>

**ШИГТГЭЭНҮҮД**

<b>Шигтгээ 1:</b>	Монгол Улсын нүүрсний зах зээл	27
<b>Шигтгээ 2:</b>	Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр	32

**ДҮРСЛЭЛҮҮД**

<b>Дүрслэл 1.1</b>	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	13
<b>Дүрслэл 1.2</b>	АНУ-ын зарим голлох үзүүлэлтүүд	14
<b>Дүрслэл 1.3</b>	Ажилгүйдлийн түвшин	14
<b>Дүрслэл 1.4</b>	БНХАУ-ын экспорт, импортын жилийн өсөлт	15
<b>Дүрслэл 1.5</b>	Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ	15
<b>Дүрслэл 1.6</b>	Евро-бүсийн зарим орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж	16
<b>Дүрслэл 1.7</b>	Зарим хөрөнгийн захын индекс	17
<b>Дүрслэл 1.8</b>	Хөгжингүй орнуудын төв банкны актив болон ДНБ-ий харьцаа	18
<b>Дүрслэл 1.9</b>	Зарим Төв банкуудын мөнгөний бодлогын хүүний түвшин	18
<b>Дүрслэл 1.10</b>	Алт, зэсийн үнэ болон ам.долларын ханшийн индекс	18
<b>Дүрслэл 1.11</b>	Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш	19
<b>Дүрслэл 1.12</b>	АНУ-ын ажилгүйдлийн түвшин, мөнгөний бодлогын хүү	19
<b>Дүрслэл 1.13</b>	Монгол Улсын нийт экспорт	20
<b>Дүрслэл 1.14</b>	Гадаад худалдааны нөхцөлийн индекс	21
<b>Дүрслэл 1.15</b>	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)	22
<b>Дүрслэл 1.16</b>	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)	22
<b>Дүрслэл 1.17</b>	Инфляцийн задаргаа	23
<b>Дүрслэл 1.18</b>	Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл	24
<b>Дүрслэл 1.19</b>	Хөрөнгө санхүүгийн дансны бүтэц	24
<b>Дүрслэл 1.20</b>	Урсгал тэнцлийн бүтэц	25
<b>Дүрслэл 1.21</b>	Урсгал тэнцлийн санхүүжилт	25
<b>Дүрслэл 1.22</b>	Улс орнуудын Засгийн газрын нийт өр-ДНБ-ий харьцааны тархалт	25
<b>Дүрслэл 1.23</b>	Гадаад валютын улсын нөөц	26
<b>Дүрслэл 1.24</b>	Аж үйлдвэрлэл болон нийт экспортод эзлэх нүүрсний хувь хэмжээ	27
<b>Дүрслэл 1.25</b>	Нүүрсний үйлдвэрлэл, экспорт, хэрэглээ	28
<b>Дүрслэл 1.26</b>	Хятад улсын коксжих нүүрсний импортод эзлэх хувийн жин ба экспортын дундаж үнэ, улсуудаар	28
<b>Дүрслэл 1.27</b>	Эдийн засгийн өсөлтийн задаргаа	29
<b>Дүрслэл 1.28</b>	M2 мөнгөний бүтэц	30
<b>Дүрслэл 1.29</b>	M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа	30
<b>Дүрслэл 1.30</b>	Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага	30
<b>Дүрслэл 1.31</b>	Банкуудын хадгаламж болон зээлийн хүү	31
<b>Дүрслэл 1.32</b>	Банк хоорондын захын хүү	31
<b>Дүрслэл 1.33</b>	Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал	31
<b>Дүрслэл 1.34</b>	Нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь	36

Дүрслэл 1.35	Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл	37
Дүрслэл 1.36	Бодит ДНБ-ий жилийн өсөлт ба эхний 8 сараарх импортын жилийн өсөлт	38
Дүрслэл 1.37	Төсвийн зарлага, түүхий эдийн үнийн корреляци ба нийт төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь	38
Дүрслэл 1.38	Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ ба БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ	39
Дүрслэл 1.39	Нийт зарлага ба бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн индекс (CRB)-ийн жилийн өсөлт	39
Дүрслэл 2.1	Банкны салбарын нийт актив	41
Дүрслэл 2.2	Банкны салбарын зээл	42
Дүрслэл 2.3	Банкны салбарын харилцах, хадгаламж	43
Дүрслэл 2.4	Хадгаламжийн байгууллагуудын актив, пассивт гарсан өөрчлөлт	43
Дүрслэл 2.5	Бүртгэлтэй Банк бус санхүүгийн байгууллагын тоо	44
Дүрслэл 2.6	Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц	45
Дүрслэл 2.7	Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар	45
Дүрслэл 2.8	Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо	48
Дүрслэл 2.9	Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар	49
Дүрслэл 2.10	Монголын хөрөнгийн биржийн арилжааны дүн болон хэлцлийн тоо	50
Дүрслэл 2.11	ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ	50
Дүрслэл 2.12	Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын тоо	51
Дүрслэл 2.13	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт	52
Дүрслэл 2.14	Хувьцаат компаниудын ногдол ашиг хуваарилалт	53
Дүрслэл 2.15	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	54
Дүрслэл 2.16	Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч	55
Дүрслэл 2.17	Даатгалын хураамж ба нөхөн төлбөрийн харьцаа	56
Дүрслэл 2.18	Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого	56
Дүрслэл 2.19	Даатгалын компаниудын нөхөн олговрын түвшин ба ашигт ажиллагаа	57
Дүрслэл 2.20	Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг/алдагдал	57
Дүрслэл 2.21	Даатгалын нөөц сан	57
Дүрслэл 2.22	Давхар даатгалын хураамж	58
Дүрслэл 2.23	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зарим статистик мэдээлэл	58
Дүрслэл 2.24	Урт хугацааны даатгалын орлого, давхар даатгал, нөхөн төлбөр, ашигт ажиллагаа, нөөц сан	61
Дүрслэл 2.25	Макро зохистой бодлогын хэрэгслийн хэрэглээ	65
Дүрслэл 3.1	Зарим улсуудын нэрлэсэн үйлчилж буй ханш ба эрдэс, түүхий эдийн үнийн индексийн өөрчлөлт	66
Дүрслэл 3.2	Нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн чангаралт	66
Дүрслэл 3.3	Нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн хэлбэлзэл	67

Дүрслэл 3.4	Бодит ханшийн тэнцвэрт түвшний үнэлгээ	67
Дүрслэл 3.5	Монгол Улсын уул уурхайн индекс	68
Дүрслэл 3.6	Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын компаниудын олон улсын бирж дэх хувьцааны үнэ	69
Дүрслэл 3.7	Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын компаниудын олон улсын бирж дэх хувьцааны үнэ	69
Дүрслэл 3.8	Херфиндалын индекс	70
Дүрслэл 3.9	Төвлөрлийн харьцаа	70
Дүрслэл 3.10	Стресс тест	71
Дүрслэл 3.11	Зээлийн өсөлтийн хувь (салбараар)	73
Дүрслэл 3.12	Чанаргүй зээлийн хувь (салбараар)	73
Дүрслэл 3.13	Зээлийн жилийн өсөлтийн хувь (төрлөөр)	73
Дүрслэл 3.14	Салбаруудын зээлийн нийт зээлд эзлэх хувь	74
Дүрслэл 3.15	Гадаад валютын зээл	74
Дүрслэл 3.16	Өрхийн орлого, зарлагын харьцаа	74
Дүрслэл 3.17	Иргэд, жижиг, дунд аж ахуй эрхлэгчдэд олгосон зээлийн жилийн өөрчлөлт	75
Дүрслэл 3.18	Иргэд, жижиг, дунд аж ахуй эрхлэгчдэд олгосон зээлийн жилийн өөрчлөлт	75
Дүрслэл 3.19	Өрхийн өр, орлогын харьцаа	76
Дүрслэл 3.20	Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү	76
Дүрслэл 3.21	Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа	76
Дүрслэл 3.22	Орон сууцны үнийн жилийн өөрчлөлт	77
Дүрслэл 3.23	Хувийн салбарын зээлийн үлдэгдлийн өсөлт, бодит үйлдвэрлэлийн өсөлт	77
Дүрслэл 4.1	Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	85
Дүрслэл 4.2	Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	86

## ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1.1	Их-7 орнуудын зээлжих зэрэглэл	17
Хүснэгт 1.2	Монгол Улсын нийт гадаад өр	26
Хүснэгт 1.3	Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд	29
Хүснэгт 1.4	2013 оны эхний хагасын ДНБ-ий өсөлт (салбаруудаар)	29
Хүснэгт 1.5	Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн санхүүжилт	32
Хүснэгт 1.6	Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл	34
Хүснэгт 1.7	Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (бүрэлдэхүүнээр)	34
Хүснэгт 1.8	Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл	35
Хүснэгт 1.9	2013 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл	37
Хүснэгт 2.1	Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд	44
Хүснэгт 2.2	Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	45



<b>Хүснэгт 2.3</b>	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	46
<b>Хүснэгт 2.4</b>	Орлого, зарлага, ашигт ажиллагаа	47
<b>Хүснэгт 2.5</b>	Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик	48
<b>Хүснэгт 2.6</b>	Хадгаламж, зээлийн хоршоодын салбарын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	49
<b>Хүснэгт 2.7</b>	Үнэт цаас төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд нээгдсэн дансдын мэдээлэл	51
<b>Хүснэгт 2.8</b>	Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	53
<b>Хүснэгт 2.9</b>	Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө	54
<b>Хүснэгт 2.10</b>	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	54
<b>Хүснэгт 2.11</b>	Даатгалын хураамжийн орлого (бүтээгдэхүүнээр)	55
<b>Хүснэгт 2.12</b>	Даатгалын нөхөн төлбөр	56
<b>Хүснэгт 2.13</b>	Давхар даатгалын хураамж	58
<b>Хүснэгт 2.14</b>	Компаниудын хураамжийн орлого	59
<b>Хүснэгт 2.15</b>	Компаниудын хохирол үнэлгээний орлого	59
<b>Хүснэгт 2.16</b>	Эзэмшигчдийн өмч	60
<b>Хүснэгт 2.17</b>	Даатгалын хураамжийн орлого, компаниудаар	60
<b>Хүснэгт 2.18</b>	Ердийн даатгалын нөхөн төлбөр	60
<b>Хүснэгт 2.19</b>	Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн үнэ	62

## ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн анхны дугаарыг гаргаж, олон нийтэд мэдээлэх, цаашид хагас жил тутам гаргах ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан – 2012” буюу анхны дугаарыг нэгтгэн боловсруулж, нийтийн хүртээл болгоод байгаа билээ.

Энэ удаа “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн хоёрдахь дугаарыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс та бүхэнд өргөн барьж байна.

Дэлхий нийтийг хамарсан даяарчлалын нөлөөгөөр улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа өргөжин тэлж, санхүүгийн салбарын бодит эдийн засагт гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө нь улам бүр өсөн нэмэгдэн, түүнийг дагасан өөрчлөлт, шинэчлэлт нь санхүүгийн зах зээлд хөгжил дэвшил авчирч, зах зээлд оролцогчдод өргөн боломжийг нээхийн зэрэгцээ санхүүгийн системийн эмзэг байдал, эрсдэл ч бас өсч байна. 2008 оноос эхлэн үргэлжилж буй дэлхийн нийтийг хамарсан санхүүгийн системийн хямралт нөхцөл байдал нь дээрхийн тод жишээ бөгөөд цар хүрээгээ хурдацтай тэлж буй санхүүгийн салбарт тодорхой хяналт, зохицуулалт, түүний тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого зайлшгүй шаардлагатай болохыг харуулсан.

Монгол Улсын хувьд санхүүгийн системийн 95 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж, санхүүгийн зах зээл нь хөгжлийнхөө эхэн үедээ байна. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудалд дан ганц мөнгөний бодлого, банкны салбарыг тойрсон асуудлаар хандах бус, санхүүгийн дэд салбарууд дахь тэнцвэртэй хөгжил, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн үр ашигтай, харилцан уялдаатай макро болон микро түвшний бодлогууд, нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилттой уялдсан санхүүгийн институци, дэд бүтцийн оновчтой, шат дараалсан реформ, олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголт, суурь мэдлэг, төлөвшилийг бүхэлд нь авч үзэх нь зүйн хэрэг юм. Дэлхий нийтэд ч энэ хандлага хүрээгээ тэлж байна.

Мэдээллийн эрин зууны хөгжлийг дагаад санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээний үр дүн нь мэдээллийн талаар баримтлах бодлогоос ихээхэн хамаарч байна. Иймд мэдээллийн талаар баримтлах бодлогын хүрээнд олон нийтийн санхүүгийн салбарын талаарх суурь мэдлэгийг гүнзгийрүүлэх, үнэн зөв мэдээллийг нийтэд тэгш, цаг тухайд нь хүргэж, бодит хүлээлтийг төлөвшүүлэх нь санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Дээрх зорилтын хүрээнд “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г албан ёсоор гаргаж буй

төв банкуудын тоо<sup>1</sup>, түүнд өгөх ач холбогдол жил ирэх бүр өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд Монгол Улсын хувьд ч “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол гаргах, түүгээр дамжуулан нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх олон нийтийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээд байгаа билээ.

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн эхний хоёр дугаарт мэдээллийн цар хүрээ өргөн байх, санхүүгийн салбарын нөхцөл байдалд үнэн зөв баримтад үндэслэсэн бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх зарчмыг бид баримталсан болно.

Цаашид “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн агуулгыг олон улсын жишигт илүүтэй нийцүүлэх, өөрийн орны онцлог, хэрэгцээ шаардлагыг тусгах зарчим баримтлах болно. Үүнд уншигч таны оролцоо, хувь нэмэр ихээхэн үнэ цэнэтэй тул энэхүү тайлантай холбогдох саналаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хаяглан, [fsc@mongolbank.mn](mailto:fsc@mongolbank.mn) цахим шуудангаар ирүүлнэ үү. Бид таны саналыг хүлээж авахдаа үргэлж таатай байх болно.

---

<sup>1</sup> 2011 оны байдлаар дэлхийн 80 гаруй орны төв банк “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол гаргаж байгаа гэсэн статистик бий (Эх сурвалж: IMF working paper WP/12/1).

## ТОЙМ

2012 оны эхэн үед судлаачид дэлхийн эдийн засаг 2013 онд сэргэж, өмнөх оноос өндөр өсөлттэй байна хэмээн төсөөлж байсан боловч энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн бодит өсөлт болон бусад голлох үзүүлэлтүүд хүлээлтээс ихээхэн доогуур гүйцэтгэлтэй гарснаас шалтгаалж, өсөлтийн талаарх дараа оны төсөөллүүд дарааллан буурсаар ирлээ. Гэхдээ бүс нутаг, улс орон бүр дэх нөхцөл байдал ихээхэн ялгаатай байгаа юм. Тухайлбал, АНУ-д ажилгүйдэл алгуур боловч тасралтгүй буурч, эдийн засгийн идэвхжилд сэргэлт ажиглагдаж эхэлсэн бол Евро бүсийн санхүүгийн зах зээл харьцангуй тогтворжсон хэдий ч, бодит эдийн засагт зэрэг хандлага төдийлөн харагдахгүй байна. Хятадын эдийн засгийн өсөлт удааширч, 2009 оны хямралын үеийг эс тооцвол сүүлийн 10 жилийн хугацаан дахь хамгийн бага өсөлт үзүүлж эхэлсэн бол гадаад нөхцөл муудсанаас шалтгаалан урсгал тэнцлийн алдагдалтай болон түүхий эд экспортлогч орнуудын төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ Япон улс эдийн засгаа дэмжих зорилгоор мөнгөний зөөлөн бодлого (QQE) хэрэгжүүлж, зохих үр дүнд хүрч байгаа юм.

Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч буй нөхцөлд санхүүгийн зах зээл дэх огцом хэлбэлзэл буурч, хөрөнгийн захуудад сэргэлт ажиглагдаж ирсний гол нөлөөлөгч хүч нь хөгжингүй орнуудад эдийн засгаа дэмжих зорилгоор авч хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлогын арга хэмжээнүүд байсаар байна. АНУ-ын ажилгүйдэл буурч, эдийн засагт нь сэргэлт ажиглагдаж байгаагаар уялдан Холбооны нөөцийн банкнаас

хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын төлөв өөрчлөгдөж магадгүй гэсэн хүлээлт бий болсон нь хөрөнгө оруулагчид бүрэлдэж буй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудад хийж буй хөрөнгө оруулалтаа хумих, хөрөнгөө эргүүлэн татах зэрэг үзэгдэл идэвхжихэд нөлөөлсөн бөгөөд тэдгээр орнуудын активын үнэ, валютын ханшид дарамт үзүүлэхийн зэрэгцээ өрийн дарамтыг нэмэгдүүлэх, санхүүгийн салбар дахь чанаргүй активыг өсгөх зэрэг сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн байна. Тухайлбал, 2013 оны эхний 8 сарын байдлаар нэрлэсэн үйлчилж буй ханш уул уурхайн эрдэс, түүхий эд экспортлогч орон Австралид 11.4 хувь, Канадад 4 хувь, Бразилд 8.3 хувь, Өмнөд Африкт 12.4 хувь, Чилид 4.1 хувиар тус тус суларчээ. Энэ хугацаанд төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 9.5 хувиар суларсан үзүүлэлттэй байна.

Хэдийгээр хөгжингүй орнууд дахь мөнгөний бодлогын төлөвт өөрчлөлт гараагүй байгаа ч, цаашдаа тэдгээр орнуудын эдийн засагт сэргэлт бий болох, мөнгөний тэлэлтийг зогсоох, улмаар мөнгөний бодлогыг хатууруулсан нөхцөлд валютын урсгалтай холбоотой гадаад эрсдэл хүлээгдэж байгаа гэдгийг сануулсан явдал байв. Монгол Улсын эдийн засагт ч дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн сөрөг нөлөө нь гадаад худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын сувгаар 2012-2013 онуудад хүчтэй нөлөө үзүүлсэн.

Монгол Улсын экспорт 2012 онд 8.3 хувь, 2013 оны эхний хагас жилийн байдлаар 10.5 хувиар буурсан бол гадаадын шууд хөрөнгө

оруулалт цэвэр дүнгээр 2012 онд 4.6 хувиар, 2013 оны эхний хагас жилийн байдлаар 41.9 хувиар тус тус татраад байна. Монгол Улсын эдийн засагт болзошгүй хямралын бодитой эрсдэл 2012 онд нүүрлэсэн үед Засгийн газраас олон улсын санхүүгийн зах зээлд бонд гаргаж, дотоодын санхүүгийн систем дэх гадаад активыг нэмэгдүүлсэн, Монголбанкнаас эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах цогц бодлого хэрэгжүүлж, энэ хүрээнд: (i) “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх, (ii) банкны салбарыг хамгаалах, Санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкуудыг шаардлагатай эх үүсвэрээр дэмжих, (iii) эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих, өрх гэр, үндэсний хэмжээнд хуримтлалыг урамшуулах шат дараатай арга хэмжээг хэрэгжүүллээ. Эдгээр нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах, санхүүгийн салбарт үүсч болзошгүй байсан зээлийн тасалдлаас сэргийлэх, ДНБ-ий бодит өсөлтийг тогтворжуулан хоёр оронтой тоонд хадгалах, ажлын байрыг хамгаалах, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүү, эдийн засгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх бодлогын арга хэмжээ болсон юм.

Монгол Улсын эдийн засаг дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан 2009 онд 1.3 хувиар буурсныг эс тооцвол 2006 оноос хойш дунджаар 10.6 хувиар өсч иржээ. Харин 2011 онд 17.5 хувиар, 2012 онд 12.4 хувиар өссөн бол 2013 оны эхний 3 улирлын байдлаар 11.5 хувиар өсөөд байгаа нь олон жилийн дунджаас өндөр хэвээр байна.

Эдийн засгийн өсөлтийн бүтцийг харвал Монголбанкнаас хэрэгжүүлсэн хөтөлбөрт хамрагдсан салбаруудад өндөр өсөлт гарсан

нь өсөлтийг ийнхүү өндөр түвшинд хадгалах суурь нөхцөл болжээ.

Хэдийгээр Монголбанк мөчлөг сөрсөн мөнгөний бодлогоор бодит секторын идэвхжилийг дэмжиж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх шат дараалсан арга хэмжээ авч байгаа ч, мөнгөний уламжлалт бус бодлогын цаашдын хэрэгжилт, цар хүрээ нь гадаад цэвэр актив хэрхэн нэмэгдэхээс ихээхэн хамаарахаар байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2013 онд төлөвлөсөн хэмжээнээс 1.5 их наяд төгрөгөөр буурах төлөвтэй байсан тул төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 799.2 тэрбум, зарлагыг 814.8 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж тодотгол хийсэн. Гадаад эдийн засгийн тааламжгүй нөхцөл, экспортын орлого буурсан, гадаад худалдааны эргэлт багассан нөхцөл байдал нь төсвийн орлого тасрах гол шалтгаан болсны зэрэгцээ анхнаасаа төсвийн орлогын төлөвлөлтийг хэт өөдрөг хийсэн нь төсвийн орлого төлөвлөснөөс буурахад мөн нөлөөлөв. Гэхдээ энэ оноос Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бүрэн агуулгаараа хэрэгжиж эхэлсэн нь санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин төсвөөс гадуурх хөрөнгө оруулалтын үр ашиг, зарцуулалт дахь хяналтыг сайжруулах, урт хугацаанд өрийн тогтвортой байдалтай нийцүүлэх чиглэлээр хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай юм.

Гадаад эдийн засгийн орчин 2013 онд үргэлжлэн муудсан хэдий ч, улсын өрийн дарамт болон гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээ зэрэг голлох индикаторууд олон улсын жишиг түвшинтэй нийцтэй байна. Мөн гадаад орчны дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулах, эдийн засагт зайлшгүй шаардлагатай тохиргоог хийх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд

валютын ханшийн уян хатан байдал нь чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд банкуудад байршуулсан эх үүсвэр нь зээл, харилцах, хадгаламж зэрэг мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлтийг тогтворжуулах, улмаар дэмжих гол хүчин зүйл болсон. Тухайлбал, уул уурхайн салбарт олгосон зээл бууралттай байгаа бол уул уурхайн бус салбарууд, тэр дундаа Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлогын нөлөөгөөр барилга, үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуй, тээвэр ба агуулахын аж ахуй зэрэг салбаруудад зээлийн өсөлт тогтворжиж сэргэх, улмаар эдгээр салбарын ДНБ-ий бодит өсөлтөд үзүүлэх хувь нэмэр өндөр болж байна.

Монголбанкнаас 2013 оны 1, 2, 3, 5 дугаар саруудад банкуудад эх үүсвэр байршуулсан, банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 2012 оны 6 дугаар сараас 2013 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд системийн нөлөө бүхий банкуудад үе шаттайгаар нэмэгдүүлэн, 12-оос 14 хувьд хүргэхээр шийдвэрлэсэн, 2013 оны 5 дугаар сард бүх банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж 16 тэрбум төгрөг болгосон зэрэг нь банкны салбарын төлбөрийн чадварыг сайжруулж, системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах чадавхийг дээшлүүлэхэд эергээр нөлөөллөө.

Санхүүгийн систем банкны салбарт суурилж буй хэдий ч, иргэдийн багагүй хэсэг нь банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж байгаатай уялдан тэдгээр байгууллагын үйл ажиллагаа ойрын жилүүдэд эрчимтэй идэвхжих хандлагатай байна. Тухайлбал, 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт бүртгэлтэй 229 Банк бус санхүүгийн байгууллага, 142 Хадгаламж зээлийн хоршоо, 94 Брокер диллерийн байгууллага, 17 Даатгалын компани, 326 Хувьцаат компани

үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж, үйл ажиллагааных нь цар хүрээ тэлж байна.

Санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц болох төлбөр тооцооны системийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж байгаа бөгөөд Монголбанкнаас санаачлан боловсруулсан “Монгол Улсын төлбөр тооцооны системийг хөгжүүлэх дунд хугацааны (2009-2014) стратеги”-ийг Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар батлуулаад байна. Мөн санхүүгийн салбарыг тэнцвэртэй хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг урамшуулах, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох зорилгоор хууль, эрх зүйн орчинг шинэчлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, 2013 оны 5 дугаар сард “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг, 2013 оны 10 дугаар сард “Хөрөнгө оруулалтын тухай”, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай” хуулиудыг тус тус баталлаа.

2013 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Зөвлөл) 2 дугаар сарын 19, 9 дүгээр сарын 25, 10 дугаар сарын 4-ний өдөр тус тус хуралдсан. Эдгээр хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих хөтөлбөр”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотойгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төсөл, Зөвлөлийн ажиллах дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар үйл ажиллагааг төлөвшүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт, зохих шийдвэрийг гаргаад байна.

# 1

## МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН


### 1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

#### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Судлаачид 2012 оны эцэс, 2013 оны эхний саруудад дэлхийн эдийн засаг энэ онд сэргэж 2012 онтой харьцуулахад өндөр өсөлттэй гарна хэмээн таамаглаж байсан хэдий ч 2013 оны эхний хагас жилийн байдлаар дэлхийн эдийн засгийн төлөв төдийлөн сайжрахааргүй байна. Үүний шалтгаан нь хэдийгээр АНУ-ын эдийн засгийн төлөв 2013 онд ялимгүй сэргэж байгаа ч, Евро бүсийн байдал сайжрахгүй, нөхцөл байдал хэр зэрэг удаан үргэлжлэх нь тодорхой бус байгаа нь бүрэлдэж буй эдийн засагтай орнууд (ЕМ) болон хөгжиж буй орнуудын төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж, эдгээр орнуудын эрсдэлийг нэмэгдүүлсэн нь дэлхийн эдийн засгийн ерөнхий төлөвт сөргөөр нөлөөлж байгаа юм.

#### Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook)” тайлан, 2013 оны 7 дугаар сар.

АНУ-ын эдийн засаг 2012 онд 2.2 хувийн өсөлттэй байсан бол судлаачид энэ оны эхэнд 1.5-2.1 орчим хувийн өсөлттэй байна хэмээн таамаглаж байлаа. 2013 оны эхэнд “Бушийн татварын хөнгөлөлт”-ийн хугацаа дуусах, төсвийн зардлыг танах зэрэг ажлууд хийгдэхээр байсан нь эдийн засагт тодорхой бус байдлыг бий болгож, бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалтын шийдвэрээ хойшлуулах, хэрэглэгчид хэрэглээгээ бууруулснаар эдийн засгийн бодит өсөлт 1.5 хувь хүртэл буурах эрсдэлтэй хэмээн шинжээчид үзэж байв. Харин энэ оны эхний улиралд бага, дунд орлоготой иргэдэд татварын хөнгөлөлтийг хэвээр үлдээж, төсвийн зардлын өөрчлөлтийг энэ оны 9 дүгээр сар хүртэл хойшлуулсан нь дээрх сөрөг нөлөөг саармагжуулсан үйлдэл болсон. Үүний зэрэгцээ Холбооны нөөцийн банк ажилгүйдлийн түвшинг 6.5 хувь болж буурах хүртэл сар бүр 85 тэрбум ам.долларын бонд, үнэт цаас худалдан авч байгаа нь санхүүгийн салбарыг тогтворжуулж, шинэ хөрөнгө оруулалт хийгдэх, шинээр ажлын байр бий болгохыг дэмжсэн чухал алхам болж байна. Ингэснээр оны эхэнд 7.9 хувь байсан ажилгүйдлийн түвшин тогтмол буурсаар 7 дугаар сарын байдлаар 7.4 хувьд хүрч, сар бүр 200 мянган ажлын байр шинээр бий болж байна. Эдийн засгийн өсөлт 2013 оны I, II улиралд тус тус 1.1, 1.7 хувь (@SAAR) байсан бол 2013 онд дунджаар 1.9 хувиар өснө хэмээн шинжээчид таамаглаж

байна. Сүүлийн үед АНУ-ын Холбооны нөөцийн банкнийг бонд, үнэт цаас тогтмол худалдан авах арга хэмжээгээ хязгаарлана гэсэн хүлээлт бий болсон хэдий ч, тус банкнаас худалдан авах бонд, үнэт цаасны хэмжээг хязгаарлах тохиромжтой нөхцөл хараахан бүрдээгүй байна гэж үзсэн.

### Дүрслэл 1.2

АНУ-ын зарим голлох үзүүлэлтүүд




Эх сурвалж: Trading economics.

Евро бүсийн эдийн засаг 2012 онд 0.6 хувиар унаж, хямралын доод цэгтээ хүрсэн тул 2013 онд хямралаас гарах явцдаа орно хэмээн шинжээчид таамаглаж байсан ч, 2013 онд нөхцөл байдал дээрдэхээргүй байгаа юм. Грекийн өрийн хямралаас үүдэлтэй Евро бүсийн хямрал нь банк санхүү, төсвийн хямрал болж гүнзгийрээд байна. Иймд Европын төв банкнаас өрийн хямралтай байгаа Грек, Португаль, Ирланд, Итали, Кипр зэрэг орнуудын засгийн газрын бондыг хязгааргүй хэмжээгээр худалдан авахад бэлэн гэдгээ зарлаж, мөнгөний бодлогын хүүг 0.5 хувь болгон бууруулсны зэрэгцээ ОУВС, Европын комисс, Европын төв банкны зүгээс төсвийн зардлыг огцом бууруулах хатуу нөхцөлтэйгээр дээрх орнуудад санхүүгийн туслалцаа үзүүлэхээр болсон. Энэхүү арга хэмжээ нь санхүүгийн зах зээлийг тогтворжуулж, Евро бүсийн орнуудад хямд өртгөөр хөрөнгө босгох боломж олгож байгаа

хэдий ч, үүний хариуд төсвийн хатуу сахилга бат шаардагдаж байгаагаас цалин, тэтгэвэр тэтгэмж буурах, ажилгүйдэл нэмэгдэх, дотоод эрэлт багасах зэрэг сөрөг нөлөөллүүд гарч байна. Үүний зэрэгцээ банкны салбарт олгож байгаа санхүүгийн нэмэлт эх үүсвэр нь эргээд бодит секторт зээл болж гарахгүй байгаагаас шалтгаалан Евро бүсийн эдийн засаг хангалттай сэргэж чадахгүй байгаа юм.

### Дүрслэл 1.3

Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook)” тайлан, 2013 оны 4 дүгээр сар.

Евро бүсийн жижиг орнуудад ажилгүйдлийн түвшин энэ оны 6 дугаар сарын байдлаар 11 хувьд хүрч, эдийн засаг нь 2013 оны I, II улиралд 0.6, 0.3 хувь (@SAAR)-иар тус тус буурсан байна. Европын төв банкны хэрэгжүүлж буй бодлого нь Евро бүсийн эрх баригчдад хямралын эсрэг нэгдсэн арга хэмжээ авах, төсвийн хатуу сахилга баттай болох, улс төрийн нэгдсэн зөвшилцөлд хүрэхэд цаг хугацаа, боломж олгож байгаа бөгөөд цаашид цаг алдалгүй оновчтой арга хэмжээ авч чадсан тохиолдолд Евро бүсийн эдийн засаг 2014 оноос эргээд сэргэнэ хэмээн эдийн засагчид үзэж байна.


2012 оны IV улиралд 7.9 хувийн өсөлттэй байсан Хятадын эдийн засаг 2013 оны I, II улиралд харгалзан 7.7, 7.5 хувийн өсөлттэй



болж саарчээ. Хятадын албан ёсны статистик мэдээнд аж үйлдвэрлэлийн жилийн өсөлт 2013 оны 1, 2 дугаар сард 9.9 хувь байсан бол 6 дугаар сарын байдлаар 8.9 хувь болж бага зэрэг саарсан байна. Оны эхэнд өндөр түвшинд байсан экспортын жилийн өсөлт 6 дугаар сард сөрөг утгатай болсон хэдий ч, 7 дугаар сараас эхлэн эерэг утгатай болов. Түүнчлэн оны 5, 6 дугаар сард буурч байсан импорт 7 дугаар сараас өсч эхлэв. Энэ нь БНХАУ-ын гадаад худалдаанд сэргэх хандлага гарч байгааг илэрхийлсэн үзүүлэлт болж байна.

### Дүрслэл 1.4

БНХАУ-ын экспорт, импортын жилийн өсөлт




Эх сурвалж: Trading economics.

Хятадын шинэ удирдлагууд хөрөнгө оруулалт, экспортод суурилсан эдийн засгийн уламжлалт бодлогыг өөрчилж, илүү тэнцвэртэй, дотоод эрэлт, хэрэглээнд суурилсан өсөлтийг бий болгох, зээлийн чанарт илүү анхааран, чанаргүй зээлийг бууруулах бодлого баримталж байна.

Дэлхийн хөгжингүй орнууд болон түүхий эдийн гол хэрэглэгч БНХАУ-ын өсөлт саарч байгаа нь түүхий эдийн эрэлтийг бууруулж улмаар түүхий эдийн экспортод түшиглэсэн орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал оны эхнээс зэс, нүүрс, алт, төмрийн хүдрийн үнэ буурах хандлагатай болсон юм.

### Дүрслэл 1.5

Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ



Эх сурвалж: Блүмберг.

Дэлхийн банкны тооцоолсноор 2013 оны эхний хагаст Хятадын зэсийн хэрэглээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувь, дэлхийн зэсийн нийт хэрэглээ 2.3 хувиар тус тус буурсан байна. Энэ нь 2012 онд Хятад зэсийн стратегийн нөөцийн хэмжээг ихээр нэмэгдүүлсэнтэй голлон холбоотой байв. 2013 оны сүүлийн хагаст Хятадын зэсийн агуулахын нөөц буурсантай уялдан зэсийн хэрэглээ нэмэгдэж, 2013 онд дэлхийн зэсийн хэрэглээ 2.8 хувиар өснө хэмээн EIU<sup>2</sup>-ийн шинжээчид таамаглаж байна. Энэ оны эхний саруудад зэсийн үнэ дэлхийн зах зээлд дунджаар 8000\$/тн байсан бол Хятадын эдийн засгийн өсөлт саарч, металын эрэлт буурахын зэрэгцээ хөрөнгө оруулагчид өгөөж өндөртэй үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой болсноор зэсийн үнэ тогтмол буурсаар 6 сарын 31-ний байдлаар 6700\$/тн-д хүрсэн. Цаашид зэсийн агуулах дахь нөөц буурч, хэрэглээ нэмэгдсэнээр зэсийн үнэ ялимгүй өсч, оны эцэст 7200\$/тн-д хүрэх төлөвтэй байна.

Хятадын эдийн засгийн өсөлт саарсан, Хятадад 300 сая тонн нүүрсний бэлтгэсэн нөөц бий болсон нь 2013 оны эхний хагаст

<sup>2</sup> Economist Intelligence Unit

нүүрсний үнэ оны эхнээс 20 орчим хувиар буурах гол шалтгаан болсон байна. Гэхдээ энэ оны сүүлд нүүрсний үнэ одоогийн түвшнээс ялимгүй өсөх боловч өмнөх оны мөн үеэс 7 хувиар бага түвшинд байхаар байна.

Алтны үнийн хувьд Киприйн төв банк алтны нөөцөө ихээр зарсан, Холбооны нөөцийн банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний уламжлалт бус, зөөлөн бодлогын хүрээнд худалдан авч буй бонд, үнэт цаасны хэмжээ хязгаарлагдаж болзошгүй талаарх мэдээлэл зах зээлд гарсан зэрэгтэй уялдан 4, 5 дугаар сард огцом унасан. 6 дугаар сарын байдлаар алтны үнэ оны эхнээс 28 хувиар буурч, энэ онд алтны нийлүүлэлт нэмэгдэж зах зээлд 600 тоннын илүүдэл үүсэх төлөвтэй байгаа тул цаашид үнэ өсөхгүй байх магадлалтай

бөгөөд оны эцэст 1300\$/унц-д хүрэх төлөвтэй байна.


6 дугаар сарын 31-ний байдлаар 1 баррель Brent газрын тосны үнэ 109\$ байна. Энэ оны эхний хагаст Ойрхи Дорнодын улс төрийн хурцадмал байдлын улмаас газрын тосны нийлүүлэлт тасалдах эрсдэл өндөр байснаас газрын тосны үнэ өндөр хэвээр байв. Гэвч дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, АНУ-ын эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаагаас газрын тосны үнэ оны эцэст ялимгүй буурч 105\$/баррельд хүрнэ хэмээн таамаглаж байна. ОХУ-ын шатахууны экспортын татвар оны эхэнд 308\$/тн байсан бол 6 дугаар сарын байдлаар 280\$/тн болж буураад байна. Гэвч оны эцэс рүү эргээд нэмэгдэх хандлагатай байгаа юм.

## ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллүүд буурч байгаа үед санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл буурч, хөрөнгийн захуудад сэргэх хандлага ажиглагдаж ирсний гол шалтгаан нь эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих зорилгоор хөгжингүй орнуудад хэрэгжүүлж буй мөнгөний уламжлалт бус, зөөлөн бодлогын арга хэмжээ, түүний бодитой үр дүн юм. Энэ нь ч санхүүгийн зах зээлийг мөнгөний бодлогын талаарх аливаа хүлээлтэд улам бүр мэдрэмтгий болгоод байна. Нөгөө талаар эдийн засгийн суурь үзүүлэлтүүд үргэлжлэн суларч буй нь мөнгөний тэлэх бодлогыг үргэлжлүүлэх шаардлагыг бий болгосоор байгаа юм. Санхүүгийн зах зээл сэргэх хандлагыг дагаад евро бүсийн орнуудын засгийн газрын бондын өгөөж буурсан нь тэдгээр орнуудад тулгараад буй төсвөө танах бодлогын шаардлагад тодорхой орон зайг бага боловч бий болгож байна.

### Дүрслэл 1.6

Евро-бүсийн зарим орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн статистик болно.

Ийнхүү хөгжингүй орнуудын макро эдийн засгийн үзүүлэлтүүд төдийлөн сайжрахгүй байгаа нь тэдгээр орнуудын зээлжих зэрэглэл буурахад нөлөөлж байлаа. Хамгийн сүүлд 2012 оны II хагаст Франц улс, 2013

оны I хагаст Их Британи улсын зээлжих зэрэглэлийг бууруулаад байгаа бөгөөд “Их-7”-гийн орнуудаас ХБНГУ болон Канад улс л хамгийн “найдвартай”-д тооцогдож үлдлээ.

**Хүснэгт 1.1**

**Их-7 орнуудын зээлжих зэрэглэл**

	Moody's	S&P	Fitch
АНУ	Aaa	AA+	AAA
Их Британи	Aa1	AAA	AA+
Франц	Aa1	AA+	AA+
ХБНГУ	Aaa	AAA	AAA
Итали	Baa2	BBB	BBB+
Канад	Aaa	AAA	AAA
Япон	Aa3	AA-	A+

Эх сурвалж: Блүмберг.

Дэлхийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүчнүүдийн нэг Хятад улс банкны болон банкны бус санхүүжилтээр дамжуулан дэд бүтэц дэх хөрөнгө оруулалтаа цаашид нэмэгдүүлэхээр болсон нь тус улсын талаар бий болоод байсан сөрөг хүлээлтийг тодорхой хэмжээнд намжаав.


Япон улс олон жилийн дефляциас гарах, улмаар эдийн засгийн эрс идэвхжил бий болгох зорилгоор Төв банкнаас инфляцийг 2 хувьд онилон, улмаар нөөц мөнгөө 2013 онд 1.5 дахин, 2014 онд 2 дахин өсгөх, төв банкны актив дахь засгийн газрын үнэт цаасны хэмжээг 2014 он гэхэд 2.1 дахин нэмэгдүүлэх, түүндээ 40 хүртэл жилийн хугацаатай үнэт цаасыг хамруулах зэргээр мөнгөний уламжлалт бус тэлэх бодлого (QQE) хэрэгжүүлж үр дүнд хүрч байгаа нь санхүүгийн зах зээлд ихээхэн сэргэлтийг бий болгосон.

Хөгжингүй орнуудын төв банкууд мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогынхоо хүрээнд актив худалдаж авах хөтөлбөрөө үргэлжлүүлсэн бөгөөд тэр хэрээр төв банкуудын баланс томорсоор байна. Харин

интервенциэс <sup>3</sup> шалтгаалан өсч байсан Швейцарийн төв банкны баланс тогтворжсон бол Европын төв банкны баланст бага зэрэг бууралт бий болов. Энэ нь Европын банкуудын санхүүгийн нөхцөл байдал харьцангуй сайжран, улмаар урт хугацааны санхүүжилтийн хөтөлбөрөөр европын төв банкнаас авсан зээлийн буцаан төлөлт идэвхжсэнтэй холбоотой юм.

**Дүрслэл 1.7**

**Зарим хөрөнгийн захын индекс**



Эх сурвалж: Блүмберг.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн статистик болно, 2012.12.31=100.

Хэдийгээр Европын банкуудын санхүүгийн нөхцөл байдал урьдынхаас дээрдэж байгаа нь бодит эдийн засгийн идэвхжилийг дэмжих зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болох боловч зээлийн нөхцөл чангарсаар байгааг судалгааны үр дүн харуулсаар байгаа юм.

<sup>3</sup>Евро бүсийн өндөр эрсдэлээс шалтгаалан хөрөнгийн орох урсгал өсч, улмаар үндэсний валютын ханшид нь чангарах дарамт үүссэнээс шалтгаалан Швейцарийн төв банкнаас еврогийн эсрэг 1.20 түвшнээс цааш чангаруулахгүй зорилттойгоор интервенц хийж байгаа билээ. Ханш чангарах дарамт буурсныг евро, Швейцарь франкын ханш 1.20 түвшнээс холдсон байгаагаас харж болно.

**Дүрслэл 1.8**

**Хөгжингүй орнуудын төв банкны актив болон ДНБ-ий харьцаа**




Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: \*2012 оны ДНБ-ийг ашиглан тооцоолов.

Европын төв банк 2013 оны 5 дугаар сарын 2-ны өдөр мөнгөний бодлогын хүүг 0.25 нэгж хувиар бууруулан жилийн 0.5 хувьд хүргэх шийдвэр гаргасан. Үүнээс гадна 2013 оны II улиралд Австрали, Дани, Энэтхэг, Израйль, Өмнөд Солонгос, Мексик, Польш болон Турк улсын Төв банкууд мөн мөнгөний бодлогын хүүг бууруулжээ.

**Дүрслэл 1.9**

**Зарим Төв банкуудын мөнгөний бодлогын хүүний түвшин**




Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн статистик болно.

Хэдийгээр дэлхийн санхүүгийн зах зээл тогтворжиж байсан ч, хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт 2012 оны сүүлийн улиралд хүлээгдэж байснаас бага гарсан нь судлаачдыг 2013 оны эдийн засгийн өсөлтийн өмнөх төсөөллүүдийг эргэж харах, улмаар төсөөллийн утгыг бууруулахад хүргэсэн. Мөн Хятад улсын эдийн засгийн өсөлт саарч, зээлжих зэрэглэл нь буурсан зэрэг таагүй үйл явдлууд бүс нутгийн болон дэлхийн эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлэв. Ийнхүү дэлхийн эдийн засгийн ерөнхий төлөв хандлага төдийлөн сайжрахгүй байгаагийн зэрэгцээ бүрэлдэж буй эдийн засагтай (EM) болон хөгжиж буй орнуудын (DC) эрсдэл нь гадаад худалдааны нөхцөл муудах, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах сувгаар төлбөрийн тэнцэлд дарамт учруулж, тэдгээр орнуудын үндэсний валютын ханшийг сулруулах чиглэлд нөлөөлж байна.

**Дүрслэл 1.10**

**Алт, зэсийн үнэ болон ам.долларын ханшийн индекс**



Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 7 дугаар сарын 24-ны өдрийн статистик болно, 2012.12.31=100, энэ үед алт 1675\$/унци, зэс 7968\$/тонн үнэтэй байв.


Энэ оны 4 дүгээр сард нийт бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн индекс (all-commodities index) 7 хувиар буурсан бөгөөд зэсийн үнийн бууралт бусад аж үйлдвэрийн металын үнийн уналтыг тэргүүлсэн. Мөн энэ оны 4 дүгээр сард алтны үнэ хоёр өдрийн дотор сүүлийн

30 жилд тохиолдож байгаагүй огцом уналтыг үзүүлэв.

Санхүүгийн захын хэлбэлзэл багасч буй нөхцөлд хүүний өндөр зөрүүнээс ашиг олох зорилго бүхий арилжаа (carry trade) 2012 оны эхний хагасаас хойш нэмэгдсэн бөгөөд энэ нь хөрвөх чадвартай, өгөөж өндөртэй валютуудын хувьд чангарах дарамтыг үүсгэж байна. Тухайлбал, Мексикийн песо, Австрали болон Шинэ Зеландын долларыг нэрлэж болох юм. Австралийн Нөөцийн банк мөнгөний бодлогын хүүг 0.25 нэгж хувиар бууруулан 2.75 хувьд хүргэсэн бол Шинэ Зеландын төв банк гадаад валютын захад интервенц түлхүү хийсэн байна.

**Дүрслэл 1.11**

**Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш**




Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн статистик болно, 2012.12.31=100.

АНУ-ын эдийн засагт сэргэлт бий болж, ажилгүйдлийн түвшин тасралтгүй буурч байгаа нь Холбооны нөөцийн банк эдийн засгийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй мөнгөний тэлэх бодлогын хүрээнд актив худалдан авах үйл ажиллагааг хязгаарлах магадлалыг нэмэгдүүлсэн. Энэ талаар Холбооны нөөцийн банкнаас гаргасан мэдэгдлүүд, АНУ-ын эдийн засгийн

индикаторууд нь санхүүгийн зах зээлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна.

**Дүрслэл 1.12**

**АНУ-ын ажилгүйдлийн түвшин, мөнгөний бодлогын хүү**



Эх сурвалж: Блүмберг, Холбооны нөөцийн банк.

Хэдийгээр хөгжингүй орнуудын эдийн засагт тодорхой хэмжээгээр сэргэлт ажиглагдаж байгаа ч, бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнуудад эсрэг дүр зураг харагдаж байлаа. Өөрөөр хэлбэл, бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж байгаа орнууд, тэр дундаа ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас өндөр хамааралтай орнуудад нийтлэг тохиолдож байгаа төлбөрийн тэнцлийн дарамт, эдийн засгийн өсөлтийн сааралт, удаашралын гол шалтгаан нь дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн уналтаас гадна хөрөнгө оруулалтын орчин дахь тодорхой бус байдал, валютын урсгалын хандлага дахь урвуу өөрчлөлт, хөгжиж буй орнуудын дотоод эрсдэл зэрэг болж байна.

Хөрөнгө оруулагчид бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнуудад хийж буй хөрөнгө оруулалтаа хумих, тэдгээр орнуудаас хөрөнгөө татах зэрэг үзэгдэл идэвхжиж, хөрөнгийн урсгалын хандлагад урвуу өөрчлөлт бий боллоо. Энэ нь тэдгээр

орнуудын активын үнэд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ өрийн дарамтыг нэмэгдүүлэх, санхүүгийн салбар дахь чанаргүй зээлийг өсгөх зэрэг сөрөг үр дагавар бий болгож байна. Бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнуудад үндэсний валютын ханш сулрах дарамт нийтлэг тохиолдож байна. Энэ нь төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал бүхий Бразил, Энэтхэг, Индонез, Өмнөд Африк, Турк зэрэг орнуудын эдийн засагт илүү хүчтэй нөлөөлөл бий болгож байгаа юм. Ийнхүү үүсээд байгаа нөхцөл байдлын эсрэг улс орнууд бодлогын янз бүрийн арга хэмжээг үндэсний эдийн засгийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлж байна. Жишээ нь, Энэтхэг улс валютын

интервенц хийх, хөрөнгийн урсгалд зарим хяналт тогтоохын зэрэгцээ урсгал тэнцлийн алдагдлыг бууруулахын тулд алт, мөнгөний импортод татвар ногдуулах, төмрийн хүдрийн экспортоо либералчлах, импортын нүүрсний хамаарлаа бууруулах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлжээ. Харин Индонез, Турк, Бразил дотоодын валютын захад интервенц хийхийн зэрэгцээ мөнгөний бодлогын хүүг өсгөж, мөнгөний бодлогын төлвийг чангаруулах арга хэмжээ авчээ. Түүнчлэн, энэ онд төлбөрийн тэнцлийн дарамт ихтэй орнуудын гадаад валютын нөөцөд огцом бууралт ажиглагдаад байна.

## 1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


### МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын эдийн засаг дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан 2009 онд 1.3 хувиар буурсныг эс тооцвол 2006 оноос хойш дунджаар 10.6 хувиар өсч иржээ. Харин 2011 онд 17.5 хувиар, 2012 онд 12.4 хувиар өссөн бол 2013 оны эхний 3 улирлын байдлаар 11.5 хувиар өсөөд байгаа нь олон жилийн дунджаас өндөр хэвээр байна. 2011 онд эдийн засгийн өсөлт 17.5 хувьд хүрч өссөн нь бүхэлдээ уул уурхайн салбарын огцом өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар тайлбарлагдаж байв.

2011 онд Монгол Улсын экспортын үнийн индекс түүхэн дээд түвшиндээ хүрч өссөний зэрэгцээ, Австралид болсон үерээс шалтгаалан тус улсын нүүрсний уурхайнууд түр хугацаанд хаагдсантай холбоотойгоор Хятадын зах зээл дэх манай нүүрсний экспортын эзлэх хувь хэмжээ өссөн юм.

### Дүрслэл 1.13

#### Монгол Улсын нийт экспорт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Түүнчлэн, хөгжингүй орнуудад хэрэгжүүлж буй мөнгөний тэлэх бодлого нь дэлхийн санхүүгийн зах зээлд эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ, уул уурхайн салбарт зонхилсон гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж, төлбөрийн тэнцэлд богино

хугацаанд дарамтгүй он байв. Ийнхүү 2011 онд Монгол Улсын экспорт 64.9 хувиар өссөн ч, түүнийгээ дагаад төсвийн зардлыг 55.8 хувиар нэмэгдүүлэн, мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжүүлсэн нь уул уурхайн цөөхөн эрдэс, түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай, эмзэг, нээлттэй, жижиг эдийн засгийн дотоод эрсдэлийг нэмэгдүүлсэн. Монгол Улс 2011-2012 он буюу богино хугацаанд бий болсон гадаад орчны таатай нөхцөл, боломжийг урт хугацаанд тогтвортой хөгжлийн суурийг бий болгох зорилготой хөрөнгө оруулалт, хуримтлалыг нэмэгдүүлэх арга хэмжээ байдлаар ашиглалгүй, төсвийг огцом тэлэх, сонгуулийн амлалт биелүүлэх зорилгоор хэрэглээ, импортыг дэмжсэн хавтгайрсан халамжийн<sup>4</sup> бодлого хэрэгжүүлсэн нь 2012 оноос эхлэн бий болсон төлбөрийн тэнцлийн дарамт, эдийн засгийн хүндрэлийн эх үндэс юм.

### Дүрслэл 1.14

Гадаад худалдааны нөхцөлийн индекс



Эх сурвалж: Монголбанк.

Дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ буурч, Монгол Улсын экспортын салбарын өрсөлдөх чадвар муудсанаас шалтгаалан экспорт 2012 онд 8.3 хувиар, 2013

оны эхний хагас жилийн байдлаар 10.5 хувиар тус тус буурлаа.

Нэг талаас бүс нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын орчин муудаж, Хятадаас хөгжиж байгаа орнуудад хийх хөрөнгө оруулалт 2012 онд 50 хувиар буурсан, нөгөө талаас 2012 оны 5 дугаар сард “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдаж, Оюу толгой төслийн гэрээний маргаан хэт сунжирсан зэрэг нь Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын орчинд тодорхой бус байдлыг үүсгэснээс шалтгаалан өмнөх онуудад урсгал тэнцлийн өндөр алдагдлыг нөхөж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2012 онд 4.6 хувиар, 2013 оны эхний хагас жилийн байдлаар 41.9 хувиар тус тус буурчээ.


Монгол Улсын урсгал тэнцлийн өндөр алдагдлыг хөрөнгө, санхүүгийн данс, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нөхөж чадахгүйд хүрснээр төлбөрийн нийт тэнцэл 2013 оны эхнээс алдагдалтай болж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах хандлагатай болсон юм. Ийнхүү үндэсний валютын ханш сулрах нь гадаад орчны сөрөг нөлөөлөлд дотоодын эдийн засгийн үзүүлж буй хариу үйлдэл юм.

Энэ нөхцөлд Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д туссаны дагуу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг баримтлан, шаардлагатай нөхцөлд ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад цаг тухайд нь оролцсоор ирлээ.

<sup>4</sup> 2011, 2012 оны нийлбэр дүнгээр хавтгайрсан халамжийн бодлогод зориулан 1.9 их наяд төгрөг зарцуулжээ.

**Дүрслэл 1.15**

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)**




Эх сурвалж: Монголбанк.

Дээр дурдсан сөрөг нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн идэвхжил 2012 оны эхнээс удааширч, түүнийг дагаад эдийн засагт санхүүгийн эх үүсвэрүүд хомсдон, мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлт эрс саарч, улмаар 2012 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн салбарт зээлийн тасалдал бий болох, улмаар санхүү, эдийн засгийн болзошгүй хямралын эрсдэл бодитоор нүүрлээд байлаа. Ийнхүү 2013 онд санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсч, банкны систем хямрах, ДНБ-ий бодит өсөлт сөрөг утгатай болох, хувийн хэвшил агшиж, олон мянган ажлын байрууд алдагдах бодит аюулыг тойрч гарах, үүний тулд эдийн засагт үүссэн хүндрэлийг саармагжуулж, эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах шат дараатай арга хэмжээг Монголбанкнаас 2012 оны 10 дугаар сараас эхлэн авч хэрэгжүүлсэн болно. Үүний үр дүнд ДНБ-ий бодит өсөлт оны эхний 3 улирлын байдлаар 11.5 хувь буюу 2 оронтой тоонд хадгалагдаж, улсын инфляци (жилийн) 2013 оны 9 дүгээр сарын байдлаар 9.9 хувь буюу оны эхнээс 4.1 нэгж хувиар бууран, банкуудын төлбөрийн чадвар сайжран өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 2013 оны 9 дүгээр сарын байдлаар

15.7 хувьд хүрч өссөний зэрэгцээ эдийн засгаас 170 гаруй мянган ажлын байр үгүй болох эрсдэлийг арилгаж чадлаа.

**Дүрслэл 1.16**

**Улирлын ДНБ-ий жилийн өсөлт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Төрөөс 2013 онд баримталж буй мөнгөний бодлогын тухайд макро тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх, бодит эдийн засгийн идэвхжилийг дэмжихийн тулд инфляцийг бууруулж, нам түвшинд нь тогтвортой байлгах нь нэн тэргүүний асуудал байсан.

Манай оронд инфляцийн суурь шалтгааныг арилгахын тулд хүнс, шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн.


Иймд инфляцийг зорилтот түвшинд нь хүртэл бууруулж, нам түвшинд тогтвортой байлгах зорилтын хүрээнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийг хязгаарлах зорилготой “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг Монголбанк, Засгийн газар хамтран баталсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 5 дэд



хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Одоогоор “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас 620 гаруй тэрбум төгрөгийг эдийн засагт нийлүүлсэн бөгөөд хөтөлбөрийн зээлүүд хуваарийн дагуу эргэн төлөгдөж байна.

**Дүрслэл 1.17**

**Инфляцийн задаргаа**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд нийлүүлэлтийн гаралтай болон хүлээлтээс шалтгаалсан инфляцийн дарамт эрс багасч, мах, гурил, жижиглэнгийн зах зээл дэх түлш шатахууны үнийн өсөлт тогтвортой байгаа нь инфляци буурахад нөлөөлж байна.

Нийлүүлэлтийн гаралтай болон эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт багасч, инфляцийн хандлага зорилтот түвшинтэй нийцтэй байсантай уялдан Монголбанкнаас мөнгөний бодлогын хүүг 2013 оны 1, 4, 6 дугаар саруудад нийтдээ 2.75 нэгж хувиар шат дараатай бууруулан эдийн засгийн идэвхжил, бодит секторыг дэмжиж, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав.

Санхүүгийн эх үүсвэр дутагдаж, банкуудад зээлийн тасалдал үүсэх бодитой эрсдэл учирсан үед Монголбанкнаас банкуудад 2013 оны 1-3 дугаар сард 850 тэрбум төгрөгийн, 5 дугаар сард 50 тэрбум төгрөгийн 12 сарын хугацаатай хадгаламж байршуулж, эх үүсвэрээр дэмжлээ. Үүний үр дүнд банкуудад зээлийн тасалдал үүсээгүй бөгөөд зээлийн өсөлт эдийн засгийн бодит өсөлттэй нийцтэй түвшинд хүрээд байна. Инфляцийг бууруулж, санхүүгийн салбарыг болзошгүй эрсдэлээс хамгаалсны дараа Монголбанкнаас эдийн засгийн бодит секторыг дэмжих, ажлын байрыг хамгаалах, ДНБ-ий бодит өсөлтийг тогтворжуулах зорилтын хүрээнд зөвхөн орон сууцны барилгын салбарт зээл гаргах зориулалттай 420 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэрийг банкуудад байршуулсан нь барилгын салбарын үйлдвэрлэлийн огцом өсөлт, орон сууцны нийлүүлэлтэд бодитой дэмжлэг болсон юм. Үүний дараа орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр хэрэгжүүлж, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлсэн болно. 2013 оны эхний 3 улирлын байдлаар Монгол Улсад орон сууцны ипотекийн зээлдэгчдийн тоо 45 мянгаас давж, нийт орон сууцны ипотекийг ДНБ-д харьцуулсан харьцаа 9 сарын дотор 6 хувиас 14 хувьд хүрч 8 нэгж хувиар өслөө. Ийнхүү дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх бодлогыг цаашид тууштай хэрэгжүүлснээр урт хугацаанд инфляци буурахын зэрэгцээ эдийн засгийн урт хугацааны тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг хангах болно.

ГАДААД СЕКТОР


**Төлбөрийн тэнцэл ба нийт гадаад өр**

2013 он гарсаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурсан нь хөрөнгө санхүүгийн дансны ашгийг бууруулах гол хүчин зүйл болов. Улмаар урсгал тэнцлийн алдагдлыг хөрөнгө санхүүгийн дансны ашгаар нөхөж чадахгүйд хүрсэн тул гадаад валютын улсын нөөц оны эхний хагаст 998 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байлаа.

Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2013 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 1.77 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 22 хувиар буюу 317 сая ам.доллараар нэмэгдсэн бол хөрөнгө санхүүгийн данс 913 сая ам.долларын ашигтай гарснаар өмнөх оны мөн үеэс 55 хувиар буюу 1.13 тэрбум ам.доллараар буурсан байна.

**Дүрслэл 1.18**

**Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл**




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \* Засгийн газраас 1.5 тэрбум ам.долларын бонд гаргаагүй бол гэсэн хувилбараарх төлбөрийн тэнцэл (Алдагдлын хэмжээ 2012 оны сүүлийн хагаст 600 сая ам.долларт хүрэхээр байв)

2013 оны эхний хагаст хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 913 сая ам.доллар болж буурсан нь Монгол Улсад орох гадаадын шууд

хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 42 хувиар буюу 1.04 тэрбум ам.доллараар, багцын хөрөнгө оруулалт 103 хувиар буюу 625 сая ам.доллараар буурч, бусад хөрөнгө оруулалт 51 хувиар буюу 533 сая ам.доллараар буурсантай холбоотой байна.

**Дүрслэл 1.19**

**Хөрөнгө санхүүгийн дансны бүтэц**




Эх сурвалж: Монголбанк.

Урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэхэд барааны гадаад худалдааны алдагдал 1 хувиар өсч 646 сая ам.долларт, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 33 хувиар өсч 764 сая ам.долларт, орлогын дансны алдагдал 3 хувиар өсч 418 сая ам.долларт, урсгал шилжүүлэг 65 хувиар буурч 58.6 сая ам.долларт хүрсэн нь тус тус нөлөөлөв. 2013 оны 2-р улиралд урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 35 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.4 нэгж хувиар өссөн байна. 2012 оны эцсийн байдлаар урсгал тэнцлийн алдагдлаас хөрөнгө санхүүгийн дансны ашиг өндөр байсан (“Чингис” бонд, Хөгжлийн банкны бондын нөлөөгөөр) тул гадаад валютын нөөцөд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байсан. Гэтэл 2013 онд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурч, урсгал тэнцлийн алдагдал нэмэгдсэнээр гадаад валютын нөөц

буурч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэв.

**Дүрслэл 1.20**

**Урсгал тэнцлийн бүтэц**




Эх сурвалж: Монголбанк.

2010-2012 онд урсгал дансны алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад зээлээр санхүүжүүлж байсан бол 2013 оны эхний хагаст урсгал тэнцлийн алдагдлын 12.2 хувийг гадаад зээл, 31.4 хувийг зээлийн бус санхүүжилт, үлдсэн 56.4 буюу талаас илүү хувийг гадаад валютын улсын нөөцөөр санхүүжүүлсэн байна.<sup>5</sup>

**Дүрслэл 1.21**

**Урсгал тэнцлийн санхүүжилт**




Эх сурвалж: Монголбанк.

<sup>5</sup> Зээлийн санхүүжилт нь төлбөрийн тэнцлийн бусад хөрөнгө оруулалт хэсгийн худалдааны зээл болон зээлийн дүнгийн нийлбэртэй тэнцүү.

Урсгал тэнцлийн болон төсвийн удаан хугацаанд үргэлжилсэн, өндөр хэмжээний алдагдал нь өрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулдаг билээ.

**Дүрслэл 1.22**

**Улс орнуудын Засгийн газрын нийт өр-ДНБ-ий харьцааны тархалт**



Эх сурвалж: Дэлхийн банк, Сангийн яам, Монголбанк.

Тэмдэглэл: Засгийн газрын гадаад, дотоод өрийн ДНБ-д эзлэх хувийн тархалтыг 64 орноор үзүүлэв. Монгол Улсын үзүүлэлт 2012 онд 47 хувь байна.

\*ОУВС-гийн (2011) "Modernizing the Framework for Fiscal Policy and Public Debt Sustainability Analysis" судалгаанд бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын засгийн газрын өрийн дээд хязгаарыг хэд хэдэн аргачлалаар судалсан байдаг: (1) Параметрт аргачлал: квадратлиг функц ашиглан төсвийн тэнцэлд хамгийн их эергээр нөлөөлж буй өр-ДНБ-ий харьцааг тооцсон [50 хувь], (2) Дитерминистик аргачлал: Mendoza, Oviedo (2003) нарын загварт суурилсан [35-75 хувь], (3) Параметрт бус аргачлал: сигналын хандлага (signal approach) [77 хувь].

\*\*Ихэнх орон төсвийн тухай (тогтвортой байдал, сахилга) хуулиндаа өр-ДНБ-ий дээд хязгаарыг 60 хувиар тогтоосон байдаг.

Хэдийгээр Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл сүүлийн жилүүдэд тасралтгүй өссөөр байгаа ч, өрийн дарамтын голлох үзүүлэлт болох Засгийн газрын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2013 оны эхний хагас жилийн байдлаар 47 хувьтай<sup>6</sup> байгаа нь олон улсын түвшинд дундаж үзүүлэлт юм.

Олон улсын түвшинд дээрх үзүүлэлтийн сэрэмжлэх түвшин 40 хувь гэж үздэг бол улс орнуудын төсвийн тухай (төсвийн тогтвортой

<sup>6</sup> Нэрлэсэн ДНБ-ий 2012 оны гүйцэтгэлд үндэслэн тооцов.

байдал, сахилга) хуулинд тогтоосон дээд хязгаар 60 хувь байх нь түгээмэл байна. Харин өрийн дарамтын үзүүлэлтийг судалсан судалгааны ажлуудад суурилан авч үзвэл засгийн газрын нийт өрийн ДНБ-д эзлэх хувь 50-80 (голч нь 65) хувь буюу түүнээс хэтрэх нь сөрөг нөлөө, эрсдэл бий болгодог гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Иймд олон улсын туршлагаас авч үзвэл Монгол Улсын засгийн газрын өр одоогийн байдлаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх буюу өрийн дарамт, хямралд хүргэх түвшинд хүрээгүй гэж дүгнэж байна.

### Хүснэгт 1.2

Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2010	2011	2012	2013Н1	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Монгол Улсын нийт гадаад өр	5 928	9 628	15 386	17 403	2 017	13%
I. Засгийн газар	1 788	1 951	4 264	4 222	-42	-1%
II. Төвбанк	274	268	414	481	67	16%
III. Банк	506	710	1 074	1 216	142	13%
Богино хугацаат	77	82	58	61	3	5%
Урт хугацаат	429	628	1 016	1 155	139	14%
IV. Бусад сектор	646	949	1 276	1 454	178	14%
Богино хугацаат	289	502	508	469	-40	-8%
Урт хугацаат	357	447	768	985	217	28%
V. Шууд хөрөнгө оруулалт <sup>7</sup>	2 715	5 750	8 357	10 029	1 672	20%


Эх сурвалж: Монголбанк.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар гадаад валютын улсын нөөц 27 хувиар буурсан хэдий ч, валютын төлбөртэй импортын 18.4 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд байгаа нь олон улсын жишиг доод түвшин болох 12 долоо хоногоос өндөр байна.

Цаашид эдийн засаг дахь гадаад валютын орох урсгалыг экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлэхийн сацуу биет болон биет бус алтаар валютын нөөцийг өсгөх, гадаад валютын улсын нөөцтэй уялдуулан эдийн засаг дахь урт хугацаатай төгрөгийн нийлүүлэлтийг хийх нь чухал байна.

### Дүрслэл 1.23

Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: 2006 оны 1 дүгээр сараас 2013 оны 6 дугаар сар хүртэлх тоон мэдээлэл ашигласан.

<sup>7</sup> Толгой компаниас охин компанид хөрөнгө оруулалт хэлбэрээр хийсэн санхүүжилт буюу толгой компаниасаа авсан зээл.

**Шигтгээ №1**

**Монгол Улсын нүүрсний зах зээл**


Нүүрс нь эрчим хүчний гол эх үүсвэрээс гадна ган, цементийн үйлдвэрлэл болон бусад аж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагддаг чухал түлш юм. 2012 оны эцсийн байдлаар дэлхийн нүүрсний “батлагдсан нөөц” 861 тэрбум тонн байгаа бөгөөд үүний дийлэнх нь буюу 68 хувь нь АНУ, ОХУ, Хятад, Австрали улсад ногдож байна. Манай улсын хувьд батлагдсан нөөцөөрөө дэлхийд 12 дугаар байранд орсон үзүүлэлттэй байна.

Монгол Улсад нийт 85 орчим орд газарт нүүрсний 173.3 тэрбум тоннын “геологийн нөөц” тогтоогдсон ба үүнээс 22.3 тэрбум тонныг урьдчилсан болон нарийвчилсан хайгуулаар тодорхойлжээ. Нүүрсний нөөцийн 12.2 тэрбум нь эрчим хүчний, 2 тэрбум нь коксжих, үлдсэн 8.1 тэрбум тонн нь хүрэн нүүрс байна. 2013 оны байдлаар нүүрсний салбарт төрийн өмчит 1, төрийн өмч давамгайлсан 2, орон нутгийн өмчит 3, хувийн хэвшлийн 40 гаруй уурхайд 60 гаруй аж ахуйн нэгж идэвхитэй үйл ажиллагаа явуулж, нүүрс олборлож байна<sup>8</sup>. Нүүрсийг чийглэг, үнслэг, дэгдэмхий бодис болон коксын гарц, шинж байдал, хүхрийн агуулга, илчлэг зэрэг чанарын үзүүлэлтүүдээс нь хамааран сайн чанарын чулуун нүүрс болон хүрэн нүүрс гэж ангилна. Манай орны сайн чанарын чулуун нүүрсний нөөц нь нутгийн баруун, баруун өмнөд, хойд хэсгээр, харин чанарын зэрэглэл багатай хүрэн нүүрсний нөөц зүүн, зүүн өмнөд хэсгээр тархсан байна. Цаашилбал, стратегийн ач холбогдол бүхий Тавантолгой, Ухаа худаг, Баруун наран, Нарийнсухайт, Овоот толгой, Хөшөөт зэрэг

томоохон, сайн чанарын коксжих нүүрсний орд газрууд нь нутгийн өмнөд болон баруун хэсгээр, Хятад улсын хилтэй ойр байрлаж, нүүрсний судал нь газрын гадаргатай ойр оршдог нь ил ашиглалтын арга, технологиор хямд өртгөөр олборлож, харьцангуй бага тээврийн зардлаар экспортлох боломжтой байна.

**Дүрслэл 1.24**

**Аж үйлдвэрлэл болон нийт экспортод эзлэх нүүрсний хувь хэмжээ**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар.

2012 оны байдлаар нүүрсний салбар аж үйлдвэрлэлийн 22 хувь, экспортын 43 хувийг эзэлж байна. Гэтэл 2013 оны эхний хагаст эдгээр үзүүлэлтүүд огцом буураад байна. Үүний гол шалтгаан нь манай экспортын нүүрсний өрсөлдөх чадвар сайжраагүйтэй холбоотой юм.


Монгол Улс жилд ойролцоогоор 30 сая тонн нүүрс үйлдвэрлэж, үүнээс 21 сая тонн орчим коксжих нүүрсийг экспортлон, 7 сая тонн нүүрсийг хэрэглэж байна. Дотоодын нүүрсний хэрэглээний 80 хувийг төв, зүүн, баруун бүсийн цахилгаан станцуудад түлшний зориулалтаар, үлдсэн хувийг

<sup>8</sup> Ашигт малтмалын газар 2013 он, Эрдэс баялаг, эрчим хүчний яам (хуучин нэрээр) 2011 он.

үйлдвэр, барилга, тээвэр, ХАА, дулааны болон бусад зориулалтаар ашигладаг.

### Дүрслэл 1.25

Нүүрсний үйлдвэрлэл, экспорт, хэрэглээ (сая тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.


Дулааны цахилгаан станцуудын хэрэгцээт нүүрсийг Багануур, Шивээ Овоо, Шарын гол, Адуунчулуун болон ойролцоох жижиг уурхайнуудаас хангаж байгаа бөгөөд эдгээр уурхайн эрчим хүчний болон хүрэн нүүрсийг зөвхөн дотоодод хэрэглэж байна. Монгол Улсаас эрчим хүчний нүүрс Хятадад экспортлох нь одоогоор эдийн засгийн хувьд үр ашиггүй байгаа тул голчлон коксжих нүүрсийг экспортод гаргаж байна. Хятад улс дотооддоо эрчим хүчний нүүрсний нөөц ихтэй, дэлхийн томоохон нийлүүлэгч орон юм.

Монгол Улс анх 2003 оноос нүүрс экспортолж эхэлсэн бөгөөд нүүрсний экспортын биет хэмжээ 2007 оноос эрчимтэй нэмэгдэж, 2010, 2011 онд харгалзан 133 хувь, 27 хувиар өсч, 2012 оны гүйцэтгэлээр 20.5 сая тонн нүүрс экспортолжээ. 2009 оноос хойш Хятад улсын коксжих нүүрсний импортод Монгол Улсын эзлэх хувь хэмжээ жигд өссөөр 2012 оны эцсийн байдлаар 36 хувийг

эзэлж байв. Гэтэл 2013 оны эхний 10 сарын байдлаар уг үзүүлэлт 19 хувь болж буураад байна.

### Дүрслэл 1.26

Хятад улсын коксжих нүүрсний импортод эзлэх хувийн жин ба экспортын дундаж үнэ, улсуудаар (2012 он)



Эх сурвалж: Блүмберг, Гаалийн ерөнхий газар.

Монголын нүүрсний экспортын дундаж үнэ (ФОБ) бусад орнуудтай харьцуулахад ойролцоогоор 2 дахин бага байна. Энэ нь нүүрсний чанарын үзүүлэлт гэхээсээ илүүтэй Монголоос Хятад руу нүүрс тээвэрлэх өртөг өндөр, нүүрс худалдан авагч Хятадын талтай байгуулсан гэрээний нөхцөлүүд тааруу байгаатай холбоотой юм. Нүүрс экспортологч аж ахуйн нэгжүүдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа боловч дийлэнх нүүрсийг цөөн хэдэн компаниуд экспортолж байна. Тухайлбал, 2012 оны байдлаар нийт 70 компани Монгол Улсаас нүүрс экспортолсноос Монголын алт МАК ХХК (26.4%), Энержи Ресурс (26.2%), Эрдэнэс Таван толгой ХК (11.6%) Тавантолгой-Транс (9.9%), Саусгоби сэндс ХХК (9.7%), Чинхуа-МАК-Нарийн Сухайт ХХК (6.3%) зэрэг компаниуд нийт нүүрсний экспортын 91 хувийг бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

**БОДИТ СЕКТОР**

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2013 оны 2 дугаар улиралд урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх улирлаас 7.2 нэгж хувиар өсч, 14.3 хувь байна.

**Хүснэгт 1.3**

**Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд**


	2012				2013*	
	I	II	III	IV	I	II
<b>Бодит ДНБ, тэрбум төгрөгөөр</b>	<b>998.5</b>	<b>1429.0</b>	<b>1490.5</b>	<b>1580.5</b>	<b>1068.9</b>	<b>1633.2</b>
Уул уурхайн	184.4	221.2	209.8	239.1	193.0	237.6
Уул уурхайн бус	814.1	1207.8	1280.7	1341.4	876.0	1395.6
<b>Бодит ДНБ-ий өсөлт</b>	<b>15.9%</b>	<b>11.3%</b>	<b>9.6%</b>	<b>14.0%</b>	<b>7.1%</b>	<b>14.3%</b>
Уул уурхайн	10.1%	14.3%	-1.2%	9.9%	4.6%	7.4%
Уул уурхайн бус	17.3%	10.7%	11.6%	14.8%	7.6%	15.6%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Эдийн засгийн өсөлт 2012 оны 1 дүгээр улирлаас эхлэн саарч, 2013 оны 1 дүгээр улиралд 7.1 хувьд хүрсэн.

**Дүрслэл 1.27**

**Эдийн засгийн өсөлтийн задаргаа**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Үүнд хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбаруудын өсөлт саарсан нь нөлөөлжээ. Харин 2013 оны 2 дугаар улиралд эдийн засгийн өсөлт 14.3 хувьд хүрсэн ба

үүнд барилгын салбар өндөр өсөлттэй гарсан, хөдөө аж ахуйн салбар өсөлтөө хадгалсан зэрэг нь нөлөөллөө.

2013 оны 2 дугаар улирлын ДНБ-ий өсөлтийг бүтцээр нь авч үзвэл, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний цэвэр татварын ДНБ-ий өсөлтөд эзлэх хувь өнгөрсөн оны 2 дугаар улиралтай харьцуулахад өссөн байна.

**Хүснэгт 1.4**

**2013 оны эхний хагасын ДНБ-ий өсөлт (салбаруудаар)**

	ДНБ	11.3%	100%
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3.0%	26.5%
2	Уул уурхай, олборлолт	1.0%	9.1%
3	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.6%	5.4%
4	Бөөн/жиж.худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	0.4%	3.3%
5	Бүтээгдэхүүний цэвэр татвар	1.7%	15.2%
6	Мэдээлэл, хөлбоо	0.4%	3.6%
7	Боловсруулах үйлдвэрлэл	0.3%	3.1%
8	Барилга	1.2%	10.3%
9	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.2%	1.8%
10	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.5%	21.7%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2013 оны 2 дугаар улиралд барилгын салбарын жилийн өсөлт 154 хувь, хөдөө аж ахуй 20.6 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 15.5 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 15.1 хувь байсан нь бусад салбаруудаас өндөр байв. Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтийн 26.5 хувийг бүрдүүлсэн бол үйлчилгээний бусад үйл ажиллагаа 21.7 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 15.2 хувь, барилгын салбар 10.3 хувийг тус тус бүрдүүлжээ. 2012 оны 2 дугаар улиралтай харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлийн салбарт өсөлт төдийлөн ажиглагдаагүй байна.


МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

2013 оны 8 дугаар сарын байдлаар M2 мөнгөний нийлүүлэлт жилийн 20.2 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр өсч, 8.4 их наяд төгрөгт хүрлээ. Үүнийг бүтцээр нь задлан үзвэл бараг мөнгөний жилийн өсөлт 21.5 хувь байгаа нь M2 мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 81 хувийг бүрдүүлж байна. Тэр дундаа төгрөгийн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28.9 хувиар өссөн нь нийт мөнгөний жилийн өсөлтийн 63 хувийг тодорхойллоо.

Бараг мөнгө өмнөх оноос 1.1 их наяд төгрөгөөр өссөн бол M1 мөнгө 16 хувиар буюу 269 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд 2011 оны хоёрдугаар хагасаас M2 мөнгөний жилийн өсөлт саарч, 2012 оны эхний хагас хүртэл үргэлжлэн, харин 2012 оны сүүлийн хагасаас тогтворжсон байна.

Дүрслэл 1.28

M2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

Харин бараг мөнгөний өсөлтийн хэмжээ 2012 онд 20-25 хувьд тогтворжиж, 2013 он гарснаар өсөлт нь бага зэрэг саарч байна. Зарим үед сөрөг утгатай байсан M1 мөнгөний өсөлт 2013 оны 1 дүгээр улирлаас тогтвортой байх, алгуур өсөх хандлагатай болов.

Дүрслэл 1.29

M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

M2 мөнгийг актив талаас нь харвал банкны салбарын зээл он гарсаар тогтмол өсөлттэй байна. Тухайлбал, 2013 оны 8 дугаар сарын байдлаар зээлийн өрийн үлдэгдэл жилийн 47 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 10 нэгж хувиар илүү байна. Энэ нь нэг талаас эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийн эерэг нөлөөлөл болон эдийн засгийн идэвхжилийг дэмжих арга хэмжээний үр дүнгээр голлон тайлбарлагдаж байна.

Дүрслэл 1.30

Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага



Эх сурвалж: Монголбанк.




Экспортын орлого 2013 он гарснаар буурч, урсгал тэнцлийн алдагдал өссөн, мөн гадаадын хөрөнгө оруулалт буурснаар гадаад цэвэр актив (ГЦА) энэ оны 8 дугаар сарын байдлаар 2.3 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 12 хувиар буурсан байна.

Манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох зэс, алт, нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ унаж, БНХАУ-ын дотоод эрэлт буурснаас шалтгаалан экспортын орлого хуримтлагдсан дүнгээр өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурсан, нөгөө талаас Монгол Улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оны эхний хагасын байдлаар 40 гаруй хувиар буурсан нь ГЦА-ын бууралтад шууд нөлөөллөө.

**Дүрслэл 1.31**

**Банкуудын хадгаламж болон зээлийн хүү\***




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*2012 оны 12 дугаар сараас хойш Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулан тооцсон хүү болно. Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

2012 оны эхний улиралд зээлийн хүү 2.9 нэгж хувиар өсч, хадгаламжийн хүүтэй харьцуулсан хүүний зөрүү 7.6 хувьд хүрч байв. Харин 2013 оны 8 дугаар сард уг зөрүү 3.8<sup>9</sup> хувь болж буурсан байна.

<sup>9</sup> Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулж тооцсон тооцоо.

**Дүрслэл 1.32**

**Банк хоорондын захын хүү**




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

Монголбанкнаас 2013 оны 2 дугаар сард олон улсын туршлагад суурилан “хүүний коридор”-ыг шинээр нэвтрүүлж, мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг боловсронгуй болгосноор богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой алхам болсон.

**Дүрслэл 1.33**

**Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал\***



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Банк хоорондын захын хүүнүүдийн жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

“Хүүний коридор” нэвтрүүлсэн буюу 2013 оны 2 дугаар сараас хойшхи хугацаанд богино хугацаат хэлцлийн хүүнүүд бодлогын хүүнээс +/-2 хувийн дотор хэлбэлзэж байна.

Тухайлбал, 2013 оны 6 дугаар сард Монголбанкны бодлогын хүү 10.5 хувь болж буурсан үед овернайт хүү 11.3 хувь, репо хүү 10.4 хувь болсон байна.

## Шигтгээ №2

### Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр

Монгол Улсад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн механизм олон жилийн турш үр ашиг муутай, тогтвортой бус байснаас нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляци байнга өндөр байсаар ирсэн юм.

Иймд Монголбанк инфляцийг бууруулж, иргэдийн бодит орлогыг хамгаалах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах замаар гол нэрийн бараа

## Хүснэгт 1.5

### Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн санхүүжилт (тэрбум төгрөг)

Дэд хөтөлбөрүүд	Зорилго	Баталсан баримт бичиг*	Баталсан огноо	Хөтөлбөрийн зээл								Нийт									
				2012		2013															
				11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар		7 сар	8 сар							
Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах /SIFS/	Жижиглэнгийн газрын тосны бүтээгдэхүүний импортыг Монголбанкнаас тогтоосон хүүгээр санхүүжүүлэх, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах замаар шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгах	Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын хамтарсан тушаал	2012/10/26	16	78		12		58	27										191	
Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах /TLF/	Гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах	Монголбанкны Ерөнхийлөгч, Зам, тээврийн сайдын хамтарсан тушаал	2012/10/26					22												22	
Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах /FPS/	Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах ойрын зорилттой, хүнсний бараа бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоо бүрдүүлэх хэтийн зорилготой	Монголбанкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаал	2012/10/26	30	57															87	
					24	4	10	3	2										7		49
Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах /HPS/	Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах замаар орон сууцны үнэ болон орон сууцны түрээсийн үнийг тогтвортой байлгах, иргэдийн эрүүл, аюулгүй орчин дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх	Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаал	2013/01/09						59	59	20	5								143	
									104	13	13										129
<b>Нийт</b>				<b>46</b>	<b>159</b>	<b>4</b>	<b>22</b>	<b>25</b>	<b>60</b>	<b>190</b>	<b>72</b>	<b>40</b>	<b>5</b>							<b>621</b>	

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \* 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Засгийн газар, Монголбанк хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

\*\* Барилгын материалын дотоодын үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээл.

\*\*\* Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын импортын санхүүжилт.

Хөтөлбөрийн зээлүүд нь хуваарийн дагуу эргэн төлөгдөж байгаа болно.

бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, улмаар зах зээлийн зарчимд суурилсан, бараа бүтээгдэхүүний хангамжийн байнгын, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Засгийн газартай хамтарсан бодлогыг 2012 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.1-д “...Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална.” гэж заасны зэрэгцээ Улсын Их Хурлын 2012 оны 57 дугаар тогтоолын 3 дахь заалтад “Иргэдийн өргөн хэрэглээний гол бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авч, үнийг тогтворжуулах цогц механизм боловсруулж хэрэгжүүлэхийг Монголбанк болон Засгийн газарт тус тус даалгасны дагуу “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн билээ.

Ийнхүү Монголбанкнаас эдийн засгийг тогтворжуулах бодлогын арга хэмжээний хүрээнд Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийн үр дүнд 2012 оны эцэст 14 хувь байсан жилийн инфляци 2013 оны 8 дугаар сарын байдлаар 9.4 хувь болж буурсны зэрэгцээ ДНБ-ий бодит өсөлт 2013 оны 2 дугаар улиралд 14.3 хувь, 2013 оны эхний 3 улирлын байдлаар 11.5 хувьтай гарахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээд байна. Өөрөөр хэлбэл энэхүү хөтөлбөр нь иргэдийн суурь хэрэглээний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сааруулах замаар бодит орлогыг хамгаалахын сацуу эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалахад чухлаар нөлөөлсөн юм.

## УЛСЫН ТӨСӨВ

## Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

2013 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 96.4 хувь, нийт зарлага 76.5 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд төсвийн нийт тэнцэл 131.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 973 тэрбум төгрөгөөр бага байна.

Гадаад эдийн засгийн нөхцөл тааламжгүй байсан, дотоодын эдийн засгийн идэвхжил 2011-2012 онтой харьцуулахад буурсан, гадаад худалдааны эргэлт багассан зэрэг нь төсвийн орлого бүрдэлтэд бодитой эрсдэл бий болгож байгаа ч, анхнаасаа төсвийн орлогыг хэт өөдрөг төлөвлөсөн нь төсвийн орлого тасрах гол хүчин зүйл болов.

## Хүснэгт 1.6

## Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2013 оны 8 сар			
		*	**	**/*	**/*
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>7 256</b>	<b>3 677</b>	<b>3 484</b>	<b>95%</b>	
Тогтворжуулалтын сан	170	98	34	35%	
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>7 086</b>	<b>3 579</b>	<b>3 450</b>	<b>96%</b>	
<b>А. Урсгал орлого</b>	<b>7 086</b>	<b>3 577</b>	<b>3 450</b>	<b>96%</b>	
<i>I. Татварын орлого</i>	<i>6 305</i>	<i>3 214</i>	<i>3 031</i>	<i>94%</i>	
1. Орлогын албан татвар	1 261	753	672	89%	
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	864	482	402	83%	
1.2. Хүн амын орлогын албан татвар	398	271	270	100%	
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	730	424	528	125%	
3. Өмчийн татвар	24	18	22	117%	
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	2 573	1 249	1 184	95%	
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 940	946	874	92%	
4.2. Онцгой албан татвар	595	274	280	102%	
4.3. Тусгай зориулалтын орлого	37	29	30	102%	
5. Гадаад худалдааны орлого	575	232	232	100%	
6. Бусад татвар	1 141	537	393	73%	
<i>II. Татварын бус орлого</i>	<i>781</i>	<i>363</i>	<i>419</i>	<i>115%</i>	
<b>Б. Хөрөнгийн орлого</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>35%</b>	
<b>В. Тусламжийн орлого</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө

\*\*Урьдчилсан гүйцэтгэл.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 87.8 хувь нь татварын орлогоор, 12.1 хувь нь татварын бус орлогоор тус тус бүрджээ. Татварын орлогын бүрэлдэхүүнд багтах аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 80.2 тэрбум төгрөгөөр,

дотоодын бараа үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар 72.4 тэрбум төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 83.7 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 128.5 тэрбум төгрөгөөр тасрахад хүргэв.

Энэ оны эхний 8 сарын байдлаар “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос нийт 34.3 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын сангийн дансанд төвлөрүүлжээ.

## Хүснэгт 1.7

## Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, үндсэн бүрэлдэхүүнээр (тэрбум төгрөг)

Төсвийн орлого	УТ*	ОНТ*	ХХС*	НДС*
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>2 412</b>	<b>1 149</b>	<b>173</b>	<b>834</b>
Тогтворжуулалтын сан	34	0	0	0
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>2 378</b>	<b>1 149</b>	<b>173</b>	<b>834</b>
<b>А. Урсгал орлого</b>	<b>2 311</b>	<b>437</b>	<b>173</b>	<b>619</b>
<i>I. Татварын орлого</i>	<i>1 932</i>	<i>397</i>	<i>173</i>	<i>619</i>
1. Орлогын албан татвар	402	270	0	0
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	402	0	0	0
1.2. Хүн амын орлогын албан татвар	0	270	0	0
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0	0	0	0
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0	0	0	619
3. Өмчийн татвар	0	22	0	0
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1 160	23	0	0
5. Гадаад худалдааны орлого	232	0	0	0
6. Бусад татвар	139	82	173	0
<i>II. Татварын бус орлого</i>	<i>379</i>	<i>40</i>	<i>0</i>	<i>0</i>
<b>Б. Хөрөнгийн орлого</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>В. Тусламжийн орлого</b>	<b>67</b>	<b>712</b>	<b>0</b>	<b>216</b>

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*УТ- Улсын төсөв, ОНТ- Орон нутгийн төсөв, ХХС-

Хүний хөгжил сан, НДС- Нийгмийн даатгалын сан.

## Улсын төсвийн орлогын гүйцэтгэл

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2.38 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 6.2 хувиар буюу 158.1 тэрбум төгрөгөөр дутуу байна. Дотоодын бараа, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 72.4 тэрбум, аж ахуй нэгж байгууллагын

орлогын албан татварын орлого 80.2 тэрбум, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 25.1 тэрбум, төсөвт байгууллагуудын орлого 26.5 тэрбум, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого 17.5 тэрбум төгрөгөөр тус тус тасарчээ. НӨАТ-ын буцаан олголтоор 56.2 тэрбум төгрөг олгосон байна.

### Орон нутгийн төсвийн орлого

Орон нутгийн төсвийн орлого 1.15 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 4.8 хувиар буюу 57.4 тэрбум төгрөгөөр бага байна.

### Хүний хөгжил сангийн орлого

Хүний хөгжлийн санд 173 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 31.4 хувиар буюу 79.3 тэрбум төгрөгөөр бага

байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 58.6 тэрбум, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн орлого 20.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэнтэй холбоотой.

### Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын сангийн орлого 834.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 9.1 хувиар буюу 69.5 тэрбум төгрөгөөр давжээ. Энэ нь орон сууцны ипотекийн санхүүжилтийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлж байгаатай уялдан дундаж давхаргын хуримтлал нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээл илүү тунгалаг болж байгаатай холбоотой юм. Тус санд улсын төсвөөс 215.7 тэрбум төгрөгийн татаасыг олгосон байна.

## Төсвийн зарлагын гүйцэтгэл

2013 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 4.68 их наяд төгрөг байхаар төлөвлөгдсөнөөс 3.58 их наяд төгрөг буюу 76.5 хувь, улсын төсвийн зарлага 3.65 их наяд төгрөг төлөвлөгдсөнөөс 2.82 их наяд төгрөг буюу 77.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

### Хүснэгт 1.8

#### Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	2012 оны	2013 оны эхний 8 сар		
	эхний 8 сар	*	**	**/*
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>3 583</b>	<b>4 683</b>	<b>3 581</b>	<b>76%</b>
<b>Урсгал зардал</b>	<b>2 761</b>	<b>3 307</b>	<b>2 816</b>	<b>85%</b>
1. Бараа, үйлчилгээний зардал	1 197	1 730	1 440	83%
1.1. Цалин хөлс	722	943	898	95%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	66	89	82	92%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	476	787	542	69%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	63	213	129	60%
3. Татаас ба шилжүүлэг	1 501	1 364	1 247	91%
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>780</b>	<b>1 298</b>	<b>718</b>	<b>55%</b>
1. Дотоод эх үүсвэрээр:	758	1 172	499	43%
2. Гадаад эх үүсвэрээр:	22	126	219	174%
<b>Эргэж төлөгдөх цэвэр зээл</b>	<b>42</b>	<b>78</b>	<b>47</b>	<b>60%</b>
<b>Тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл</b>	<b>329</b>	<b>270</b>	<b>634</b>	<b>235%</b>
<b>Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл</b>	<b>-482</b>	<b>-1 104</b>	<b>-131</b>	<b>12%</b>

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө

\*\*Урьдчилсан гүйцэтгэл.

Ийнхүү төсвийн зардал төлөвлөгөөнөөс дутуу биелэхэд бараа, үйлчилгээний бусад зардал 244.5 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 84.2 тэрбум төгрөгөөр, татаас ба шилжүүлэг 116.6 тэрбум төгрөгөөр, дотоод эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын зардал 621.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелэлттэй байсан нь нөлөөлөв.


### Улсын төсвийн зарлага

Улсын төсвийн халамжийн сангаас алдар цолтой ахмад дайчдын тэтгэмжид 3.9 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд 30.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Хотын нийтийн тээврийн татаас 37 тэрбум, эрчим хүч, дулааны алдагдлын татаас 24.6 тэрбум, улаан буудайн татаас 12.7 тэрбум, махны татаас 5.2 тэрбум, засгийн газрын нөөц хөрөнгийн зардал 9.1 тэрбум, их дээд сургууль коллежийн оюутны тэтгэлэг 63 тэрбум, улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний

санхүүжилт 349.6 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 107.9 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 503 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 100.6 тэрбум төгрөгийн Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг тус тус орон нутагт олгоод байна.

### Дүрслэл 1.34

Нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook)” тайлан, 2013 оны 4 дүгээр сар, Сангийн яам.

### Орон нутгийн төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага 968.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 73.5

хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгаас улсын төсөвт 8.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь 33.2 хувийн биелэлттэй байна.

### Хүний хөгжил сангийн зарлага

Хүний хөгжил сангийн зарлага 185.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 149.5 тэрбум, иргэн бүрт олгох 21000 төгрөгийн санхүүжилтээр 27.4 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

### Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 97.8 хувийн буюу 694.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 58.1 тэрбум төгрөгийн татаасыг олгосон байна.

### Эргэж төлөгдөх цэвэр зээл

Улсын төсвөөс 0.7 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 13.7 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг барагдуулсан байна. Гадаадын зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөр 13.2 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрчээ.

### Төсвийн тэнцэл


Тайлант хугацаанд гадаад зээлийн үндсэн төлбөрт 54.6 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 1.7 тэрбум, Засгийн газрын богино хугацаат бондын үндсэн төлбөрт 1 их наяд төгрөгийг тус тус төлж, 236.5 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, Засгийн газрын 1.1 их наяд төгрөгийн богино хугацаат, 400 тэрбум төгрөгийн урт хугацаат бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байна. Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 633.5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 131.2 тэрбум

төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 110 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 439.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн гүйцэтгэлийг өмнөх оны эхний 8 сарын гүйцэтгэлтэй харьцуулахад 351.9 тэрбум төгрөгөөр өссөн бол нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын гүйцэтгэл 2013 оны төсвийн тухай хуульд тусгагдсан орлого ба зарлагын дүнгийн тус бүр 48 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 9

жилийн байдлаарх хамгийн бага үзүүлэлт болж байна.

**Дүрслэл 1.35**

**Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл (Жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо.  
Тэмдэглэл: \*Эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэл.  
Жил бүрийн эхний 8 сарын орлого, зарлагын гүйцэтгэлийн нийт батлагдсан төсвийн орлого, зарлагад эзлэх хувийг тооцов.  
2011 оноос хойшхи нь тэнцвэржүүлсэн нийт тэнцэл болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь болно.

**Нэгдсэн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл**

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2013 онд төлөвлөсөн хэмжээнээс 1.5 их наяд төгрөг буюу 21 хувиар буурах төлөвтэй байна.

**Хүснэгт 1.9**

**2013 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (тэрбум төгрөг)**

Үзүүлэлтүүд	2013*	2013**	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7 088	5 597	-1 492	-21%
Урсгал орлого	7 087	5 596	-1 492	-21%
I. Татварын орлого	6 462	4 934	-1 528	-24%
1. Орлогын албан татвар	1 262	1 020	-241	-19%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	864	631	-233	-27%
1.2. Хүн амын орлогын албан татвар	427	419	-9	-2%
2. Нийгмийн даатгалын шивтгэл, хураамж	732	815	83	11%
3. Өмчийн татвар	24	24	-	0%
4. Дотоодын бараа, үйчилгээний татвар	956	789	-167	-17%
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	757	603	-155	-20%
4.2. Онцгой албан татвар	199	186	-13	-6%
5. Гадаад худалдааны орлого	2 231	1 629	-603	-27%
5.1. Импортын барааны онцгой албан татвар	397	259	-137	-35%
5.2. Импортын барааны НӨАТ	1 260	972	-288	-23%
5.3. Гаалийн албан татвар	575	398	-178	-31%
6. Бусад татвар, тусгай зориулалтын орлого	1 257	657	-599	-48%
6.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	566	482	-84	-15%
6.2. Бусад	691	175	-515	-75%
II. Татварын бус орлого	626	662	36	6%
Хөрөнгийн ба тусламжийн орлого	1	1	-	0%

Эх сурвалж: Сангийн яам.  
Тэмдэглэл: \*2013 оны төлөвлөгөө, \*\*Хүлээгдэж буй гүйцэтгэл.

Орлогын төлөвлөгөө буурахад дараах хүчин зүйлс голлох нөлөө үзүүлэхээр байна. Үүнд:


1. Эдийн засгийн өсөлт 2011-2012 онтой харьцуулахад саарсан;
2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого эрс багассан;
3. Импорт буурч байгаагаас зарим татварын орлого буурсан;
4. Гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом багасч, санхүүгийн эх үүсвэр буурах эрсдэлтэй байсан;
5. Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах замаар төсөвт 450 гаруй тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ гэж үндэслэл багатай төлөвлөлт хийсэн зэрэг болно.

**Нэг. Эдийн засгийн өсөлт:** 2011 оны 4 дүгээр улиралд 20.2 хувьд хүрч өндөр өсөлттэй гарсан бол 2012 оны дундаж өсөлт 12.4 хувь болж саарсан бөгөөд 2013 оны

эхний улирлын байдлаар 7.1 хувьд хүрч удааширч байв.

**Дүрслэл 1.36**

**Бодит ДНБ-ий жилийн өсөлт ба эхний 8 сараарх импортын жилийн өсөлт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ОУВС.  
Тэмдэглэл: 2013 оны бодит ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөллийг ОУВС-гийн 2013 оны 4 дүгээр сарын “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook)” тайлангаас авсан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн бодит өсөлт 11.3 хувьд хүрч, эргээд 2 оронтой тоонд ороод байна.


Нэрлэсэн ДНБ-ий өсөлт 2013 онд өмнөх жилүүд болон төлөвлөснөөс буурахаар байгаа, өсөлттэй байгаа салбаруудын татварын орлого дахь нөлөөлөл харьцангуй бага зэргээс шалтгаалан орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар болон эдийн засгийн өсөлтөөс хамаарсан бусад татварын орлогын гүйцэтгэл төсөвлөсөн хэмжээнээс 408.4 тэрбум төгрөгөөр буурахаар хүлээгдэж байсан.

**Хоёр. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт:** Монгол Улсын нийт экспортын 90 орчим хувь, төсвийн орлогын 20 гаруй хувь нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортоос хамаардаг бөгөөд цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспортоос төсвийн орлого шууд хамаарч, хэлбэлзэж байдаг.

Хэдийгээр Хятадын нүүрсний эрэлт, хэрэглээ өссөөр байгаа хэдий ч, Монгол Улсын нүүрсний экспорт буурсаар байна. Энэ нь тус салбар дахь өрсөлдөх чадвараа сайжруулах, экспортод аль болох баяжуулалт, боловсруулалт хийгдэж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах чиглэлд тодорхой алхмуудыг оновчтой авч хэрэгжүүлэхгүй тохиолдолд цаашид Монгол Улсын нүүрсний экспортын орлого үргэлжлэн буурах эрсдэлтэйг харуулж байна.

**Дүрслэл 1.37**

**Төсвийн зарлага, түүхий эдийн үнийн корреляци ба нийт төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ОУВС-гийн төсөөлөл “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook)” тайлан, 2013 оны 4 дүгээр сар, Блүмберг.  
Тэмдэглэл: 2001-2012 оны статистик ашиглан төсвийн зарлага болон бүтээгдэхүүн түүхий эдийн үнийн индекс(CRB)-ийн жилийн өсөлтийн хоорондох корреляцийг тооцов. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг 2012 оны байдлаар авсан болно.


Уул уурхайн бүтээгдэхүүн, түүний дотор алт, зэс, нүүрсний үнэ буурсаар байгаа тул уул уурхайн томоохон компаниудын үйлдвэрлэл болон ашигт ажиллагаа эрс буурч байна.

Үүний нөлөөгөөр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад татвар, төлбөр, хураамжаар төсөвт төвлөрөх орлого тус тус буурч байгаа юм.



**Дүрслэл 1.38**

**Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ ба БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ (эхний 8 сараар, сая тонн)**




Эх сурвалж: Блүмберг, Сангийн яам.

Энэ оны эхний 8 сарын байдлаар 9.5 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оны мөн үеийнхээс 2.8 сая тонноор бага буюу 22.8 хувиар буурсан үзүүлэлт юм.

**Дүрслэл 1.39**

**Нийт зарлага ба бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн индекс(CRB)-ийн жилийн өсөлт**



Эх сурвалж: Блүмберг, Сангийн яам.

Дээрх тоо хэмжээ нь аж ахуйн нэгжүүдийн уулын ажлын төлөвлөгөө болон нүүрсний экспортын төсвийн төлөвлөлтөд туссан хэмжээ (27.9 сая тонн)-тэй харьцуулахад маш доогуур үзүүлэлт юм.

Энэ оны үлдэж буй 4 сарын хугацаанд 8.2 сая тонн нүүрс экспортолж, жилийн дүнгээр нийт

17.7 сая тонн нүүрс экспортолно гэж тооцвол 2013 онд батлагдсан төсвийн төлөвлөгөөнөөс даруй 10.2 сая тонноор бага гүйцэтгэлтэй гарч, үүнээс шалтгаалан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 222.3 тэрбум төгрөгөөр буурах юм.

**Гурав. Импортын бууралт:** Нийт импортын хэмжээг эдийн засгийн өсөлттэй уялдуулан 2013 онд 9.6 тэрбум ам.доллар буюу өнгөрсөн 2012 оны гүйцэтгэлээс 43 хувиар нэмэгдүүлэн тооцсон боловч энэ оны эхний 8 сарын байдлаар 4.2 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн импортлоод байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.6 орчим хувиар буурсан үзүүлэлт бөгөөд оны эцэст төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байна.

Монгол Улсын импортын хэмжээг сүүлийн 10 жилийн хугацаанд судалж үзэхэд 2004-2008 онд үүссэн барилгын салбарын огцом өсөлт болон уул уурхайн төсөл арга хэмжээ эрчимжсэн зэрэг нь түүнийг дагасан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын зориулалттай нэг удаагийн шинжтэй импортын өсөлт 2010, 2011 онд хамгийн дээд түвшинд хүрэхэд нөлөөлсөн байна. Үүний дотор Оюутолгой төсөлтэй холбоотой бүтээн байгуулалтын ажлаас шалтгаалан импортын хэмжээ огцом өссөн.

Энэ оны эхний 8 сарын байдлаар импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 11 хувиар буураад байна.

Цаашид импортоос хамаарах нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвар, онцгой албан татварын нийт 638.8 тэрбум төгрөгийн орлого буурах тооцоотой байна.

**Дөрөв. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт:** 2013 оны эхний хагаст Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 42 хувиар буюу 1.04 тэрбум ам.доллараар огцом буурсан.

Үүнийг дагаад санхүүгийн эх үүсвэр хомсдох байдал үүсч, улмаар хувийн секторын бизнесийн үйл ажиллагаа саарч, татварын орлогыг бууруулах нөхцөлийг бий болгож байна.

**Тав. Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотойгоор хийсэн үндэслэлгүй төлөвлөлт:** Тус гэрээнд өөрчлөлт оруулах замаар төсөвт орлого төвлөрүүлнэ гэж үндэслэл муутай төлөвлөлт хийсний улмаас 2013 оны нэгдсэн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон 445.7 тэрбум төгрөг, үүнээс улсын төсөвт 290.9 тэрбум төгрөг, Хүний хөгжлийн санд 154.8 тэрбум төгрөгийн орлого тус тус тасрахаар байсан.

Ийнхүү гадаад, дотоодын эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран 2013 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 1.5 их наяд төгрөгөөр буурах төлөвтэй байсан тул дотоод нөөц бололцоогоо дайчлах замаар төсвийн орлогын бууралтыг нөхөх, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого буурахтай уялдан төсвийн зарлага, санхүүжилтийг зохицуулах зайлшгүй шаардлага тулгарсан.

Нэгдсэн төсвийн 2013 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг энэ оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, гадаад болон дотоодын эдийн засгийн нөхцөл байдал, экспортод гарах эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ зэрэг үзүүлэлтэд үндэслэн тооцоход 2013 оны нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал ДНБ-ий 6.8 хувьд хүрэхээр байсан тул Төсвийн тухай хуулийн 34.1.2 зүйлийн *“Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3*

*хувиар нэмэгдэх тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ”* гэсэн заалтын дагуу 2013 оны төсөвт тодотгол хийх нөхцөл байдал үүсч, улмаар “Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг УИХ-аар 2013 оны 10 дугаар сард баталсан.

Тодотгол хийгдсэн төсвөөр төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6.29 их наяд төгрөг болж, батлагдсан төсвөөс 799.2 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 6.63 их наяд төгрөг болж батлагдсан төсвөөс 814.8 тэрбум төгрөгөөр тус тус буурч нийт алдагдал 340.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэж байхаар тусгасан. 2013 оны 10 дугаар сарын байдлаар төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 4.46 их наяд төгрөг буюу 102 хувийн, нийт зарлага 4.64 их наяд төгрөг буюу 83.6 хувийн, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл -183 тэрбум төгрөг буюу 15.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь 2013 оны эцэст “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-нд заасан “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэсэн тусгай шаардлагыг хангахаар байна.

Улсын төсвийг үндэслэл муутай төлөвлөснөөс шалтгаалан төсвийн гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс эрс зөрүүтэй гарч, төсөвт тодотгол хийх явдал нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал, түүнд чиглэсэн мөнгөний бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг тул цаашид төсвийн төлөвлөлтийг сайжруулах шаардлага өндөрсөж байна.

# 2

## САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА


### 2.1 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

#### БАНКНЫ САЛБАР

Банкны салбарт 2013 оны хагас жилийн байдлаар 14 банк, 1401 салбар, нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.4 сая, зээлдэгчдийн тоо 650.8 мянгад хүрлээ.

#### Дүрслэл 2.1

Банкны салбарын нийт актив



Эх сурвалж: Монголбанк.

Төв банкнаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүд, харилцах, хадгаламжийн өсөлттэй уялдан нийт эх үүсвэрийн хэмжээ 13.7 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 34.6 хувь буюу 3.5 их наяд төгрөгөөр өсчээ. Эх үүсвэрийн хэмжээ өссөнөөр банкны салбарын нийт активын хэмжээ 15.1 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 31.9 хувиар буюу 3.6 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Нийт активын 25.6 хувийг мөнгөн хөрөнгө, 9.6 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 54.8 хувийг зээлийн өрийн

үлдэгдэл, үлдэх 10 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Банкуудын төлбөрийн чадварын үзүүлэлт сайжирч, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 43.8 хувьд хүрлээ. Банкууд төв банкин дахь харилцах, хадгаламжаа 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн нь мөнгөн хөрөнгийн хэмжээ 3.9 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 51.9 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өсөхөд нөлөөлөв. Нийт богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 1.4 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 22.5 хувиар буюу 265.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Банкуудын засгийн газрын үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ оны эхнээс 1.2 дахин нэмэгдэж 2013 оны эхний хагас жилийн байдлаар 701.4 тэрбум төгрөгт хүрлээ. Төв банкны үнэт цаасны хэмжээ 2013 оны эхэн үетэй харьцуулахад 12.1 хувиар буюу 92 тэрбум төгрөгөөр буурч 670 тэрбум төгрөгт хүрэв.


Нийт зээлийн үлдэгдэл 8.4 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 1.6 их наяд төгрөгөөр буюу 23.6 хувиар өслөө. Нийт зээлийн 96.2 хувь болох 8.1 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 1.8 хувь болох 148.4 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд ангилагдсан нь оны эхнээс хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өссөнийг харуулж байна. Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл бөөний болон

жигжлэнгийн худалдааны салбарт 17.8 хувь буюу 1.5 их наяд төгрөг, барилгын салбарт 14 хувь буюу 1.2 их наяд төгрөг, үл хөдлөх хөрөнгийн салбарт 13.7 хувь буюу 1.1 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлд эзлэх тухайн салбарын хувь хэмжээг өмнөх онтой харьцуулахад барилгын салбар 2.2 нэгж хувиар өссөн бол уул уурхайн салбар 1.8 нэгж хувиар буурчээ.

Зээлийн чанарын үндсэн үзүүлэлт болох чанаргүй зээлийн хэмжээ оны эхнээс 24.4 тэрбум төгрөгөөр буюу 16.5 хувиар өсч 172.3 тэрбум төгрөгт хүрэв. Чанаргүй зээлийн харьцаа 2 хувьд хүрч оны эхнээс 0.2 нэгж хувиар буурчээ. Зээл олголт хийгдсэн гол салбаруудын зээлийн чанарыг авч үзвэл барилгын салбарын зээлийн 1.7 хувь, уул уурхайн салбарын 3.4 хувь, бөөний болон жигжлэн худалдааны салбарын 2.4 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 3.1 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарын 0.8 хувь нь чанаргүй зээлд ангилагджээ. Онцгой нөхцөл байдлын шинжилгээнээс авч үзвэл хэвийн зээлийн 5 хувь нь чанаргүй болоход банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 1 нэгж хувиар буурахаар байна.

## Дүрслэл 2.2

### Банкны салбарын зээл



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Анод, Зоос банкныг хассанаар.

Харилцахын үлдэгдэл 2.7 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны эцсээс 14.8 хувиар буюу 343.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хувийн секторын харилцахын үлдэгдэл 20.4 хувиар буюу 230.8 тэрбум төгрөгөөр өсч 1.4 их наяд төгрөгт хүрлээ. Иргэдийн харилцахын үлдэгдэл 499.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны эцсээс 7.6 хувиар буюу 35.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэв.


Банкны салбарт хадгаламж эзэмшигч, харилцагчдын хөрөнгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталж, хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчин бүрдлээ. Олон улсад санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хадгаламжийг даатгалд хамруулж, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг эрсдэлгүй байлгах нь чухал ач холбогдолтой байдаг. Манай орны хувьд 2008-2012 оны хооронд төрөөс банкны харилцах, хадгаламжид баталгаа гаргахаар зохицуулж байсан бол 2013 оноос эхлэн хязгаарлагдмал хэмжээнд банкуудын хадгаламжийг даатгах тогтолцоог бүрдүүлж байна.

Банкны салбарын хадгаламжийн үлдэгдэл 2013 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 5.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 14.1 хувиар буюу 715.5 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Хувийн салбараас татсан хадгаламжийн хэмжээ 341.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 206.8 тэрбум төгрөгөөр буюу 37.7 хувиар буурсан байгаа бол нийт хадгаламжийн 69.8 хувийг бүрдүүлдэг иргэдийн хадгаламжийн хэмжээ 6.2 хувиар буюу 237.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 4 их наяд төгрөгт хүрэв.

Эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгө нь системийн хэмжээнд 1.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны эцсээс 10.9 хувиар буюу 138.1 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 12.4 хувиар буюу 0.9 их наяд төгрөгөөр нэмэгдэж 8.8 их наяд төгрөгт хүрлээ.

### Дүрслэл 2.3

Банкны салбарын харилцах, хадгаламж




Эх сурвалж: Монголбанк.

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар бүх банкуудад 2013 оны 5 дугаар сарын 1-ний дотор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16 тэрбум төгрөгт хүргэх шаардлагыг тавьсан. Тайлант хугацаанд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 51.1 тэрбум төгрөгөөр буюу 12.2 хувиар нэмэгдэж, 468.9 тэрбум төгрөгт хүрсэн,

банкуудын ашиг нэмэгдсэн нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Активын өгөөжийн үзүүлэлт 1.5 хувьд хүрч өнгөрсөн оны эцсээс 0.8 нэгж хувиар, өөрийн хөрөнгийн өгөөж 11.1 хувьд хүрч 4.1 нэгж хувиар буурчээ.

### Дүрслэл 2.4

Хадгаламжийн байгууллагуудын актив, пассив гарсан өөрчлөлт (2012 оны 12 сараас 2013 оны 8 сар)



Эх сурвалж: Монголбанк.

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

## Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал


## Ерөнхий төлөв байдал

2013 оны эхний хагас жилд Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар 21 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 22 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 1 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 233 ББСБ Санхүүгийн зохицуулах хорооноос

олгосон тусгай зөвшөөрлөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

## Дүрслэл 2.5

## Бүртгэлтэй Банк бус санхүүгийн байгууллагын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2013 оны эхний хагас жилийн байдлаарх статистикийн голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 2.1-д хураангуйлав.

## Хүснэгт 2.1

## Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны эхний хагас жил
1	ББСБ-ын тоо	233
	Үүнээс:	
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй	25
3	Гадаадын хөрөнгө оруулалттай	18
4	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй	39
5	Хувь нийлүүлэгчдийн тоо	617
6	Ажиллагсдын тоо	1 292
7	Салбар нэгжийн тоо	74
8	Харилцагчдын тоо	394 666
9	Нийт актив	307.7
	Банкны салбарт эзлэх хувь	1.9%
10	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	188.1
	Банкны салбарт эзлэх хувь	2.2%
11	Нийт эзэмшигчдийн өмч	198.7
	Банкны салбарт эзлэх хувь	17.4%
12	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/	161.0
	Банкны салбарт эзлэх хувь	45.0%
13	Нийт орлого	38.0
14	Нийт зардал	25.0
15	Тайлант үеийн ашиг	13.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тайлант хугацаанд 22 ББСБ шинээр үүсгэн байгуулагдан, 1 ББСБ хүчингүй болсноор нийт тусгай зөвшөөрөлтэй 233 ББСБ-ын 82 хувь нь зээл, 42.1 хувь нь гадаад валютын арилжаа (16.7 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг), 8.1 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл, өгөх, 2.1 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 5.6 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.9 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 7.7 хувь нь итгэлцлийн үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

## Хүснэгт 2.2

### Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо
1	Зээл	191
2	Гадаад валютын арилжаа	98
3	Иптэлцлийн үйлчилгээ	18
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	19
5	Факторингийн үйлчилгээ	13
6	Төлбөрийн баталгаа гаргах	9
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## Нийт актив

2006-2013 оны эхний хагас жил хүртэлх мэдээлэлд үндэслэж үзвэл нийт актив 2007 онд өмнөх оноос буурсныг эс тооцвол жил бүр өсөн нэмэгдсээр 2013 оны эхний хагас жилийн байдлаар 307.7 тэрбум төгрөгт хүрээд байна.

## Дүрслэл 2.6

### Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Нийт активын 59 хувь нь зээл, 26.1 хувь нь мөнгөн хөрөнгө байгаа буюу нийт активын 85.1 хувийг эзэлж байна.

## Зээлийн чанар

2013 оны эхний хагас жилийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн үлдэгдэл 35.2 хувиар өссөн. Үүнээс хэвийн зээл 34 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 81.9 хувиар, чанаргүй зээл 30.2 хувиар тус тус өссөн хэдий боловч зээлийн чанарт төдийлөн ахиц гараагүй юм (Дүрслэл 2.7).

## Дүрслэл 2.7

### Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## Зээлийн хүү

Зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 191 ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.7 хувь, зээлийн дундаж доод хүү 2.7 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.7 хувьд хүрэв.

## Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

2012 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 32 хувийг нийт өр төлбөр, 68

хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт өр төлбөр 35.4 хувь, эзэмшигчийн өмч 64.6 хувь болж өөрчлөгдсөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 43 хувиар, эзэмшигчдийн өмч 30.2 хувиар тус тус өссөн. 2013 оны эхний хагас жилд нийт эх үүсвэрт эзлэх өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 63.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 40.4 хувиар буюу 18.3 тэрбум төгрөгөөр, итгэлцлийн үйлчилгээний өглөг 17.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 31 хувиар буюу 4.2 тэрбум төгрөгөөр, бусад пассив 13.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.1 дахин буюу 7.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой юм. Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болов. Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэй уялдан дүрмийн сан өсч байна. ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

2013 оны эхний хагас жилийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.7 хувийг, тэдгээрийн актив ББСБ-ын нийт активын 36.3 хувийг, эзэмшигчийн өмч нь ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчийн 31.5 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант хугацаанд 17.8 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээний өглөг бүртгэгджээ.

### Хүснэгт 2.3

#### Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013Н1
Нийт актив	69.2	66.4	78.5	96.5	128.6	205.4	252.1	307.7
Нийт олгосон тээл	30.3	35.4	46.4	55.5	78.1	119.0	157.8	188.1
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	69.2	66.4	78.5	96.5	128.6	205.4	252.1	307.7
Нийт өр төлбөр	21.5	18.4	23.5	21.6	36.6	67.2	80.7	109.0
Эзэмшигчдийн өмч	47.7	48.1	55.0	74.8	92.0	138.2	171.3	198.7
Үүнээс:								
Хувьцаат капитал	43.5	41.8	46.7	66.4	80.0	116.5	137.9	161.0
Бусад өмч	0.1	0.0	0.6	0.5	0.5	3.2	7.6	6.6
Сангууд	1.1	1.1	1.1	1.1	1.1	1.1	0.1	0.2
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1.9	4.0	6.2	6.1	9.4	14.7	24.2	29.1
Хоёрдогч өглөг	0.8	0.5	0.4	0.8	0.9	2.7	1.6	1.8
Нийт орлого	9.1	13.8	18.8	26.6	30.1	46.3	70.5	38.0
Нийт зарлага	7.8	11.1	14.9	21.7	22.9	34.9	51.9	25.0
Татварын дараах цэвэр ашиг	1.3	2.7	3.9	4.9	7.1	11.4	18.6	13.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ байгаагаас 2013 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд 1.7 тэрбум төгрөгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын өглөг бүртгэгдсэн.

2013 оны эхний хагас жилийн байдлаар хоёрдогч өглөгтэй 7 ББСБ байгаагаас 1.8 тэрбум төгрөгийн өглөг тэдгээрт бүртгэлтэй байна.

СЗХ-ны 2010 оны 199 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг батлан мөрдөж эхэлсэн ба энэхүү журмыг 2012 оны 248 дугаар тогтоолоор хүчингүй болгож “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичиг бүртгэх журам”-ыг шинэчлэн баталж, мөн оны 346 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хаалттай өрийн бичгийн зөвшөөрөлтэй 3 ББСБ нь (“Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК-д 800 сая төгрөг, “Хөгжил финанс ББСБ” ХХК-д 600 сая төгрөг, “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-д 1.6 тэрбум төгрөг) нийт 3 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргахаар СЗХ-нд бүртгүүлсэн боловч 2013 оны эхний хагас жилийн байдлаар “Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК нь 376 сая



төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргаад байна.

### Орлого, зарлага, ашигт ажиллагаа

2013 оны эхний хагас жилийн байдлаар 233 ББСБ нийт 12.9 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55.9 хувиар өссөн, тайлант хугацаанд нийт орлого 27.2 хувиар, зардал 16.1 хувиар тус тус өслөө. Тайлант хугацааны нийт орлогын 77.3 хувийг хүүгийн орлого (өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.2 хувиар өссөн), 21.2 хувийг хүүгийн бус орлого (өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар буурсан) тус тус эзэлж байна.

#### Хүснэгт 2.4

##### Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)

	Үзүүлэлтүүд	2013 оны эхний хагас жил
<b>1</b>	<b>Нийт орлого</b>	<b>38.0</b>
1.1	Хүүгийн орлого	29.3
1.2	Хүүгийн бус орлого	8.0
1.3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0.6
1.4	Ердийн бус орлого	0.0
<b>2</b>	<b>Нийт зардал</b>	<b>25.0</b>
2.1	Хүүгийн зардал	4.0
2.2	Хүүгийн бус зардал	17.4
2.3	Болзошгүй эрсдэлийн зардал	1.6
2.4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.4
2.5	Ердийн бус зардал	0.0
<b>3</b>	<b>Орлогын татварын зардал</b>	<b>1.6</b>
<b>4</b>	<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>13.0</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 29.6 хувийг гадаад валютын арилжааны орлого, 47.3 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 23.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 20.3 хувийг гадаад валютын арилжааны орлого, 45.4 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 34.3 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өссөнөөс хүүгийн зардал 34.2 хувиар, хүүгийн бус зардал 11 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 26.4 хувиар, орлогын татварын зардал 50.9 хувиар тус тус өсч, үндсэн бус үйл ажиллагааны болон ердийн бус зардал 22.8-38.7 хувиар буурав. Тайлант хугацаанд 184 ББСБ буюу нийт ББСБ-ын 79 хувь нь ашигтай ажиллаж тэдгээрийн нийт ашиг 13 тэрбум төгрөгт хүрлээ.

### Салбарын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 189 ББСБ бүрэн хангаж ажилласан, 44 ББСБ 1-3 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байгаагаас 1 харьцааг хангаж ажиллаагүй 19 ББСБ, 2 харьцааг хангаж ажиллаагүй 18 ББСБ, 3 харьцааг хангаж ажиллаагүй 7 ББСБ байв. Санхүүгийн тайлангийн нэгтгэлээр СЗХ-ны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- ◆ Нийт өөрийн хөрөнгө 198.7 тэрбум төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 229.5 тэрбум төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 85.6 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 91.2 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 63.8 хувь;
- ◆ Түргэн борлогдох актив 72.6 тэрбум төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 76.5 тэрбум төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 94.8 хувь;

- ♦ Валютын дансны цэвэр зөрүү 12 тэрбум төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 198.7 тэрбум төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 6.04 хувь;
- ♦ Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 17.8 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 198.7 тэрбум төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.98 хувь;

- ♦ Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 4.1 тэрбум төгрөг, нийт актив 307.7 тэрбум төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.3 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.
- ♦ Харин активын эрсдэлийн санг 5.3 тэрбум төгрөгөөр байгуулбал зохихоос 42.5 сая төгрөгөөр илүү буюу нийт 5.3 тэрбум төгрөгөөр байгуулсан байна.

### Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал


#### Ерөнхий төлөв байдал

СЗХ-ны хуралдаанаар 2 хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 17 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2013 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 142 ХЗХ СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ажиллагаа эрхэлж буй Хасбанктай франчайзын гэрээтэй 15 ХЗХ-нд 267 сая төгрөг, салбарын хэмжээнд нийт 18 ХЗХ-нд 1.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 82.7 сая төгрөгөөр буурав.

#### Дүрслэл 2.8

##### Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тайлант улиралд Банк болон ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн үлдэгдэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 3 ХЗХ-нд 1.1 тэрбум төгрөг, орон нутагт үйл

#### Хүснэгт 2.5

##### Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (сая төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны I хагас
1	ХЗХ-дын тоо	142
2	Гишүүдийн тоо	26 422
3	Нийт актив	71 855
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	56 425
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1 566
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	49 553
	Банкны салбарт эзлэх хувь	1.0%
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	9 696
	Банкны салбарт эзлэх хувь	3.0%
8	Нийт хөршоологчдын өмчийн үлдэгдэл	6 958
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	1 351
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	519
11	Нийт орлого	8 439
12	Нийт зардал	6 581
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	1 859

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.4 хувиар буюу 7.4 тэрбум төгрөгөөр өслөө. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.4 хувиар буюу 7.1 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

### Хүснэгт 2.6

#### Хадгаламж, зээлийн хоршоодын салбарын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013Н1
Нийт актив	15.6	35.6	41.7	44.6	48.8	61.9	67.7	71.9
Нийт олгосон зээл	13.6	19.3	32.4	32.2	34.9	41.5	48.3	56.4
Татан төвлөрсөн хадгаламж	11.4	25.9	27.7	29.9	34.8	43.8	47.1	49.6
Хувь нийлүүлсэн хоршоо	2.9	6.5	7.7	7.4	7.4	8.4	9.4	9.7
Хориологчдын өмч	0.8	0.8	3.2	4.5	3.9	4.8	6.9	7.0
Нийт орлого	6.4	10.5	12.7	14.5	12.5	13.4	16.5	8.4
Нийт зарлага	6.6	8.2	10.8	12.7	11.0	11.2	12.7	6.6
Нийт ашиг	-0.2	2.3	1.9	1.8	1.5	2.2	3.8	1.9


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Зээлийн чанар

2013 оны эхний хагас жилийн байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 56.4 тэрбум төгрөг байгаа нь активын 78.5 хувьтай тэнцэж байна.

### Дүрслэл 2.9

#### Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Цэвэр зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.9 тэрбум төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл 0.5 тэрбум төгрөгөөр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

### Ашигт ажиллагаа

2013 оны эхний хагас жилийн байдлаар ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 185 сая төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 480 сая төгрөгөөр тус тус өсч, ашиг нь 1.9 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 295 сая төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Нийт 142 ХЗХ-дын 126 ХЗХ буюу 88.7 хувь нь 1.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 16 ХЗХ буюу 11.3 хувь нь 64 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### Ерөнхий төлөв байдал

2013 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 125 удаагийн арилжаагаар 122 компанийн 21.9 сая ширхэг хувьцааг 12.3 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувьцааны арилжааны үнийн дүн 48.6 тэрбум төгрөгөөр буюу 79.8


хувиар буурсан бөгөөд компанийн бондын болон анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. Үнэт цаасны арилжааны дүн өмнөх оны мөн үеийнхээс буурсан шалтгаан нь 2010 онд төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмшүүлэхтэй холбогдон иргэд хуучнаар “Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг”-ээр

эзэмшсэн хувьцаагаа худалдах ажиллагаа идэвхжисэн, үүнээс үүдэн бүртгэлтэй байгаа нээлттэй компаниудын хяналтын багц, цөөн тооны этгээдүүдийн гарт төвлөрсөн, зах зээлд хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгдэхгүй байгаа, үнэт цаасны зах зээлийн талаарх иргэд аж ахуйн нэгжүүдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас ихээхэн шалтгаалж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос өмч хөрөнгө нь үрэгдсэн, 90 дээш хувь төвлөрсөн 6 компанийг бүртгэлээс хасах ажлыг хийв.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2012 оны 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах тухай журам”-ыг баталж, 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн Засгийн газрын үнэт цаас нь Монголбанкны дэд бүтцээр арилжигдах болсон.

**Дүрслэл 2.10**

**Монголын хөрөнгийн биржийн арилжааны дүн болон хэлцлийн тоо**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зах зээлийн нийт үнэлгээ 2013 оны эхний хагас жилийн байдлаар 1 их наяд 438 тэрбум төгрөг хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 457.4 тэрбум төгрөгөөр буюу 24.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт үнэлгээний 86.3 хувийг 30 компани дангаар бүрдүүлжээ.

**Дүрслэл 2.11**

**ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 18301.9 нэгж, доод үзүүлэлт 13188.5 нэгж, дундаж үзүүлэлт 15734.7 нэгж байв. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5168.3 нэгжээр буюу 26.5 хувиар буурч 14363.3 нэгж байна.

ТОП-20 индексийн бууралтад индексийн сагсанд багтдаг Таван толгой (60.1%), Монголын цахилгаан холбоо (45.5%), Монгол шилтгээн (21%), Шивээ овоо (20%), Хөх ган (17.6%), Монголиа девелопмент ресорсес (12.9%), БиДиСек (12%), Ремикон (10.1%), Багануур (6.2%), АПУ (5.3%) зэрэг ХК-иудын үнэт цаасны ханш буурсан нь нөлөөлжээ.

**Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн мэдээлэл**

2013 оны эхний хагас жилийн байдлаар “ҮЦТТТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжийн дансаар 113 харилцагчийн

дансанд 914 удаа 608 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ, 721 харилцагчийн 880

удаагийн гүйлгээгээр 210 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус гүйцэтгэсэн байна.

Мөн хугацаанд төлбөр тооцоо гүйцэтгэх арилжааны дөрвөн банкаар 6.2 тэрбум төгрөгийн арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэсэн бөгөөд үүнээс Голомт банкаар 2.5 тэрбум, Худалдаа хөгжлийн банкаар 1.8 тэрбум төгрөг, Хасбанкаар 1.7 тэрбум төгрөг, ХААН банкаар 230 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн.

Тайлант хугацаанд нийт 63 брокер, дилерийн компани 873 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд, 66 брокер, дилерийн компани 381 сая төгрөгийг төлбөрийн баталгааны сангийн дансанд тус тус байршуулаад байна. Арилжааны үнийн дүнд гадаад аж ахуйн нэгжийн 50 хувь, дотоодын аж ахуй нэгж 17 хувь, гадаадын иргэн 10 хувь, дотоодын иргэн 23 хувийг тус эзэлж байна.

Төвлөрсөн хадгаламжид данс нээсэн байдлыг авч үзвэл дотоодын иргэн 6091 ширхэг, гадаадын иргэн 62 ширхэг, дотоодын аж ахуйн нэгж 52 ширхэг, гадаадын аж ахуйн нэгж 5 данс нээлгэв.

### Хүснэгт 2.7

Үнэт цаас төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд нээгдсэн дансдын мэдээлэл

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013НН
Холболтын данс	2 202	4 449	3 512	1 086	3 528	14 660	8 577	1 054
ХОЭБ-ийн данс	20 579	20 579	19 077	8 240	4 846	5 569	95 278	0
Шинэ данс	2 304	50 221	2 654	671	1 310	108 909	105 616	4 959
Нийт данс	25 085	75 249	25 243	9 997	9 684	129 138	200 894	6 013

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойшхи хугацаанд төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр 772396 данс нээгдээд байна.

### Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчид

2013 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн брокер, дилерийн 94, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 18 компани байна.


Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос нийтдээ 3 компанид брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ.

Түүнчлэн 2 компанид нэмэлт тусгай зөвшөөрөл, 1 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 6 компанийн тусгай

зөвшөөрлийг сунгах тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарчээ.

### Дүрслэл 2.12

Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Мөн энэ хугацаанд нийт 10 компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт

оруулах, 15 компанийн гүйцэтгэх захирлыг томилох, 1 компанийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарсан.

СЗХ-ноос 2013 оны эхний хагас жилийн байдлаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг

түргэтгэх, иргэдэд брокер, дилерийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх чиглэлээр орон нутагт салбар байгуулахыг дэмжиж ажилласан бөгөөд 2 компани Дархан-Уул, Эрдэнэт зэрэг 2 аймагт салбарын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгосон байна.

### Хувьцаат компани

2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт 326 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэйгээс, төрийн өмчийн 23, төрийн өмчийн оролцоотой 30, хувийн өмчийн 273 хувьцаат компани байна.


Санхүүгийн зохицуулах хороо 2006-2007 онд бүртгэлтэй хувьцаат компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийж үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон, компанийн өмч хөрөнгө үрэгдсэн нийт 165 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зогсоосон. Үүнээс 2013 оны эхний хагас жилийн байдлаар тэдгээр компаниудын 22 нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж, 21 нь арилжаагаа сэргээж, 9 компани татан буугдав.

Үнэт цаасны бүртгэлийн тухайд 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт гурван компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасах, СЗХ-ноос 2 компанийн үнэт цаасны арилжааг сэргээх, 3 компанийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөлт оруулах тогтоол батлагджээ.

2013 онд эхний хагас жилийн байдлаар Компанийн тухай хуулиар хүлээсэн үндсэн үүргүүд болох хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулсан болон санхүүгийн тайлангаа ирүүлж олон нийтэд мэдээлсэн компанийн тоо өмнөх жилүүдээс эрс өссөн дүнтэй байна.

### Дүрслэл 2.13

Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Хувьцаат компанийн ногдол ашиг тараалт

2013 онд эхний хагас жилийн байдлаар нийт 26 хувьцаат компани ногдол ашиг тараах шийдвэрийг гаргажээ. 2012 оныг хүртэл хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилсан ногдол ашгийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна.

**Дүрслэл 2.14**

**Хувьцаат компаниудын ногдол ашиг хуваарилалт**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГА**

**Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл**

2013 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 240 даатгалын салбар, 3227 даатгалын төлөөлөгч, 20 даатгалын зуучлагч компани, 11 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3290 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.

хүчингүй болгож, 3 даатгалын зуучлагч компани, 2 даатгалын хохирол үнэлэгч компани тус тус нэмж мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар 2.6 дахин өслөө.

**Хүснэгт 2.8**

**Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013нI
Даатгагч	16	18	17	17	18	17
Даатгалын компанийн салбар	120	129	138	188	213	240
Даатгалын төлөөлөгч	1167	1676	2061	2057	2357	3227
Даатгалын зуучлагч	4	5	9	8	17	20
Даатгалын хохирол үнэлэгч	-	2	6	9	9	11
Актуарч	9	10	12	13	18	15
<b>Дүн</b>	<b>1196</b>	<b>1711</b>	<b>2105</b>	<b>2104</b>	<b>2419</b>	<b>3290</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын зах зээл дэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо энэ оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 1.1 дахин өссөн байна. Тайлант хугацаанд 1 компанийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг

**Даатгагчийн хөрөнгө**


2013 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 113.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.6 тэрбум төгрөг буюу 1.1 дахин өссөн байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 3 дахин нэмэгдсэн нь даатгалын компаниудын дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх СЗХ-ны бодлоготой холбоотой юм.

Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2012 оны 2 дугаар улиралд 80.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 82.6

хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 17.0 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.3 хувийг эзэлж байсан бол тайлант онд эргэлтийн хөрөнгө 96.3 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 85 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 15 хувийг эзэлж байна.

### Дүрслэл 2.15

#### Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ



Үзүүлэлтүүд	2012.06.30		2013.06.30		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	80.7	83%	96.3	85%	15.6	2.0
Эргэлтийн бус хөрөнгө	17.0	17%	17.0	15%	0.0	-2.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>97.7</b>	<b>100%</b>	<b>113.2</b>	<b>100%</b>	<b>15.5</b>	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 2.4 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс буурч, эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин нэмэгдсэн байна. Үүнд богино хугацаат хөрөнгө оруулалт, банкны хадгаламж, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт нөлөөлсөн.

2013 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 59.8 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 23.3 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 14.3 хувийг дансны авлага, үлдэх 2.6 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна.

### Хүснэгт 2.9

#### Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013H1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	23.5	34.2	39.0	51.9	57.6
Богино хугацаат хөрөнгө оруулалт	8.0	8.6	18.5	24.8	22.4
Дансны авлага	3.8	3.8	7.2	9.8	13.8
Бусад эргэлтийн хөрөнгө	1.0	0.7	0.8	2.2	2.5
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>36.2</b>	<b>47.3</b>	<b>65.6</b>	<b>88.7</b>	<b>96.3</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 4.6 пунктээр, дансны авлага 0.1 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 0.2 пунктээр буурч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 5 нэгж хувиар өссөнийг Хүснэгт 2.9-өөс харж болно.

### Хүснэгт 2.10

#### Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2013 оны эхний хагас жилийн байдлаар, тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	22.9	20.2
2	Бодь даатгал ХХК	12.4	11.0
3	Тэнгэр даатгал ХХК	8.3	7.3
4	Мандал генерал даатгал ХХК	7.7	6.8
5	Миг даатгал ХХК	7.6	6.7
6	Практикал даатгал ХХК	7.5	6.6
7	Ард даатгал ХХК	7.3	6.5
8	Соёмбо даатгал ХХК	6.2	5.5
9	Номин даатгал ХХК	6.1	5.4
10	Нэйшнл лайф даатгал ХХК	4.8	4.3
11	Моннис даатгал ХХК	4.0	3.5
12	Монре даатгал ХХК	3.9	3.4
13	УБ хотын даатгал ХХК	3.3	2.9
14	Мөнх даатгал ХХК	3.0	2.6
15	Ган зам даатгал ХХК	2.8	2.5
16	Гэр даатгал ХХК	2.7	2.4
17	Хаан даатгал ХХК	2.7	2.4
<b>Дүн</b>		<b>113.2</b>	<b>100</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.




2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харуулахад “Хаан даатгал” ХХК хамгийн бага буюу 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 2.4 хувийг эзэлж байна. Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 20.2 хувийг “Монгол даатгал” ХХК дангаараа бүрдүүлжээ.

### Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилээр эхний хагас жилийн байдлаар Дүрслэл 2.16-д харьцуулж үзүүлэв.

#### Дүрслэл 2.16

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2011 оны 2 дугаар улиралд 47 хувийг эзэлж байсан бол 2012 оны мөн үед 47.1 хувь, тайлант үед 47 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 3 жилийн нөөцийн сангийн нийт хөрөнгөнд эзлэх хувь

тогтвортой байх хандлага ажиглагдаж байгааг харуулж байна.

### Даатгалын хураамжийн орлого

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2013 оны 2 дугаар улиралд 42.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.014 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 41.9 тэрбум төгрөг, урт хугацааны даатгагч 484 сая төгрөгийн орлоготой ажилласан. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 410 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 141 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 12.5 их наяд төгрөгт хүрчээ.

#### Хүснэгт 2.11

Даатгалын хураамжийн орлого, бүтээгдэхүүнээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	2012НН	2013НН	Өөрчлөлт
		Даатгалын хураамжийн орлого		
1	Хөрөнгийн даатгал	10 274	10 054	-220
2	Авто тээвэр хэрэгслийн даатгал	8 650	8 655	5
3	Агаарын хөлгийн даатгал	4 302	3 778	-524
4	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	-	83	-
5	Хариуцлагын даатгал	3 693	4 273	580
6	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3 102	3 708	606
7	Жолоочийн хариуцлагын даатгал	9 293	3 230	-6 063
8	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	-	4 844	-
9	Санхүүгийн даатгал	881	1 163	282
10	Барилга угсралтын даатгал	685	524	-161
11	Ачааны даатгал	643	912	269
12	Хугацаат амьдралын даатгал	178	207	29
13	Эрүүл мэндийн даатгал	83	190	107
14	Хуримтлалын даатгал	64	61	-3
15	Тэтгэврийн даатгал	18	26	8
16	Зээлийн даатгал	-	709	-
<b>Дүн</b>		<b>41 865</b>	<b>42 416</b>	<b>551</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тэмдэглэл: Тайлант хугацаанд хураамжийн орлого нь тэг байсан даатгалын хэлбэрүүдийг үзүүлээгүй болно.

Даатгалын хэлбэрээр 2013 оны нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөрөнгийн даатгал 0.2 тэрбум төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 0.5 тэрбум төгрөгөөр, жолоочийн хариуцлагын даатгал 6.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 0.6 тэрбум төгрөгөөр, хариуцлагын

даатгал 0.5 тэрбум төгрөгөөр, ачааны даатгал 0.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Дүрслэл 2.17**

**Даатгалын хураамж ба нөхөн төлбөрийн харьцаа**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2013 оны 2 дугаар улиралд нийт хураамжийн орлого 42.4 тэрбум төгрөгт хүрч, нэг хүнд ногдох хураамжийн орлого 15.1 мянган төгрөг болжээ.

**Дүрслэл 2.18**

**Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого (төгрөг)**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Даатгалын нөхөн төлбөр**

2013 оны 2 дугаар улиралд нийт 11.78 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон

бөгөөд даатгалын төрлүүдээр авч үзвэл дараах байдалтай байна.

**Хүснэгт 2.12**

**Даатгалын нөхөн төлбөр (сая төгрөг)**

№	Даатгалын хэлбэр	Даатгалын нийт нөхөн төлбөр		Өөрчлөлт
		2012Н1	2013Н1	
1	Хөрөнгийн даатгал	502	1 299	797
2	Авто тээвэр хэрэгслийн даатгал	3 049	3 354	305
3	Агаарын хөлгийн даатгал	9	5	-3
4	Хариуцлагын даатгал	118	160	42
5	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	853	975	122
6	Жолоочийн хариуцлагын даатгал	1 196	1 122	-74
7	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	-	3 651	-
8	Санхүүгийн даатгал	618	254	-364
9	Барилга угсралтын даатгал	-	25	-
10	Ачааны даатгал	91	126	35
11	Хугацаат амьдралын даатгал	24	24	0
12	Эрүүл мэндийн даатгал	36	58	22
13	Хуримтлалын даатгал	32	37	5
14	Тэтгэврийн даатгал	4	3	-1
15	Зээлийн даатгал	-	689	-
<b>Дүн</b>		<b>6 531</b>	<b>11 781</b>	<b>5 250</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тэмдэглэл: Тайлант хугацаанд нөхөн төлбөр хийгдээгүй даатгалын хэлбэрүүдийг үзүүлээгүй болно.

**Даатгалын нөхөн олговрын түвшин**

2013 оны 2 дугаар улиралд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 42 хувь болж өмнөх жилийн мөн үеийнхээс 12.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 34 хувьтай байна.


Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2013 оны 2 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК-иуд 53 хувь буюу хамгийн өндөр хувьтай байлаа.

Даатгалын компаниудаас даатгуулагчдад олгосон даатгалын нөхөн олговрын түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Бодь даатгал” ХХК 4.6, “Миг даатгал” ХХК 15.2, “Ард даатгал” ХХК 4.4, “Ганзам даатгал” ХХК 5.1, “Гэр даатгал” ХХК 28.4, “Мөнх даатгал” ХХК 18.3, “Номин даатгал” ХХК 19, “Практикал даатгал” ХХК 21.5, “Тэнгэр даатгал” ХХК 11.3, “Соёмбо даатгал” ХХК 16.2, “Монре даатгал” ХХК 30.6

пунктээр тус тус өсч, “Нэйшнл лайф даатгал” ХХК 1.1, Моннис даатгал” ХХК 9.2, “УБ хотын даатгал” ХХК 5.1 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Дүрслэл 2.19**

**Даатгалын компаниудын нөхөн олговрын түвшин ба ашигт ажиллагаа**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2013 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 3.5 тэрбум төгрөг болсон байна. Өмнөх оны мөн үеийнхээс 199.2 сая төгрөгөөр нэмэгджээ.

**Дүрслэл 2.20**

**Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг/алдагдал (сая төгрөг)**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Тайлант үеийн “Нэйшнл лайф даатгал” ХХК 41.9 сая төгрөг, “Соёмбо даатгал” ХХК 89.6 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 413 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна. Даатгалын компаниудын хуримтлагдсан ашгийг сүүлийн 3 жилийнхтэй нь харьцуулахад 1.1 дахин буурчээ.

**Даатгалын нөөц сан**

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн эхний хагас жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2012 оны мөн үед 46 тэрбум байсан бол тайлант оны мөн үед 53.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.16 дахин өслөө.

**Дүрслэл 2.21**

**Даатгалын нөөц сан (тэрбум төгрөг)**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Давхар даатгал**

2013 оны 2 дугаар улиралд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 11 тэрбум төгрөгийн хураамж төлсөн ч өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 214 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Тайлант үеийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулан Дүрслэл 2.22-г харуулав.

**Дүрслэл 2.22****Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хүснэгтээс харвал “Ард даатгал” ХХК 325, “Бодь даатгал” ХХК 2168, “Миг даатгал” ХХК 98, “Ган зам даатгал” ХХК 171, “Монре даатгал” ХХК 8.9 сая төгрөгөөр тус тус буурч бусад даатгагчийн хувьд нэмэгдсэн байна.

**Хүснэгт 2.13****Давхар даатгалын хураамж (сая төгрөг)**

№	Компанийн нэр	2012Н1	2013Н1
1	Бодь даатгал ХХК	3 914	1 746
2	Монгол даатгал ХХК	3 420	4 654
3	Ард даатгал ХХК	987	662
4	Миг даатгал ХХК	1 216	1 117
5	Соёмбо даатгал ХХК	28	301
6	Моннис даатгал ХХК	852	1 042
7	Тэнгэр даатгал ХХК	189	747
8	Мандал генерал даатгал ХХК	334	560
9	Практикал даатгал ХХК	69	88
10	Ган зам даатгал ХХК	171	-
11	Номин даатгал ХХК	7	35
12	Нэйшнл лайф даатгал ХХК	-	30
13	Монре даатгал ХХК	64	55
<b>Дүн</b>		<b>11 250</b>	<b>11 036</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


**Албан журмын даатгал**

Жолоочийн даатгалын тухай хууль 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн ба 2013 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 16 компанид жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон.

Тайлант хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалаар нийт 8.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Мөн тайлант хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалаар нийт 4.8 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон ба өмнөх оны мөн үеийнхээс 3.6 тэрбум төгрөгөөр өслөө.

Мөн хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалын 167.1 мянган гэрээ байгуулагдсан

бөгөөд нөхөн төлбөр авсан 9.5 мянган хохирогч, даатгуулагч байна.

**Дүрслэл 2.23****Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зарим статистик мэдээлэл (сая төгрөг)**

Үзүүлэлтүүд	2012Н1	2013Н1
Даатгалын хураамжийн орлого	9 294	8 074
Даатгалын гэрээний тоо	168 510	167 100
Олгосон нөхөн төлбөр	1 195	4 772
Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	1 795	95 000

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Даатгалын мэргэжлийн оролцогч**

**Даатгалын зуучлагч**

2013 оны 2 дугаар улиралд нийт 17 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 284 тэрбум төгрөг болсон ба үүнээс 203 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

**Хүснэгт 2.14**

**Компаниудын хураамжийн орлого (сая төгрөг)**

№	Компанийн нэр	2012Н1	2013Н1
1	Асимон брокерс ХХК	33.7	40.9
2	Аме ХХК	2.5	10.1
3	Ачит ундарга ХХК	45.6	24.8
4	Лоялти солюшн ХХК	34.9	16.5
5	Эм жи ай би ХХК	0	0
6	Ренессанс групп ХХК	33.8	26.4
7	Жомолхари ХХК	4.9	0
8	Пийс оф лайф ХХК	-	0
9	Монголиан интернэшнл брокерс ХХК	0	0
10	Юу ай би ХХК	6.7	13.5
11	Гэрэлт буян ундрах ХХК	0	3.5
12	Нэйшнл эженси ХХК	44.4	14.3
13	Изи инвестмент ХХК	0	-
14	Си эн эн икс ХХК	0	51.6
15	Хаан банк ХХК	-	1.1
16	Хас банк ХХК	-	-
17	Хадгаламж банк	-	0
18	Эрдлийн шийдэл ХХК	-	0
19	ASIB ХХК	-	0
20	SIBS ХХК	-	0
<b>Дүн</b>		<b>207</b>	<b>203</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.  
Тэмдэглэл: -үйл ажиллагаа эрхлээгүйг илэрхийлнэ.

Тайлант оны хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Асимон брокерс” ХХК 7.6, Аме” ХХК 7.6, “Юу ай би” ХХК 6.8, “Си эн эн икс” ХХК 51.6, “Гэрэлт буян ундрах” ХХК 3.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Лоялти солюшн” ХХК 18.4, “Ачит ундарга” ХХК 20.8, “Ренессанс групп” ХХК 7.4, “Жомолхари” ХХК 4.9, “Нэйшнл эженси” ХХК 30.1 сая төгрөгөөр тус тус буурсан. Бусад компаниуд нь даатгалын зуучлалын орлого төвлөрүүлээгүй байна.

**Даатгалын хохирол үнэлэгч**

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 246.6 сая төгрөг болсон. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 54.4 хувь буюу 134.1 сая төгрөг төвлөрүүлж, үлдсэн 45.6 хувийг бусад орлого эзэлжээ.

**Хүснэгт 2.15**

**Компаниудын хохирол үнэлгээний орлого (сая төгрөг)**

№	Компанийн нэр	2011	2012
1	Гэрэгэ эстимэйт ХХК	13.8	62.5
2	Вендо ХХК	5.5	63
3	Иптэлт эстимэйт ХХК	0	38.9
4	Бест эстимэйт ХХК	1.7	20.8
5	Арвижихэстимэйт ХХК		9.9
6	Файн эстимэйт ХХК	0	9.1
7	Мега марз ХХК	5.5	-
8	Жи ай си си ХХК	0.4	1.5
9	Хөрөнгийн үнэлгээний төв ХХК	0.2	0.5
<b>Дүн</b>		<b>27.1</b>	<b>206.2</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.  
Тэмдэглэл: -тайлангаа ирүүлээгүйг илэрхийлнэ.

**Ердийн даатгал**

2013 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 16 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 240 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.2

хувиар нэмэгдсэн. Тайлант үеийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 108.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн

үеийнхээс 14.4 тэрбум төгрөгөөр буюу 1.15 дахин өссөн байна. Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос тогтвортой өсчээ.

### Хүснэгт 2.16

#### Эзэмшигчдийн өмч (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	12.06.30		13.06.30		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эзэмшигчдийн өмч	34.7	81%	46.8	88%	12.2	7.1
Хуримтлагдсан ашиг/алдагдал	8.2	19%	6.3	12%	-1.9	-7.0
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>42.9</b>	<b>100%</b>	<b>53.1</b>	<b>100%</b>	<b>10.3</b>	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тайлант үеийн эзэмшигчдийн өмч нь өмнөх оны мөн үеийнхээс 12.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч, хуримтлагдсан ашиг 1.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

### Ердийн даатгалын хураамжийн орлого

Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 11 тэрбум төгрөг буюу 26.3 хувийг давхар даатгалд, 175 сая төгрөг буюу 0.5 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 30.8 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажиллажээ.

Даатгалын компаниудыг 2013 оны 2 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 30.8 хувь буюу 12.9 тэрбум төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 13.8 хувь буюу 5.8 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлснээр даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 44.6 хувийг эзэлсэн байна. Ердийн даатгалын нийт хураамжийн орлого 41.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт хураамжийн орлогын 30.8 хувийг “Монгол даатгал” ХХК-ийн орлого эзэлж байна.

### Хүснэгт 2.17

#### Даатгалын хураамжийн орлого, компаниудаар (тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	4.1	9.7
2	Бодь даатгал ХХК	5.8	13.8
3	Ган зам даатгал ХХК	0.1	0.2
4	Мандал генерал даатгал ХХК	2.2	5.2
5	Миг даатгал ХХК	3.8	9
6	Монгол даатгал ХХК	12.9	30.8
7	Гэр даатгал ХХК	0.2	0.6
8	Моннис даатгал ХХК	1.3	3.1
9	Мөнх даатгал ХХК	0.4	0.9
10	Номин даатгал ХХК	1.3	3.1
11	Практикал даатгал ХХК	1.8	4.3
12	Тэнгэр даатгал ХХК	3.2	7.7
13	Соёмбо даатгал ХХК	2.8	6.7
14	Монре даатгал ХХК	1.1	2.7
15	Хаан даатгал ХХК	0.5	1.3
16	УБ хотын даатгал ХХК	0.3	0.8
<b>Дүн</b>		<b>41.9</b>	<b>100</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Ердийн даатгалын нөхөн төлбөр

2013 оны хагас жилийн байдлаар 11.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 5.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн буюу 2 дахин өссөн дүн юм.

### Хүснэгт 2.18

#### Ердийн даатгалын нөхөн төлбөр (сая.төгрөг)

№	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	942.7	8.1
2	Бодь даатгал ХХК	1 197.8	10.3
3	Ган зам даатгал ХХК	23.4	0.2
4	Мандал генерал даатгал ХХК	361.5	3.1
5	Миг даатгал ХХК	1 105.8	9.5
6	Монгол даатгал ХХК	3 746.6	32.1
7	Гэр даатгал ХХК	63.4	0.5
8	Моннис даатгал ХХК	17.7	0.2
9	Мөнх даатгал ХХК	146.3	1.3
10	Номин даатгал ХХК	495.6	4.3
11	Практикал даатгал ХХК	1 014.2	8.7
12	Тэнгэр даатгал ХХК	931.5	8
13	Соёмбо даатгал ХХК	1 099.7	9.4
14	Монре даатгал ХХК	457.5	3.9
15	Хаан даатгал ХХК	22.3	0.2
16	УБ хотын даатгал ХХК	33.9	0.3
<b>Дүн</b>		<b>11 659.9</b>	<b>100</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 32.1 хувь, “Ард даатгал” ХХК 10.3 хувь, “Миг даатгал” ХХК 9.5 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 51.9 хувийг эзэлж байна.

2013 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг

3.5 тэрбум төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Ард даатгал” ХХК 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, нийт зах зээлийн 52.4 хувийг дангаараа бүрдүүлсэн. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажиллав.


**Урт хугацааны даатгал**

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Байгуулагдсан цагаас хойшхи нийт хөрөнгийн хэмжээ 4.8 тэрбум төгрөгт хүрсэн. Урт хугацааны даатгалын компани 2013 оны 2 дугаар улирлын байдлаар 483.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 29.6 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 121.3 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ.

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 812.2 сая төгрөгт хүрчээ. Нөөц сан 2013 оны 2 дугаар улирлын байдлаар 756.3 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 327.6 сая төгрөгөөр буюу 1.7 дахин өссөн байна.

**Дүрслэл 2.24**

**Урт хугацааны даатгалын орлого, давхар даатгал, нөхөн төлбөр, ашигт ажиллагаа, нөөц сан (сая төгрөг)**



Үзүүлэлт	2011.06.30	2012.06.30	2013.06.30
Хуримтлагдсан ашиг/алдагдал	-594	-700	-812
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	-120	-54	-42
Нөөц сан	138	429	756

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА**

Улсын Их Хурлын 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар Зээлийн батлан даалтын сан 2012 оны 11 дүгээр сарын 6-нд үүсгэн байгуулагдсан.

Зээлийн батлан даалтын сан нь 2013 оны 8 дугаар сарын байдлаар Капитал банк, Төрийн банк, Голомт банкуудтай хамтран ажиллаж нийт 26 зээлийн батлан даалт хүсэгч иргэн,

аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч, 14 батлан даалт хүсэгчид 958.4 сая төгрөгийн батлан даалт гаргаад байна.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, холбогдох эрх зүйн зохицуулалтыг хийж байна. Энэхүү сангийн ач холбогдлын талаар товч дурдвал:

- ◆ Макро эдийн засгийн үзүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ. Хөдөө орон нутгийн ЖДҮ эрхлэгчид Сангийн батлан даалтад

хамрагдсанаар бүс нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.

- ◆ Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээл олгогдох боломж бүрдэж, улмаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо, чадавхи өсч, энэ хэмжээгээр орлогын тогтвортой эх үүсвэртэй болно.
- ◆ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үйлдвэрлэлээ өргөжүүлэх, технологио сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, үүнтэй уялдаад ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурах боломж бүрдэнэ. Мөн өрсөлдөх чадвар сайжирснаар импортын бараа, бүтээгдэхүүнийг орлох дотоодын бүтээгдэхүүн бий болж, валютын гадагшлах урсгалыг багасгана.
- ◆ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн сайн түүхтэй болсноор банкны

найдвартай харилцагч болж, үйл ажиллагаа нь өргөжихийн хэрээр цаашид өөрийн хангалттай барьцаа хөрөнгөтэй болж Сангийн батлан даалтын шаардлагагүйгээр арилжааны банкнаас зээл авах чадвартай болно.

- ◆ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүү, эдийн засгийн мэдлэг, боловсрол дээшилж, төсөл хөтөлбөр боловсруулах, менежментийн сайн тогтолцоог бүрдүүлэх чадавхитай болно.
- ◆ Банк, санхүүгийн байгууллагууд нь ЗБДС-тай хамтран ажилласнаар зээлийн нэмэгдэл эх үүсвэртэй болж, эрсдэлийн хувь хэмжээ нь буурснаар харилцагчдын тоо өсөх, зээл олголт, мөн орлого нэмэгдэх давуу талтай.

## ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ БА ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

ХАА-н Биржээр ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос гэсэн нэр төрлийн түүхий эдийн арилжаа хийгдэж, 2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 312 тэрбум төгрөгийн хэлцлийг баталгаажуулсан байна.

2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар ХАА-н Биржийн арилжаа 60 удаа зохион байгуулагдаж, 24 тонн хонины угаасан цагаан ноосыг 64.8 сая төгрөгөөр, 24 тонн тэмээний өнжсөн завод ноосыг 84 сая төгрөгөөр, 5.2 мянган тонн ямааны цагаан, цайвар, бараан, ангилаагүй гэсэн 4 төрлийн ноолуурыг 312 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр тус тус арилжаалсан.

Арилжаа эхэлснээс хойшхи түүхий эдийн жигнэсэн дундаж үнийг Хүснэгт 2.19-д үзүүлэв.

### Хүснэгт 2.19

Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн үнэ (мянган төгрөг)

	Жигнэсэн дундаж үнэ, 1 богц*
Ангилаагүй ноолуур	570
Бараан ноолуур	602
Цайвар ноолуур	608
Цагаан ноолуур	636
Хонины угаасан цагаан ноос	270
Тэмээний өнжсөн завод ноос	35

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тэмдэглэл: \*1 богц=10 кг

Тайлант хугацаанд нэг өдрийн арилжааны дундаж нь 8.7 мянган богц, үнийн дүнгээр 5.1 тэрбум төгрөг байв. Хамгийн өндөр дүнтэй арилжаа 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр 13.13 тэрбум төгрөг байсан бол хамгийн бага дүнтэй арилжаа 2013 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 112 сая төгрөг байлаа.



2013 оны 4-6 сарын хооронд ХАА-н Биржээр нийт 312 тэрбум төгрөгийн бараа, түүхий эд (ноос, ноолуур)-ийн арилжаа хийгдсэн байгаа нь үүнтэй адил хэмжээний бэлэн мөнгө түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид (ченж)-ийн гар дээр далд эргэлдэж байсныг ил болгосон сайн талтай юм. Мөн биржийн арилжаанаас шимтгэл, хураамж хэлбэрээр улсын төсөвт болон төрийн өмчит ХАА-н Бирж компанид

тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгө төвлөрүүлэв.

Цаашид биржээр арилжих бараа, түүхий эдийн болон гэрээний төрлийг нэмэгдүүлэх дэд бүтцийг бүрдүүлэх шаардлагатай байгаа ба үүний хэрээр таваарын зах зээлийн санхүү, эдийн засагт үзүүлэх жин нэмэгдэхээр байна.

## 2.2 МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр түүний хэлбэлзэл, эрсдэлийн бодит эдийн засагт үзүүлэх нөлөө өсөн нэмэгдсээр байна. Үүний тод жишээ бол сүүлийн жилүүдэд цар хүрээ, давтамж нь нэмэгдэж буй санхүү, эдийн засаг, төлбөрийн тэнцлийн хямралууд юм. Макро зохистой бодлого нь санхүүгийн системийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор уламжлалт макро эдийн засгийн бодлогын<sup>10</sup> хамт, нэмэлт байдлаар ашиглагдаж байна. 2008-2009 оны дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг улс орнууд илүү нарийвчлан хөгжүүлэх болсон. Бодлого боловсруулагчид макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг сонгохдоо дараах сонголтуудтай тулгардаг:

- ◆ *Нэг эсвэл хэд хэдэн.* Хэд хэдэн хэрэгслийг ашиглах нь системийн эрсдэлийг бууруулахад илүү үр дүнтэй хэдий ч зардал өндөртэй байдаг;
- ◆ *Өргөн хүрээний эсвэл зорилтот.* Тодорхой эрсдэлийг зорилтоо болгож, түүнд тохирсон арга хэмжээ авах нь илүү үр ашигтай юм;
- ◆ *Тогтмол эсвэл хугацааны туршид өөрчлөгдөх.* Мөчлөгийн ялгаатай үеүүдэд хэрэгслүүдэд тохиргоо хийж байх нь

тогтмол хандлагаас илүү үр ашигтай байна;

- ◆ *Дүрэмд суурилсан эсвэл дискрет.* Динамик эрсдэлийн сан гэх мэт дүрэмд суурилсан хандлага нь маш тодорхой, ойлгомжтой байдаг боловч зарим макро зохистой хэрэгслийн хувьд дүрэм зохиоход хүндрэлтэй байдаг;
- ◆ *Бусад бодлогуудтай уялдаатай эсэх.* Макро зохистой хэрэгслийн зорилготой мөнгө, төсвийн бодлогын хэрэгсэл нийцэж байвал бодлогын үр дүн илүү сайн байна.

Бодлого боловсруулагчид санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, түүний тогтвортой байдлыг хангахад уламжлалт<sup>1</sup> макро эдийн засгийн бодлогууд голлох үүрэг гүйцэтгэх хэдий ч мөн зорилгоор олон төрлийн макро зохистой бодлогын арга хэрэгслүүд ашиглагдаж байна. Иймээс макро зохистой бодлогын хэрэгслийг ялгаж, тодорхойлох нь чухал юм. ОУВС-гийн түүвэр судалгаагаар<sup>11</sup> улс орнуудын зонхилон ашиглаж буй 10 макро зохистой хэрэгслийг тодорхойлсон байдаг. Эдгээрийг шинж чанараар нь дараах гурван бүлэгт хуваая:

<sup>10</sup> Үүнд мөнгөний болон төсвийн бодлогыг авч үзнэ.

<sup>11</sup> ОУВС, 2011, "Macroprudential Policy: What Instruments and How to Use Them?"

- ◆ *Зээлтэй холбоотой:* Зээл-үнэ цэнийн харьцаа (LTV)-нд хязгаар тогтоох, өр-орлого (DTI)-ын харьцаанд хязгаар тогтоох, гадаад валютын зээлд хязгаар тогтоох, зээл эсвэл зээлийн өсөлтийн хурдад дээд хязгаар тогтоох;
- ◆ *Хөрвөх чадвартай холбоотой:* Гадаад валютын нээлттэй позици/currency mismatch-д хязгаар тогтоох, актив, пассивын эргэн төлөгдөх дундаж хугацаанд (maturity mismatch) хязгаар тогтоох, зайлшгүй байлгах нөөцийн норм тогтоох;
- ◆ *Өөрийн хөрөнгөтэй холбоотой:* Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлага, динамик эрсдэлийн сан, ашгийн хуваарилалтад хязгаарлалт тогтоох.

Эдгээр хэрэгслүүд нь тодорхой зорилгод чиглэсэн байх ёстой. Нийтэд нь авч үзвэл дараах дөрвөн төрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор макро зохистой хэрэгслүүдийг ашигладаг. Үүнд:

- ◆ Зээлийн хурдацтай өсөлт, түүнээс шалтгаалсан хөрөнгийн үнийн өсөлтөөс үүссэн эрсдэл;
- ◆ Эрсдэл даах хэмжээнээсээ хэт хэтэрсэн өр, зээллэгээтэй холбоотой эрсдэл;
- ◆ Системийн хөрвөх чадварын эрсдэл;
- ◆ Их хэмжээний хөрөнгийн урсгалын хэлбэлзэлтэй холбоотой эрсдэл.

Макро зохистой хэрэгслийн сонголт нь эдийн засгийн бүтэц, хөгжлийн түвшин зэрэг тухайн улсын онцлогоос шалтгаална. Бүрэлдэж буй эдийн засагтай улсуудын бизнесийн мөчлөгийн далайц харьцангуй өндөр, санхүүгийн зах зээлийн төвлөрөл өндөр, хөгжлийн түвшин сул байдгаас хөгжингүй улсуудтай харьцуулахад макро зохистой хэрэгслүүдийг түлхүү ашиглах хандлагатай байдаг. Хүснэгт 2.25-д улс

орнууд макро зохистой хэрэгслийг хэрхэн ашиглаж буй талаар тоймлон үзүүлэв.

Монгол Улсад дараах макро зохистой хэрэгслүүдийг ашиглаж байна.

- ◆ *Хөрвөх чадвар.* 2011 онд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 18 хувиас 25 хувьд хүргэсэн;
- ◆ *Өөрийн хөрөнгийн хүрэлцээ.* I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 9 хувиас доошгүй байх, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 12 хувиас доошгүй байх, системийн хувьд өндөр ач холбогдол бүхий банкуудын хувьд уг үзүүлэлт 14 хувиас доошгүй байх;
- ◆ *Зээлийн төвлөрөл.* Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хэмжээ 20 хувиас хэтрэхгүй байх, хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээлийн өөрийн хөрөнгөд эзлэх хэмжээ 20 хувиас хэтрэхгүй байх, нэг этгээдэд олгосон зээлийн өөрийн хөрөнгөд эзлэх хэмжээ 5 хувиас хэтрэхгүй байх;
- ◆ *Гадаад валютын нээлттэй позиц.* Тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц нь өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй байх, нийт нээлттэй позиц нь өөрийн хөрөнгийн 40 хувиас хэтрэхгүй байх;
- ◆ *Актив, пассивын эргэн төлөгдөх дундаж хугацаанд (maturity mismatch) хязгаар тогтоох.* Хөрөнгө, өр төлбөрийн дундаж хугацааны зөрүү нийт хөрөнгийн дундаж хугацааны 30 хувиас хэтрэхгүй байх;
- ◆ *Нөөцийн шаардлага.* Зайлшгүй байлгах нөөцийн хэмжээ татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12 хувьтай тэнцүү байх;
- ◆ *Эрсдэлийн сан.* 2010 онд эрсдэлийн сан байгуулах журмыг Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан

тушаалаар шинэчлэн баталсан. 2008-2009 оны хямралын үед эрсдэлийн сан

байгуулах хувь хэмжээг бууруулсан байдаг.

**Дүрслэл 2.25**

**Макро зохистой бодлогын хэрэгслийн хэрэглээ**



Эх сурвалж: ОУВС, 2011, “Macprudential Policy: What Instruments and How to Use Them?”.

Тэмдэглэл: 0 оноо нь макро зохистой хэрэгсэл ашигладаггүй болохыг, 1 оноо нь 1 ширхэг макро зохистой хэрэгсэл ашигладаг болохыг тус тус илэрхийлнэ. Хэрэв хэд хэдэн хэрэгсэл ашигладаг, зорилготой, цаг хугацааны хувьд хувьсах эсвэл бусад бодлоготой уялдаатай бол тус бүр 1 оноо нэмж тооцжээ.

# 3


## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

### 3.1 ГАДААД СЕКТОРЫН ЭРСДЭЛҮҮД

Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч байгаа хэдий ч, зарим хөгжингүй орнуудад сэргэлт ажиглагдаж байна. Макро эдийн засгийн тогтвортой байдлаа харьцангуй хадгалж үлдсэн бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч болж, хөгжингүй орнуудаас эдийн засгаа дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй мөнгөний тэлэх бодлого нь дэлхийн санхүүгийн зах зээлийг тогтворжуулахад эерэгээр нөлөөлж байна.

#### Дүрслэл 3.1

Зарим орнуудын нэрлэсэн үйлчилж буй ханш ба эрдэс, түүхий эдийн үнийн индексийн өөрчлөлт




Эх сурвалж: Блүмберг, Монголбанк.

Хөгжингүй орнуудын төв банкууд эдийн засгийн бодит секторыг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлогын хүүг байж болох хамгийн доод түвшинд хүртэл шат дараатай бууруулж, мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж ирсэн

нь 2010-2011 онуудад бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнуудад их хэмжээний хөрөнгийн орох урсгал бий болгож, улмаар макро эдийн засгийн бодлогын хувьд тодорхой сорилтууд бий болгож байсан билээ. Гэвч хөгжингүй орнуудын эдийн засагт сэргэлт бий болох, мөнгөний тэлэх бодлого эргээд хумигдах нөхцөлд эсрэг нөхцөл байдал буюу хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах үзэгдэл ихсэх эрсдэл байгааг АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас гаргасан мэдэгдэлүүд, түүний үр дагавар тодорхой харуулж байна.

#### Дүрслэл 3.2

Нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш, сонгосон орнуудаар (2013 оны эхний 8 сарын байдлаар)



Эх сурвалж: BIS, Монголбанк.


Дээрх мэдэгдэлтэй уялдан бондын зах зээлийн хүү өсч, бүрэлдэж буй эдийн засагтай

болон хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах үзэгдэл хүчтэй ажиглагдлаа. Үүний улмаас тэдгээр орнуудын үндэсний валютын ханш огцом суларсан нийтлэг хандлага бий болсон.

Ийм орчинд хөрөнгө оруулагчид **урсгал тэнцлийн алдагдал өндөртэй** орнуудыг илүү эрсдэлтэй гэж үзэж байна.

### Дүрслэл 3.3

Нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн хэлбэлзэл



Эх сурвалж: BIS, Монголбанк.


Хэдийгээр АНУ-ын Холбооны нөөцийн банкны 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн мэдэгдлээр тус банк актив худалдан авалтаа ойрын хугацаанд бууруулахгүй байхаар шийдвэрлэсэн хэдий ч, цаашид хөгжингүй орнуудын эдийн засаг сэргэж, түүнийг дагаад мөнгөний зөөлөн бодлого нь чангарсан нөхцөлд дэлхийн санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарах, хөгжиж буй орнууд руу чиглэсэн хөрөнгө оруулалт татрах, зардал өсөх зэрэг эрсдэл байгааг анхаарах шаардлагатай юм.

Эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн зах зээл дээрх

бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ буураад байгаа билээ. Энэ нь ч манай улстай ижил анхдагч түүхий эд экспортлогч орнуудын хувьд үндэсний валютын ханш сулрах нийтлэг шалтгаан болсон бөгөөд ОУВС-гийн 2012 оны эцсийн байдлаар хийсэн судалгаагаар Австрали, Канад, Бразил, Өмнөд Африк, Чили<sup>12</sup> зэрэг орнуудын бодит ханш урт хугацааны тэнцвэрт түвшнээсээ илүү үнэлэгдсэн гэсэн үр дүн гарсан байна.

### Дүрслэл 3.4

Бодит ханшийн тэнцвэрт түвшний үнэлгээ



Эх сурвалж: IMF Multilateral Policy Issues Report – Aug 2013, Монголбанк.


Уул уурхайн эрдэс, түүхий эд экспортлогч дээр дурдсан орнуудын үндэсний валютын бодит ханш 2010-2012 оны хооронд хамгийн ихдээ 7 хувиар суларч, 12.6 хувиар чангарсан бол төгрөгийн бодит ханш мөн хугацаанд 30 гаруй хувиар чангарсан байна. Оны эхнээс

<sup>12</sup> 2011 оны байдлаар нийт экспортод эрдэс, түүхий эдийн экспортын эзлэх хувь хэмжээ Австралид 48 хувь, Бразилд 24 хувь, Өмнөд Африкт 21 хувь, Канадад 23 хувь, Чилид 20 хувь байсан бол Монголд энэ хувь хэмжээ 90 гаруй хувьтай байна.

тооцвол 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар валютын нэрлэсэн үйлчилж буй ханш Австралид 11.4 хувь, Канадад 4 хувь, Бразилд 8.3 хувь, Өмнөд Африкт 12.4 хувь, Чилид 4.1 хувиар тус тус суларчээ. Дээр дурдсан орнуудтай харьцуулахад эрдэс, түүхий эдийн экспортоос 2-4 дахин өндөр хамааралтай, нээлттэй, жижиг эдийн засагтай Монгол Улсын хувьд төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш мөн хугацаанд 9.5 хувиар суларсан байгаа нь макро суурь нөхцөл, түүний өөрчлөлттэй нийцтэй байна.

### Дүрслэл 3.5

#### Монгол Улсын уул уурхайн индекс



Эх сурвалж: МІСС.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн статистик болно.

Дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүн түүхий эдийн эрэлтэд өндөр жин эзэлж буй Хятадын эдийн засгийн төлөв байдал, хөгжиж байгаа орнуудаас эрдэс, түүхий эд авах Хятадын сонирхол нь Монгол Улсын эдийн засагт нөлөөлөх гол гадаад нөхцөл юм.

2013 оны 1-р улиралд Хятадын эдийн засгийн идэвхжил удааширч, тоон үзүүлэлтүүд төсөөлж байсан түвшинд хүрээгүй тул 2013 оны Хятадын ДНБ-ий өсөлтийн төсөөлөл 8.1 хувиас 7.8 хувь болж буурчээ<sup>13</sup>. Хөгжингүй орнууд дахь эдийн засгийн таагүй нөхцөлөөс

шалтгаалан Хятадын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч болж байсан экспортын эрэлт буурч эхэлсэнтэй уялдан Хятадын эрх баригчид эдийн засгийн тогтвортой өсөлтөө хадгалахын тулд дотоодын хэрэглээг нэмэгдүүлэх зорилт тавьсан билээ. Гэсэн хэдий ч Хятад улсын хувийн хэрэглээ мөн л шинжээчдийн таамгаас бага үзүүлэлттэй гарч байна.


Түүнчлэн, бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнуудад Хятадаас хийх гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан хандлага үргэлжлэхээр байгаа юм.

Ийнхүү гадаад эдийн засгийн орчин төдийлөн сайжрахааргүй байгаа нөхцөлд Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудсан, эдийн засагт орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан сөрөг хандлага үргэлжилж болзошгүй эрсдэлтэй байна. Энэ тохиолдолд экспортын үнэ буурах, экспортлох бүтээгдэхүүний тоо хэмжээ өсөхгүй байх эрсдэл байсаар байх тул экспортын өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын бүтээгдэхүүний өртгийг бууруулах, “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлага гарсаар байна. Нөгөөтэйгүүр, бүс нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын орчин таатай бус хэвээр байгаа нөхцөлд Монгол Улс хөрөнгө оруулалтын дотоод өрсөлдөх чадвараа сайжруулж, эрх зүйн орчинг шинэчлээд байна. Гэсэн хэдий ч, хөрөнгө оруулалтын тогтвортой орчинг бүрдүүлэхийн сацуу эдийн засагт үлэмж нөлөө бүхий, хөрөнгө оруулалтын цар хүрээ ихтэй том төслүүдийн хэрэгжилтийг түргэтгэх, хөрөнгө оруулагч талтай үүссэн асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

<sup>13</sup> IMF, WEO 2013, Jul 2013 update

**Дүрслэл 3.6**

**Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын компаниудын олон улсын бирж дэх хувьцааны үнэ**




*Эх сурвалж:* Блүмберг, Монголбанкны тооцоолол.  
*Тэмдэглэл:* 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн үнийг нэг байхаар тус бүр индексжүүлсэн, 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2013 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүртэлх тоон мэдээлэл ашигласан.

Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын компаниудын олон улсын бирж дээрх хувьцааны үнэ буурсан бөгөөд 2013 оны 8 дугаар сард 2011 оны 1 дүгээр сараас хойш хамгийн бага түвшинд хүрчээ. Энэ нь манай улсад хийх хөрөнгө оруулалтын эрсдэлүүд (тайлант хугацаанд) дорвитой буураагүй байгааг харуулж байна.

**Дүрслэл 3.7**

**Монгол Улсын засгийн газрын бондын үнэ (ам.доллар)**



*Эх сурвалж:* Блүмберг.

### 3.2 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АСУУДЛУУД

#### БАНКНЫ САЛБАР


Монголын банк, санхүүгийн салбар тогтвортой байгаа хэдий ч, цаашид дараах эрсдэлүүдийг бууруулахад анхаарах шаардлага гарч байна. Үүнд:

**Зарим банкууд дахь зээлийн төвлөрөл өндөр байна.** Монголбанкнаас Банкны тухай хуулийн 17.1-д нэг зээлдэгчид тавих хязгаарлалтыг тогтоосон байдаг. Зээлийн төвлөрөл өндөр байгаа банкууд зохистой харьцааны дээрх шаардлагыг хангаж ажиллах нь зээлийн төвлөрлийн эрсдэлийг бууруулахад эерэгээр нөлөөлнө.

**Банкны салбарт төвлөрөл өндөр байсаар байна.** Төвлөрлийг хэмжих үзүүлэлтүүдийн нэг болох херфиндалын индекс нь манай орны хувьд нийт активын 18 хувь, хадгаламжийн 19.4 хувь байгаа нь төвлөрөл өндөр хэвээр байгааг харуулж байна.

#### Дүрслэл 3.8

##### Херфиндалын индекс



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 7 дугаар сарын статистик болно.

Системийн хамгийн том 5 банкны төвлөрлийн харьцаа 89.5 хувьд байгаа нь

олон улсын жишгээр төвлөрөл өндөртэйг илтгэнэ.

#### Дүрслэл 3.9

##### Төвлөрлийн харьцаа\*



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: (1) \* Хадгаламжийн зах зээлд банкуудын эзлэх хувь хэмжээнд үндэслэн тооцогдсон

\*\* CR# - салбарын эхний # том банкны тоо

(2) Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 7 дугаар сарын статистик болно.

**Өөрийн хөрөнгө, түүний эрсдэл даах чадвар.** Монголбанкнаас банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 2012 оны 6 дугаар сараас 2013 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд системийн нөлөө бүхий банкуудад үе шаттайгаар 12 хувиас 14 хувьд хүргэн нэмэгдүүлж, банкны эрсдэл даах чадварыг сайжрууллаа. Мөн хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг сайжруулах зорилгоор 2013 оны 5 сард бүх банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж 16 тэрбум төгрөг болгов. Ингэснээр банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ системийн хэмжээнд эрс сайжирч, эрсдэл даах чадвар нь дээшиллээ.



**Гадаад валютын ханшийн эрсдэл.**

Хэдийгээр гадаад валютын зээлдэгчдийн дийлэнх нь ханшийн эрсдэлээ удирдаж чадах томоохон компаниуд байдаг ч, зээлдэгч, банк, санхүүгийн байгууллага, Засгийн газрын түвшинд гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах тогтолцоог бий болгох нь чухал байна.

**Мэдрэмтгий байдлын шинжилгээгээр гэнэтийн шок бий болоход банкны салбарт үзүүлэх нөлөөллүүд.** Зээлийн эрсдэлээс үүдэлтэйгээр банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөх болон эх үүсвэрийн гарах урсгалаас үүдэлтэйгээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт хэрхэн буурахыг тус тус авч үзье.


Зээлийн эрсдэлийн хувьд сул, дунд болон хүчтэй сценариудыг сонгохдоо одоогийн чанарын ангилалд бүртгэлтэй байгаа зээлийн үлдэгдэл нь харгалзан 10, 20 болон 30 хувиар нэг ангиллаар буурах (муу зээлийн ангилалд байгаа зээл ангилал шилжихгүй) тохиолдлуудыг сонголоо. Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь нь гадагшлах тохиолдолд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанд орох өөрчлөлтүүдийг харуулав.

Сул сценарийн хувьд банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 0.4 нэгж хувь, дунд сценарийн хувьд 1.1 нэгж хувь харин хүчтэй сценарийн хувьд 1.6 нэгж хувиар тус тус буурахаар байна. Шинжилгээнээс харахад өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд нь дээрх

сценариудын дараах байдлаар зохистой харьцааны хамгийн доод шаардлагаас 2.3-3.4 нэгж хувиар өндөр байна. Харин системийн нөлөө бүхий банкуудад тавигдаж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээний хамгийн бага шаардлагаас 0.3-1.4 нэгж хувиар илүү байна.

**Дүрслэл 3.10**

**Стресс тест**



Эх сурвалж: Монголбанк.

Нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь гадагшлахад банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 3-9.9 нэгж хувиар буурахаар төсөөлөл гарч байна. Энэ нь Монголбанкнаас тавьдаг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны хамгийн доод шаардлагаас даруй 8.9-15.8 нэгж хувиар өндөр байна. Үүнээс дүгнэхэд гэнэтийн шок үүсэхэд банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь эрсдэл даах хэмжээнд байгаа бөгөөд цаашид системийн хэмжээнд төлбөрийн чадварыг хадгалах шаардлагатай юм.

## БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

**Эрсдэлийн үнэлгээ, судалгаа**

Үнэт цаасны, даатгалын, бичил санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй зохицуулалтын байгууллагуудын санхүүгийн тайлагнал, аудит, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чанар, стандартыг сайжруулах, зах зээлийн гол үзүүлэлтүүдийн талаарх судалгаа, шинжилгээ хийх, бизнесийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх замаар эрсдэлийг бууруулах чиглэлийг барьж ажиллаж байна. СЗХ-ноос жил тутам зохион байгуулж эхлээд буй “Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага” сэдэвт семинарт аж ахуйн нэгжүүд, төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагууд, дотоод гадаадын эрдэмтэн судлаачид өргөнөөр оролцож санхүүгийн байгууллагад эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх аргачлал, туршлагаа хуваалцан, семинарын үр дүнгээр эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэхэд хэрэглэгдэх арга, аргачлалын гарын авлагыг бэлтгэн цаасан болон электрон хэлбэрээр мэргэжлийн байгууллага, олон нийтэд хүргэж ирлээ. Мөн семинарт хэлэлцсэн асуудлуудаар холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, сайжруулах ажил хийгдэж байна.

Зохицуулалтын байгууллагын санхүүгийн тайлагнал, түүний аудит, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний асуудлыг хариуцдаг мэргэжлийн холбоодтой байгуулсан хамтран ажиллах санамж бичигүүдийн хүрээнд санхүүгийн зах зээлийн онцлогийг тусгасан хөтөлбөрийн дагуу мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулах, аудит, үнэлгээний байгууллагуудын ажилд чанарын хяналт, шалгалтыг хамтран гүйцэтгэх ажил тогтмолжиж байна.

**Венч хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг бүрдүүлэх**

Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын техник, технологийн судалгааны ажлын үр дүнг бүтээгдэхүүн болгох, технологи нэвтрүүлэх, туршилт зүгшрүүлэлт хийх гарааны компаниудад зориулсан хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн орчин 2012 онд УИХ-аар батлагдсан Инновацийн тухай хуулиар бүрдсэн. Тус хуульд заасан Венч хөрөнгө оруулалтын компани, Венч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тусгай зөвшөөрлийн журмыг боловсруулах ажлыг СЗХ-ноос хийж байгаа ба Венч хөрөнгө оруулалтыг дэмжих татварын орчинг бүрдүүлэх шаардлага гарч байна.

### 3.3 САЛБАРУУДЫН ЗЭЭЛ, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ

Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын хүрээнд банкуудад байршуулж буй эх үүсвэр нь зээл, харилцах хадгаламж зэрэг мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлтийг тогтворжуулах, улмаар дэмжих гол хүчин зүйл болж байна. Тухайлбал, барилгын салбарт олгосон зээлийн өсөлт 4.2 хувиас 85.3 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн өсөлт -33.2 хувиас 77.7 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх -8.7 хувиас 70.6 хувь болж өсчээ.

#### Дүрслэл 3.11

Зээлийн өсөлтийн хувь (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

2013 оны 2 дугаар улиралд жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгж, бусад аж ахуй нэгж, иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийн өсөлт харгалзан 41, 36, 37 хувь байна.

Зээлийн чанарын үзүүлэлт 2009 оноос хойш тогтмол сайжирч, 2013 оны эхний хагас жилд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 3.7 хувь болж 2012 оны эцсээс 0.5 нэгж хувиар буурчээ.

#### Дүрслэл 3.12

Чанаргүй зээлийн хувь (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Харин 2013 оны 8 дугаар сард чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 4.8 хувьд хүрч, 2013 оны эхний хагасаас 1.1 нэгж хувиар өссөн нь Хадгаламж банкныг Төрийн банкинд шилжүүлсэнтэй уялдан зээлийн чанарын ангилалд гарсан өөрчлөлттэй голлон холбоотой байна.

#### Дүрслэл 3.13

Зээлийн жилийн өсөлтийн хувь (төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: ЖДҮ- Жижиг Дунд Үйлдвэрлэл ААН- Аж Ахуй Нэгж.

Салбаруудын зээлийн багцыг 2012 оны эцэстэй харьцуулахад тогтвортой байна. Барилга, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын зээлийн нийт зээлийн

өрийн үлдэгдэлд эзлэх хувь 1-1.3 нэгж хувиар өссөн бөгөөд бусад салбарын хувьд 0.4-0.7 нэгж хувиар буурчээ.

### Дүрслэл 3.14

Салбаруудын зээлийн нийт зээлд эзлэх хувь (2013 оны эхний хагаст)




Эх сурвалж: Монголбанк.

**Нийт зээлийн өрийн үлдэгдэлд гадаад валютын зээлийн эзлэх хувь буурч байна.** Гадаад валютын зээл нь зээл олгогч болон зээлдэгч талуудын аль алинд ханшийн эрсдэлийг бий болгодог. Ялангуяа төгрөгийн орлоготой иргэд, аж ахуйн нэгжүүд гадаад валютаар зээл авах явдал нь (unhedged borrowers) ханшийн хэлбэлзлээр дамжин зээлийн болзошгүй эрсдэлийг бий болгох магадлалтай. Иймд гадаад валютын зээлтэй холбоотой аливаа харилцаанд валютын ханшийн эрсдэлийг зохистой удирдан бууруулах зохицуулалт байх ёстой бөгөөд төгрөгийн орлоготой этгээд валютын зээл авах тохиолдолд санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан ханшийн эрсдэлийг бууруулах зайлшгүй шаардлагууд гарч байгаа билээ.

2010 оны эхэнд нийт зээлийн 38 хувийг гадаад валютын зээл эзэлж байсан бол 2013 оны 7 дугаар сард 29.4 хувь болж буурчээ.

### Дүрслэл 3.15

Гадаад валютын зээл



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

**Өрхийн төсөв тогтвортой байна.** Өрхийн төсөв 2013 оны эхний хагасын байдлаар харьцангуй тогтвортой байна. Байнгын алдагдалтай явж ирсэн өрхийн төсөв 2011 оны 2 дугаар улирлаас 2012 оны эхний улирлын хооронд балансжиж эхэлсэн бол 2012 оны 2 дугаар улирлаас хойш ашигтай байна. 2013 оны 2 дугаар улиралд өрхийн орлого, зарлага өмнөх оны мөн үеэс харгалзан 14, 20 хувиар өсчээ.

### Дүрслэл 3.16

Өрхийн орлого, зарлагын харьцаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Орлогын өсөлт нь хүнсний хэрэглээнээс илүүтэй хүнсний бус хэрэглээнд илүүтэй зарцуулагдах хандлага гарч байна. Өөрөөр хэлбэл, 2008 онд өрх гэр нийт орлогын 35-40 хувийг зөвхөн хүнсэндээ зарцуулж байсан бол тус үзүүлэлт 2013 оны эхний хагасын байдлаар 22 хувь болж буураад байна.

Эдийн засгийн богино хугацааны хэт өөдрөг төсөөлөл, инфляцийн өндөр хүлээлтээс шалтгаалан хуримтлал хийхээс илүүтэй хэрэглээг өсгөх, түүнд чиглэсэн өр, зээл бий болгох хандлага нь өрхийн төсөв, цаашлаад макро эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг.

### Дүрслэл 3.17

**Иргэд, жижиг, дунд аж ахуй эрхлэгчдэд олгосон зээлийн жилийн өөрчлөлт**



Эх сурвалж: Иргэд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн тайлан.

Тухайлбал, банкны зээлийн 44 хувийг<sup>14</sup> тайлбарлаж буй иргэдийн зээл 2011, 2012 онд нийт 1.7 их наяд төгрөгөөр өссөний 60 орчим хувийг цалин, тэтгэвэр, хэрэглээний зээл дангаараа тайлбарлаж байлаа.


Гэтэл ипотекийн зээлийн өсөлт түүнээс 2 дахин бага буюу 30 орчим хувийг л бүрдүүлж байжээ. Хэрэглээний зээл ийнхүү өсөх нь эдийн засгийн мөчлөгийн сааралтын үед

<sup>14</sup> 2013 оны 8 дугаар сарын байдлаар

санхүүгийн системд өндөр дарамтыг бий болгож байсан юм.

### Дүрслэл 3.18

**Иргэдийн зээлийн жилийн өсөлт**



Эх сурвалж: Иргэд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн тайлан.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 6 дугаар сарын статистик болно.


2013 оны эхний хагасын байдлаар иргэд, жижиг, дунд аж ахуй эрхлэгчдэд олгосон зээл нэмэгдэж, тэдгээрийн жилийн өсөлт 2012 оны эцсээс 11-17 нэгж хувиар өндөр байна. Иргэдийн зээлийн өсөлтөд тэтгэврийн зээл 72 хувиар, цалингийн зээл 62 хувиар, ипотекийн зээл 38 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн.

2013 оны 6 дугаар сараас эхлэн “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаатай уялдсан цаашид иргэдийн зээлийн өсөлтөд орон сууцны ипотекийн зээл үлэмж нөлөө үзүүлж, голлох хувийг эзлэх эерэг хандлага бий болохын хэрээр цалин тэтгэврийн зэрэг хэрэглээний зээл хумигдаж, орон сууцны ипотекийн буюу хуримтлалын зээл өсөх, ингэснээр нийгмийн дундаж давхаргын хуримтлал нэмэгдэх юм. 2013 оны 6 дугаар сараас 8 дугаар сарын хооронд иргэдийн зээл

681 тэрбум төгрөгөөр өссөний 70 хувийг ипотекийн зээлийн өсөлт тайлбарлаж байна.

### Дүрслэл 3.19

#### Өрхийн өр, орлогын харьцаа\*




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанкны Ипотекийн зээлийн тайлан.

Тэмдэглэл: \* Өрхийн дундаж орлогод эзлэх хувь бөгөөд энэхүү харьцааг тооцоходоо өрхийн орлогыг ҮСХ-ноос тооцон гаргадаг улсын өрхийн дундаж сарын орлогыг авч ашигласан болно. Харин орон сууцны зээлийн сарын төлбөрийг гаргахдаа 1 зээлдэгчийн орон сууцны дундаж зээлийн хэмжээ, жигнэсэн дундаж хугацаа, хүүг ашигласан болно.

Орон сууцны зээлийн хүү буурч, хугацаа нь харьцангуй уртасч, өрхийн цалингийн орлого нэмэгдсэн нь ипотекийн зээлд хамрагдсан дундаж өрхийн өр, орлогын харьцаа буурахад нөлөөлж байна. Тус харьцаа нь дундаж өрх орлогоороо орон сууцны зээл авсан бол өр, төлбөрийн хувьд ямар дарамттай байхыг илтгэнэ. 2013 оны эхний хагасын байдлаар дундаж өрхийн өр, орлогын харьцаа нь 43 хувь хүртэл буурчээ. Уг үзүүлэлт сүүлийн 2 жилд эрс буурсан хэдий ч, хөгжсөн орны жишигтэй харьцуулахад өндөр хэвээр байна. Тухайлбал, АНУ-д орон сууцны төлбөр орлогын харьцаа 36 хувиас доош байх зарчмыг баримталдаг. Шинэ Зеланд улсын хувьд дээрх үзүүлэлт дунджаар 15-25 хувь байна.

### Дүрслэл 3.20

#### Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү




Эх сурвалж: Ипотекийн зээлийн тайлан.

Тэмдэглэл: \*Хөтөлбөрийн зээлийг оруулж тооцсон хүү Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

Өрхийн орлого нэмэгдсэн он жилүүдтэй давхцан орон сууцны зээлийн нөхцөл сайжирсан нь /хугацаа уртасч, хүү буурах/ орон сууцны зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн. Тухайлбал, ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8 дугаар сард 8.9 хувь болж буурсан бол зээлийн жигнэсэн дундаж хугацаа 14.1 жил болж өсөөд байна (Дүрслэл 3.20, Дүрслэл 3.21).

### Дүрслэл 3.21

#### Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)



Эх сурвалж: Ипотекийн зээлийн тайлан.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2013 оны 8 дугаар сарын статистик болно.

**Орон сууцны зах зээлийн үйл ажиллагаа идэвхитэй байна.** Улаанбаатар хотын орон сууцны үнэ 2011 оны эхний улирлаас 2012 оны эхний улирлын хооронд хурдацтай өссөн бол 2012 оны 2 дугаар улирлаас хойш үнийн жилийн өсөлт нь саарах хандлагатай байна. 2010 оны 4 дүгээр улирлаас 2012 оны 1 дүгээр улирал хүртэл Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг дэх орон сууцны үнэ бусад дүүрэгтэй харьцуулахад илүү хурдацтай өсч байсан бол 2012 оны 3 дугаар улирлаас эхлэн Сонгинохайрхан, Баянгол дүүрэг дэх орон сууцны үнэ бусад дүүрэгтэй харьцуулахад илүү хурдацтай өсөх болжээ (Дүрслэл 3.22).

Орон сууцны үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2013 оны 1 дүгээр улиралд 13.7 хувиар, 2 дугаар улиралд 15.6 хувиар тус тус өсчээ.

### Дүрслэл 3.22

Орон сууцны үнийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.


Иргэдийнхээ орон сууцны эрэлт хэрэгцээг амжилттай шийдсэн бусад улс орнуудад байдагтай адил урт хугацаанд тогтвортой үргэлжлэх ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох бодлого нь барилгын салбар дахь хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, улмаар урт хугацаанд орон сууцны эрэлтээ дагаж

нийлүүлэлт нь тогтвортой өсөх суурь нөхцөлийг бүрдүүлсэн чухал алхам байв.

**Хувийн хэвшлийн зээл мөчлөг дагасан хандлагатай байв.** Аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хувийг эдийн засгийн бодит өсөлттэй харьцуулан үзвэл 2011 оноос эхлэн хоорондоо хүчтэй хамааралтай болжээ. Эдийн засаг өсөлттэй үед үйлдвэрлэл эрчимжиж, аж ахуй нэгжүүд хөрөнгө оруулалт хийх, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор банкнаас зээл авах хандлагатай байдаг. Учир нь энэ үед бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт өндөр байдаг бөгөөд компаниуд илүү их орлого олохын тулд үйлдвэрлэлээ өргөжүүлэх сонирхолтой байна. Нөгөө талаас эдийн засгийн өрнөлийн үед банкууд зээлийн нөхцөлөө сулруулах нь хувийн хэвшлийн зээл эдийн засгийн мөчлөг дагахад нөлөөлнө.

### Дүрслэл 3.23

Хувийн салбарын зээлийн үлдэгдлийн өсөлт, бодит үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Харин эдийн засгийн өсөлт саарсан, бодит секторын идэвхжил удааширсан үед компаниудын борлуулалт буурч, эдийн засгийн өсөлтийн үед авсан зээлээ төлж чадахгүйд хүрч болзошгүй. Энэ нь банкны салбарт чанаргүй зээлийг огцом нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг. Ийнхүү зээлийн өсөлтийн мөчлөгийн шинж чанар нь нэг талаас банкны

зээлийн нөхцөл, мөнгөний эрэлтийн өөрчлөлтөөр тайлбарлагдаж болох ч, нөгөө талаар банкны системийн актив, пассивын хугацаа богино байгаатай болон нийт эдийн засгийн багтаамж нь бага, богино хугацаатай мөчлөг бүхий, улирлын шинж чанартай салбарууд эдийн засагт зонхилох байр суурь эзэлдэгтэй мөн холбоотой юм.

Үйлдвэрлэл харьцангуй сайн хөгжсөн орнуудын хувьд зээл нь бодит ДНБ-д нэлээдгүй цаг хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлдөг байна. Тухайлбал, Монгол Улстай харьцуулахад илүү аж үйлдвэржсэн Польш улсад хувийн хэвшлийн зээлийн өсөлтийн хэлбэлзэл нь 4 улирлын дараа бодит үйлдвэрлэлийн өсөлтийн хэлбэлзэлтэй давхцдаг бөгөөд эдгээр үзүүлэлтүүд хоорондоо 4 улирлын хоцрогдолтойгоор хүчтэй эерэг хамааралтай байдаг байна.

Цаашид манай оронд гадаад, дотоодын урт хугацаатай хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах, улмаар нэмэгдүүлэх, орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх, үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдыг бий болгох, хөрөнгө оруулалтын тусгай сан, гадаадын хөрөнгө оруулагчдыг засгийн газрын үнэт цаас, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулахад татан оролцуулах замаар санхүүгийн систем дэх урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь зүйтэй.



# 4

## САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ

### 4.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

#### Төлбөрийн систем

Монголбанк нь олон улсад нийтлэг мөрдөж буй санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудтай уялдуулан эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг сайжруулах, үнэт цаасны төлбөр тооцоо, гадаад валют болон хил дамнасан төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, Монголбанкнаас эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар санхүүгийн салбарын дэд бүтцийн тогтвортой байдлыг дэмжих, үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Төлбөр тооцооны системийн харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах гарцыг өргөжүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлд нэгдэх орчинг бүрдүүлэх зорилгоор “Монгол Улсын төлбөр тооцооны системийг шинэчлэх” төслийг эхлүүлсэн ба уг төсөл нь Засгийн газар, УИХ-ын Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороо, Үндэсний аюулгүй байдлын байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэгдэж, дэмжигдсэн тул Азийн хөгжлийн банктэй зээлийн хэлэлцээр байгуулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар соёрхон батлуулахаар ажиллаж байна.

Монголбанкны санаачилгаар АХБ-тай хамтран мобайл банкны эрх зүйн орчинг төлөвшүүлэх зорилготой “Хувьсан шинэчлэгдэх дэвшилтэт мобайл банкны үйлчилгээ” төслийг хэрэгжүүлж, хөдөлгөөнт

банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлогыг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар батлуулсан. Мөн тус бодлогын хүрээнд Монголбанкнаас хөдөлгөөнт банкны журмын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Эдгээр эрх зүйн баримтанд хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхэд банк, Банк бус санхүүгийн байгууллага, үүрэн холбооны байгууллагын оролцоо, тэдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгасан нь мөнгөн хөрөнгийг солилцох үр ашигтай, найдвартай бүтцийг хөгжүүлэх, технологийн дэвшлийг ашиглан банкны үйлчилгээнд бүрэн хамрагдах боломж хязгаарлагдмал хөдөө орон нутгийн иргэдэд банк, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг шуурхай хүргэж, улмаар бэлэн мөнгөний хэрэглээг багасгаж, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгох Монголбанкны бодлогод нийцсэн зохицуулалт байлаа.

#### Төлбөр тооцоо, хөрөнгийн бүртгэлийн систем

Хөрөнгийн биржийн бүртгэлийн шалгуур хангахгүй байгаа хувьцаат компанийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах, татан буугдсан хамтын сан болон хөрөнгө оруулалтын сангийн үлдэгдэл хөрөнгийн асуудлыг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн хэлбэрээр шийдвэрлэх ажлын хүрээнд СЗХ-ны 2013

оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 278 дугаар тогтоолоор нэр бүхий 57 компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасахаар шийдвэрлэн, олон нийтэд мэдээлж ажиллав. Ингэснээр Хөрөнгийн биржийн бүртгэлийн стандарт, компанийн засаглалыг сайжруулах эерэг үр дүнтэй юм. Мөн татан буугдсан хөрөнгө оруулалтын сангийн үлдэгдэл хөрөнгийг баталгаажуулах Ажлын хэсэг байгуулагдан “ҮЦТТХТ” ХХК-тай хамтран ажиллаж байна.

Үйл ажиллагаа явуулдаггүй, хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдсан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй болон хувьцаат компанийн шаардлага хангахгүй байгаа компанийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал боловсруулж 2013 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах ажил хийгдэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдийн хувьцааг Хөрөнгийн биржээр арилжаалах заалтын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журмыг зөвлөхүүдийн саналаар уул уурхайн компаниуд үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, онцлог зохицуулалт хийхээр ажиллаж байна.

### Үнэт цаасны зах зээл

Монгол Улсын Засгийн газраас “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” (Шинэчилсэн найруулга) болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2013 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталлаа.

### Хуульд тусгагдсан онцлог шинэ зохицуулалт

Хуульд дараах зарчмын шинжтэй асуудлуудыг шинээр тусгасан:

- ◆ Хуулийн төсөлд хөрөнгийн зах зээлд арилжаалагдах санхүүгийн хэрэгслүүдийг манай улсын зах зээлд нэвтрүүлэх бодит шаардлагыг харгалзан уг хуульд хэрэглэх гол нэр томъёог олон улсын жишигт нийцүүлэн шинээр тодорхойлж, эдгээртэй холбоотой зохицуулалтыг хуульд тусгасан.
- ◆ Үнэт цаас нь өргөн хүрээг хамарсан, олон төрлийн эрхийг гэрчлэх хэрэгсэл тул зөвхөн энэ хуулийн зохицуулалтад хамрах үнэт цаасыг тодорхойлж, үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, компаниас өрийн хэрэгсэл гаргах, гадаадын болон дотоодын компаниуд давхар бүртгэлтэйгээр үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульд тусгасан. Мөн үнэт цаасыг нийтэд санал болгоход тавигдах шаардлага, танилцуулгад тусгах мэдээлэл, уг ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн хариуцлага, мэдээлэх үүрэг, суурь үнэт цаасыг үндэслэн хадгаламжийн бичиг гаргахтай холбогдсон харилцааг нарийвчлан тодорхойлж хуульд тусгав.
- ◆ Үнэт цаасны зах зээлд оролцох, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа, түүний төрөл, тавигдах нөхцөл, шаардлагыг шинээр тогтоож, тэдгээр үйл ажиллагаатай холбогдох нарийвчилсан зохицуулалт бүхий дүрэм, журам, заавар, аргачлалаас бүрдэх багц дүрмийн хүрээ, хязгаарыг хуульд зааж, Санхүүгийн зохицуулах хороо баталж, мөрдүүлэхээр хуульд тусгасан.

- ◆ Хөрөнгийн болон бараа, үйлчилгээний зах зээлийн төрөл, хэлбэр өргөжиж байгаатай холбогдуулан үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу Хөрөнгийн биржийн чиг үүргийг нарийвчлан зааж, Хөрөнгийн биржээс тогтоох дүрэм, журмууд, нийтэд мэдээлэх мэдээлэл, эрхэлж болох үйл ажиллагааны хүрээ зэргийг заасан. Бараа, бүтээгдэхүүнд суурилсан санхүүгийн үүсмэл хэрэгслийн арилжааны болон үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхэлж болохоор хөрөнгө оруулагчдыг тэгш мэдээллээр хангах, эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг дээшлүүлэхэд гол үүрэгтэй үнэт цаасны зах зээлд дэх мэдээллийн урсгалыг нээлттэй болгох, түүнтэй холбоотой оролцогч болон эрх бүхий этгээдийн мэдээлэх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхой болгон тусгав.
- ◆ Үнэт цаасны зах зээл дэх төрийн байгууллагын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, хэлбэр, ялгааг заахаас гадна өөрийгөө зохицуулах байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлж, тэдгээрийн эрх, гишүүнчлэлийн асуудлыг тодорхой болгон тусгасан.
- ◆ Үнэт цаасны зах зээлд мэдээлэл шаардах эрх, хяналт шалгалт явуулах хэлбэр, журмыг тогтоож, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн бүрэн эрхийг уг салбарын онцлогт нийцүүлэн тодорхойлноос гадна үнэт цаасны зах зээлийн оролцогч хоорондын маргааныг урьдчилан хянан шийдвэрлэх үүрэг бүхий маргаан таслах зөвлөлийн эрх зүйн байдлыг тодорхойлж, үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон болон зах зээлийг урвуулан ашигласан, хууль тогтоомж зөрчигчдөд

хүлээлгэх хариуцлагын хэмжээг өндөржүүлэн тогтоохдоо зөрчлийн улмаас учруулсан хохирлын хэмжээ, цар хүрээ, зах зээлд үзүүлэх сөрөг нөлөөлөл зэргийг харгалзан шийтгэлийг ногдуулж байхаар хуульд тусгасан.

#### **Хууль батлагдсаны ач холбогдол, үр дүн**

- ◆ Үнэт цаасны зах зээл жинхэнэ сонгодог утгаараа хөгжих эрх зүйн орчинг нь хуульчилж өглөө. Жишээ нь, аль ч улсад үнэт цаасны зах зээлийн гол тоглогч нь мэргэжлийн хөрөнгө оруулагч байдаг. Мэргэжлийн хөрөнгө оруулагч гэдэгт тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан (нээлттэй, хаалттай)-гууд, даатгалын сангууд, хөрөнгө оруулалтын банкууд хамаардаг. Тэдгээрт энэхүү харилцаанд оролцох боломжийг анх удаа нээсэн нь том дэвшил юм.
- ◆ Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчид гадаадын хөрөнгийн бирж дээр нээлттэй компани хэлбэрээр хөрөнгө босгон, тус компанийхаа хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалах бололцоо нээгдсэн. Ийнхүү Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа шууд арилжаалах бололцоо нээгдсэнээр Монголчууд уул уурхайн томоохон төслүүдийг эдийн засгийн эргэлтэнд оруулж, эдгээр компанийн өндөр өгөөжтэй хувьцааг өөрийн орны хөрөнгийн биржээс шууд авах, хөрөнгө оруулах боломжийг олгож байгаа юм.
- ◆ Хаалттай компаниуд хөрөнгийн зах зээлд өрийн бичиг гаргаж санхүүгийн эх үүсвэр татах бололцоотой болж байна.
- ◆ Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компани гадаадын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэл хийлгэж,

гадаадын хөрөнгийн зах зээл дээр компанийхаа бонд эсхүл, хадгаламжийн сертификатыг гаргаж Лондон, Хонконг, Нью-Йоркийн хөрөнгийн биржээс хөрөнгө татах бололцоог хангаж өгсөн.

- ◆ Нэг талаас дан ганц хадгаламжийн хүүгээр биш хөрөнгө оруулалт хийж хөрөнгө мөнгөө өсгөх сонирхолтой хувь хүмүүс, нөгөө талаасаа банкны богино хугацаатай, хүү өндөртэй зээлээр биш урт хугацааны санхүүжилт шаардлагатай компаниудын хувьд нээлттэй компани болж бизнесээ өргөтгөх сонирхолтой үндэсний компаниудын хоорондын сонирхолын огтлолцол нь хөрөнгийн бирж юм. Өөрөөр хэлбэл, энэ хуулийн гол амин сүнс нь Монголын хөрөнгө оруулагчид бөгөөд хадгаламжид мөнгөө хадгалдаг иргэдийн хувьд хөрөнгийн зах зээлд оролцож мөнгөө өсгөх бололцоог сонгодог утгаар нь нээж өгч байна гэсэн үг юм.

Түүнчлэн 2013 оны эхний хагас жилийн байдлаар үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос 7 журам шинээр баталж, 3 журам, 3 тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Мөн 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 72 дугаар тогтоолоор нэр бүхий 11 арилжааны банкуудад Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч арилжаанд харилцагчийн нэрийн өмнөөс, түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

СЗХ-ны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 256 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан цаашид мэргэжлийн зуучлагч байгууллагад тавигдах шалгуурыг өөрчлөх бодлогын дагуу түүнд нийцүүлэн дүрэм, журам, зааврыг

боловсруулах ажлыг хэрэгжүүлж байгааг тэмдэглэн, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг хүлээн авахыг 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал түр хугацаагаар зогсоогоод байна.

### Даатгалын байгууллага

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын салбарын тогтвортой хөгжлийг дэмжих замаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, даатгалын салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлуудыг шат дараалан авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- ◆ СЗХ-ны 2012 оны 355 дугаар тогтоолоор даатгалын компаниудын дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн доод хэмжээг шинэчлэн тогтоов. Тус тогтоолын дагуу 2016 оны эцэс гэхэд даатгалын компаниудын дүрмийн сангийн доод хэмжээ таван тэрбум төгрөгт хүрсэн байх шаардлагыг СЗХ-ноос тавьж буй бөгөөд ингэснээр даатгуулагчдын өмнө гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхийг дээшлүүлж, дотоодын зах зээлийн чадамжийг өсгөх олон давуу талуудыг бий болгож байгаа юм.
- ◆ УИХ-ын 2013 оны хаврын чуулганаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, үүнтэй холбоотойгоор Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсгийг хүчингүй болгосон. Ингэснээр даатгалын зах зээл дэх чөлөөт мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлд татан төвлөрүүлэх эрх зүйн орчны үндсийг буй болгож байгаа юм. Үүнтэй холбоотойгоор

СЗХ-ноос даатгалын компанийн нөөцийн сан дахь мөнгөн хөрөнгийг үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулахтай холбоотой эрх зүйн хэм хэмжээг буй болгох талаар ажиллаж, ердийн болон урт хугацаат даатгалын үйлчилгээ эрхэлж буй компаниудын хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг тодорхойлсон 2 журмыг СЗХ-ноос батлан, мөрдүүлж байна.

СЗХ нь даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах ерөнхий чиг үүргийнхээ хүрээнд 2013 оны эхний хагас жилийн байдлаар дараах тогтоолуудыг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцэн батлаад байна. Үүнд:

- ◆ СЗХ-ны 2013 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” шийдвэрийг гаргасан;
- ◆ СЗХ-ны 2013 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 93 дугаар тогтоолоор “СЗХ-ны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан журам”-д өөрчлөлт орсон. СЗХ-ны 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 102 дугаар тогтоолоор “СЗХ-ны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан;
- ◆ СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 172 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг хүчингүй болгосон өөрчлөлт оруулсан;
- ◆ “СЗХ-ны 2011 оны 331 дүгээр тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д өөрчлөлт орсон. СЗХ-

ны 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор “Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага”-ыг хавсралтаар шинэчлэн баталсан;

- ◆ СЗХ-ны 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 198 дугаар тогтоолоор “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг баталсан;
- ◆ СЗХ-ны 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг гаргасан;
- ◆ СЗХ-ны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг шинэчлэн батлах тухай, СЗХ-ны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 250 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг батлах тухай шийдвэр гаргасан.

### **Банк бус санхүүгийн байгууллага**

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх чиглэлээр анхаарал хандуулан ажиллаж байна. 2013 онд уг хуулийн төсөлтэй холбогдуулан СЗХ-ны Ажлын албаны даргын 69 дүгээр тушаалаар Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтарсан ажлын хэсэг байгуулж, улмаар хуулийн хамтарсан хэлэлцүүлгийг 2013 оны 4

дүгээр сард үр дүнтэй зохион байгуулан ажиллалаа.

Түүнчлэн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, зааврыг боловсронгуй болгох чиглэлээр “Банк бус үйл ажиллагааны зохицуулалтын журам”, “Банк бус санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар, банк бус санхүүгийн байгууллагын дансны жагсаалт болон банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягт”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-уудад нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

#### **Хадгаламж, зээлийн хоршоо**

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 онд батлагдсантай холбогдуулан 2012 онд тус хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн холбогдох заавар журмуудыг шинэчлэх болон шинээр батлуулан ажиллахад ихээхэн чармайлт гарган ажиллаж байсан.

2013 оны тухайд ядуурлыг бууруулах Японы Сангийн буцалтгүй тусламжтайгаар Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хадгаламж, зээлийн хоршоодыг чадавхижуулах чиглэлээр СЗХ олон улсын зөвлөхүүдтэй хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаатай холбогдсон журам, зааврын талаар харилцан санал солилцон ажиллахын зэрэгцээ цаашид зөвлөхүүдээс өгсөн зөвлөмжид үндэслэн журам, заавруудад шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

2013 онд төлөвлөгдсөн ажлын дагуу 2012 онд Сангийн сайд болон СЗХ-ны даргын

хамтарсан тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, санхүүгийн тайлангийн маягт” шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар”-ыг тус тус шинэчлэн баталлаа.

#### **Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа**

Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК нь Төрийн өмчийн хорооны 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдсан ба бирж 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс зарим нэр төрлийн түүхий эдийг шууд арилжих гэрээний төрлөөр арилжаалж эхлээд байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч(брокер)-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ыг баталж эхний хагас жил хүртэлх хугацаанд нийт 33 компанид тусгай зөвшөөрөл олгов.

СЗХ-ны 2013 оны 7 дугаар сарын 17-ны 264 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн түр журам”-ыг баталсан.

Мөн Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчидтой холбоотой дараах шийдвэрүүдийг гарган мөрдүүлж байна. Тухайлбал:

- ◆ СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 24-ны 180 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч(брокер)-ийн

- үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээг тогтоосон;
- ◆ СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 10-ны 155 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч(брокер)-аас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон;
- ◆ СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 10-ны 148 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч(брокер)-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан;
- ◆ СЗХ-ны 2013 оны 6 дугаар сарын 12-ны 216 дугаар тогтоол, 2013 оны 7 дугаар сарын 17-ны 265 дугаар тогтоолуудаар нэр

бүхий 26 компанид хонины ноос гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нэмж олгосон;

- ◆ Биржийн арилжааны танхимын суудлын хүрэлцээ хангалтгүй буюу 32 суудлын тоо дууссанаас хамаарч СЗХ-ны 2013 оны 7 дугаар сарын 17-ны 266 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авахыг түр зогсоосон.

## 5.2 ТӨЛБӨР ТООЦОО, ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

### Их дүнтэй төлбөр тооцооны систем

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны Банксүлжээ системээр бодит цагийн горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцооны системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, заавал байлгах нөөцийг хангуулах боломжийг бүрдүүлдэг.


Их дүнтэй төлбөр тооцооны системээр банк хоорондын төлбөр тооцоо, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцоо, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн төлбөр тооцоог нэг бүрчлэн бодит цагаар гүйцэтгэж, үр дүнг тооцож байна. Түүнчлэн бага дүнтэй төлбөр тооцооны системийн үр дүнгийн тооцооллыг хааж, оролцогчийн Монголбанк дахь харилцах дансанд тусгадаг.

2008-2012 онуудад төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 96-98 орчим хувь, гүйлгээний тооны 12-14 орчим хувийг их

дүнтэй төлбөр тооцооны системээр дамжуулж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар дүнгийн 99.2, тооны 13.1 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд энэхүү систем нь банк, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн тогтвортой байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

### Дүрслэл 4.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт




Эх сурвалж: Монголбанк.

## Бага дүнтэй төлбөр тооцооны систем

Үндэсний цахим гүйлгээний төв<sup>15</sup> нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээ, Сангийн яамны Төрийн сангийн газрын бага дүнтэй гүйлгээ, банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг цэвэршүүлж, Банксүлжээ системээр дамжуулан банкны харилцах дансанд тусгадаг.

## Дүрслэл 4.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.

Бага дүнтэй төлбөр тооцоо нь 2008-2012 онуудад төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 2-4 орчим хувь, гүйлгээний тооны 86-88 орчим хувийг тус тус эзэлж байсан бол 2013 оны эхний хагас жилийн байдлаар дүнгийн 0.8, тооны 86.9 хувийг эзэлж байна. Энэхүү систем нь олон тооны хэрэглэгчийг хамарч байдаг тул түүний найдвартай, тасралтгүй ажиллагаа нь харилцагчийн банкинд итгэх итгэлд ихээхэн нөлөө үзүүлж байдаг.

Бага дүнтэй гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлтээс үзэхэд гүйлгээний тоо, дүн 2011 оноос огцом нэмэгдсэн нь картын нэгдсэн сүлжээг 2010 онд нэвтрүүлсэнтэй холбоотой юм. ҮЦГТ-ийн гүйлгээ 2008 онд 1 тэрбум төгрөгийн 7.4 мянган ширхэг байсан бол 2013 оны эхний хагас жилд нэг өдөрт дунджаар 3 тэрбум төгрөгийн 51.1 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ, 4.1 тэрбум төгрөгийн 86.5 мянган ширхэг картын гүйлгээг дамжуулдаг болсон байна.

<sup>15</sup> Монголбанкны Төлбөр тооцооны төвийн нэрийг 2012 онд Үндэсний цахим гүйлгээний төв болгон өөрчилсөн.



### Төлбөр тооцооны үндэсний зөвлөл

Монголбанкны санаачилгаар банк, санхүү, мэдээллийн технологийн болон төрийн бусад холбогдох байгууллагын төлөөллөөс бүрдсэн Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)-ийг 2008 онд байгуулсан. ТТҮЗ нь Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэхтэй холбоотойгоор Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг хэлэлцэж таниулах, холбогдох санал, зөвлөмж гаргах замаар төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, системийн үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилготой юм. Энэхүү зорилгын хүрээнд Монголбанкнаас санаачлан боловсруулсан “Монгол Улсын төлбөр тооцооны системийг хөгжүүлэх дунд хугацааны (2009-2014) стратеги”-ийг ТТҮЗ-ийн анхны хуралдаанаар баталсан. Монголбанк нь ТТҮЗ-ийн хуралдааныг жилд 2 удаа тогтмол зохион байгуулж, төлбөрийн системийг хөгжүүлэх чухал асуудлуудыг хэлэлцүүлж, шийдвэрлэж байдаг.

ТТҮЗ-ийн ээлжит XI хуралдааныг 2013 оны эхний хагас жилд Монголбанкнаас зохион байгуулсан. Уг хуралдаанаар Монголбанкнаас АХБ-тай хамтран хэрэгжүүлсэн Мобайл банкны үйлчилгээний эрх зүйн орчинг төлөвшүүлэх төслийн хүрээнд боловсруулан гаргасан Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого болон холбогдох журмын төслийн танилцуулгыг гишүүдэд хийсэн.

Энэхүү бодлого, зохицуулалтыг бий болгох нь мэдээллийн технологийн хөгжил, дэвшлийг ашиглаж, иргэдэд банкны болон төлбөр тооцооны үйлчилгээг хямд зардлаар, түргэн шуурхай хүргэх, төлбөр тооцооны шинэ хэлбэрийг хөгжүүлэх чухал алхам болсон юм.

### Төлбөрийн системийн хяналт

Төлбөр системийн оператор болон оролцогчдын төлбөр тооцооны системийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, бууруулах, төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг баталгаажуулах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төлбөрийн системийн хяналтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, гүйцэтгэж байна.

Энэхүү зорилгын хүрээнд Монголбанк нь төлбөрийн системийн оролцогчдод төлбөрийн шинэ хэрэгсэл, үйлчилгээ нэвтрүүлэх үйл ажиллагааны зөвшөөрлийг олгох, зөвшөөрөлгүйгээр эрхэлж буй төлбөр тооцооны үйл ажиллагааг илрүүлэн шалгаж, холбогдох арга хэмжээ авч ажилласан. Карт эзэмшигч, хэрэглэгчдийн эрх ашгийг

хамгаалах, бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд 2013 оны эхний хагас жилийн байдлаар 12 банкинд 7 нэр төрлийн төлбөрийн картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон бөгөөд төлбөрийн картын олон улсын стандарт болон “Төлбөрийн картын журам”-ын холбогдох шаардлагыг хангуулан ажиллаж байна. Төлбөрийн системийн оролцогчийн ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжийн програмчлал болон зөвшөөрлийн хүрээнээс гадуур эрхэлж буй үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоон, мэдэгдэл хүргүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авлаа.

Төлбөрийн системийн техник, технологи, хэвийн үйл ажиллагаанд гэнэтийн осол,

гамшиг, програм хангамжид алдаа, саатал үүсэх үед системийн үйл ажиллагааг тасралтгүйгээр явуулах, үйл ажиллагааг нөөц төв рүү шилжүүлэх, хэвийн горимд буцаан шилжүүлэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний туршилтыг “Банксүлжээ” систем дээр хийж гүйцэтгэсэн.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан зөвлөмжийн дагуу төлбөрийн

системийг бүхэлд нь болон оролцогч нэг бүрээр үнэлэх аргачлалын бичиг баримтыг боловсруулж байгаа ба энэхүү аргачлалыг системийн хэмжээнд мөрдөн ажилласнаар эрсдэлийг урьдчилан харж, нарийвчлан үнэлгээ хийх шаардлагатай хэсгийг тодорхойлж, төлбөрийн системийн бүтэц, үйл ажиллагаа нь бодлого, зарчмын дагуу явагдаж байгаа эсэхийг тогтоох боломжтой болох юм.

### Үнэт цаасны төлбөр тооцоо

СЗХ-ноос 2013 оны эхний хагас жилд бодлого, зохицуулалтын чиглэлээр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга болон төслийн анхны хувилбар, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж ажиллав.

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 171 дүгээр тушаалаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагуу боловсруулах журмын жагсаалтыг” батлан нийт 22 журмыг боловсруулахаар ажиллаж байна.

Тайлант хугацаанд зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, системийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах ажлууд хийгдэв. Үүнд:

- ◆ Нэг дансаар өөрөө өөртэйгөө арилжаа хийдгийг зогсоосон;
- ◆ Дансны давхардлыг арилгуулсан;
- ◆ Данс нээгдээгүй иргэдийн дансыг нээлгэсэн;
- ◆ Зөрчилтэй, чанаргүй үнэт цаасны арилжааг зогсоон шалгаад зарим бүртгэлийн шаардлага хангахгүй компанийн асуудлыг нэг мөр шийдвэрлэсэн;
- ◆ Нэгдсэн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн;
- ◆ Мэргэжлийн оролцогчдын талаарх мэдээллийн нэгдсэн санг үе шаттайгаар шинэчилсэн;
- ◆ Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулсан зэрэг юм.

### 4.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төвбанкны тухай хууль болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл(Зөвлөл)-ийн ажиллах дүрэмд заасны дагуу Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан юм. Тухайлбал, 2013 оны 2 дугаар сарын 19, 9 дүгээр сарын 25, 10 дугаар сарын 4-ний өдөр тус тус хуралдаад байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2013.02.19-ний өдрийн хуралдаанаар санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд санал боловсруулах, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба (СТБЗАА)-ыг Монголбанкинд төвлөрүүлж, 5 хүний орон тоотой ажиллуулахаар болсон. Харин 2013 оны 9 дүгээр сарын 25, 10 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 баримлах үндсэн чиглэлийн төсөл, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих хөтөлбөр”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотойгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төсөл зэрэг асуудлуудыг авч хэлэлцэж, хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгч,

холбогдох газруудад санал, зөвлөмж хүргэн ажиллаж байна.

Сангийн яаманд Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа MSTAP төслийн хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, түүний ажлын албаны чадавхийг сайжруулах чиглэлээр гадаадын ба дотоодын зөвлөхийг тус зөвлөлийн Ажлын албатай хамтран ажиллуулав. Энэ хүрээнд санхүүгийн тогтвортой байдлын асуудал эрхэлсэн институцийн хэм хэмжээ, бусад орны сайн туршлага, санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд өгөх үнэлгээ дүгнэлт, бодлогын болон техникийн түвшинд учирч буй асуудлууд зэрэг өргөн хүрээг хамарсан эхний шатны тайлан гарч, Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороог хамарсан хоёр удаагийн семинарыг зохион байгууллаа.

СТБЗАА нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээлэл хүлээн авч, “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан-2012” буюу анхны дугаарыг нэгтгэн боловсруулж, хэвлүүлэн, цахим хуудаст байршуулж, олон нийтийн хүртээл болгосон бөгөөд ийнхүү хоёрдахь дугаарыг та бүхний гарт хүргэж байна.